

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КӨМИСС
“ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЧАДАВХИЙГ
ДЭЭШЛҮҮЛЭХ” ТӨСӨЛ

**“Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан
хийх эрхийн төлөв байдал, цаашид
боловсронгуй болгох асуудал”
сэдэвт судалгааны
тайлан**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот, 2004 он

**“Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрхийн төлөв байдал, цаашид боловсронгуй болгох асуудал” сэдэвт судалгааны тайлан
(1989-2003 он)**

Нэг.Судалгааны зорилго

1.1.Монгол Улсад 1989-2003 оны /сүүлийн 14 жилд/ хооронд зохион байгуулагдсан тайван жагсаал, цуглааны талаар мэдээлэл цуглуулж, жагсаал, цуглаан хийх эрхийн төлөв байдлыг тодорхойлон, түүний эрх зүйн орчныг судлан зохих дүгнэлт хийж тайлан боловсруулан тодорхой санал, зөвлөмж гаргах нь энэхүү судалгааны эрхэм зорилго болно.

Судалгааны баг 1989-2003 оны 12 сарын 31 хүртэл /сүүлийн 14 жилд/ хугацаанд Монгол Улсын аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны талаар мэдээллийн сан бүрдүүлэх,

- Жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилтийн талаар эрдэмтэн, судлаач, улс төрчид болон олон нийтийн бодол саналыг тусгасан хэвлэл мэдээллийн тоймыг судлах, дүгнэх, мэдээллийн сан /жагсаалт/ бүрдүүлэх,

- Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хэрэгжилтийн талаар өмнө нь хийгдсэн судалгааны тайлан, статистик, тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийх,

- Монгол Улсын хүний эрхийн олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд жагсаал, цуглаан хийх эрхийн талаар харьцуулсан судалгаа хийх,

- Жагсаал, цуглаан хийх эрхтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны талаар судалгаа хийж, шүүхийн практикийг судлан шүүхийн шийдвэрийн талаарх мэдээллийг эмхтгэн нэгтгэх,

- Жагсаал, цуглаан хийхэд өгдөг урьдчилсан зөвшөөрлийн талаар холбогдох

байгууллагын удирдах хүмүүс, жагсаал, цуглаан зохион байгуулагчдын төлөөлөгч, олон нийтийн байгууллагын холбогдох хүмүүстэй уулзаж, санал солилцох,

- Олон Улсын гэрээ, конвенц, түүний ерөнхий зөвлөмж, нэгдэж орсон орнуудын

холбогдох тайлбарыг үндэсний хууль тогтоомжид заасан нөхцөл, заалттай харьцуулан судлах,

- Эцэст нь нэгдсэн тайлан бичиж Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгч, уг эрхийг хангах эрх зүйн баталгааг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмжийг бэлтгэх зорилт тавьсан юм.

Хоёр.Судалсан байдал ба судалгааны арга зүй

2.1.Бид судалгааны ажлын төлөвлөгөө ёсоор судалгааны явцад дор дурьдсан мэдээллийг цуглуулж, дараахь байдлаар судлан үзсэн болно.

2.1.1.Монгол Улсад 1989-2003 оны хооронд зохион байгуулагдсан жагсаал, цуглааны талаар Монгол Улсад хүний эрхийг хангах төсөл, ХЭҮК-ын аймаг дахь итгэмжлэгдсэн төлөөлөгч нартай хамтран, тэдний туслалцаа дэмжлэгтэйгээр Монгол улсын 21 аймгийг хамарсан судалгаа хийж;

2.1.2.Чингэлтэй дүүргийн Засаг даргын 1992, 1993, 1994, 1995, 1996, 1997, 1998, 1999 оны захирамж, Улаанбаатар хотын Сүхбаатарын районы АДХГЗ-ны /Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа/ 1989, 1990, 1991, 1992 оны тогтоол, нийслэлийн Сүхбаатар дүүргийн засаг даргын 1993, 1994, 1995, 1997, 1999 оны захирамж, Улаанбаатар хотын Октябрийн районы АДХГЗ-ийн 1989, 1990, 1992 оны тогтоол, Баянгол дүүргийн засаг даргын 1993 оны “А”, “Б” захирамж, 1994, 1996 оны “А” захирамж, Улаанбаатар хотын АДХТ-ийн /Ардын депутатуудын хурлын тэргүүлэгчид/ 1989 оны тогтоол, Улаанбаатар хотын АХГЗ-ны /Ардын хурлын гүйцэтгэх захиргаа/ 1989-1996 оны тогтоол, Нийслэл дэхь хүний эрхийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн оролцоотойгоор нийслэлийн засаг даргын тамгын газрын 1998-2002, Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газрын 1998-2003, Сүхбаатар дүүргийн засаг даргын 1998-2003 онд явуулсан албан бичгийн бүртгэл, жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл олгосон болон татгалзсан шийдвэрийг судлан Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан жагсаал, цуглаантай холбоотой мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж;

2.1.3.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн 1994-2003 онд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай захиргааны шийтгэвэр, 2003 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шийдвэр, Сүхбаатар дүүргийн шүүхийн 1992-2003 онд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай захиргааны шийтгэвэр, 2003 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шийдвэр зэргийг судлан;

2.1.4.1989-2003 оны хооронд гарсан “Үнэн” сонин, “Ардын эрх”, “Засгийн газрын мэдээ”, “Өнөөдөр”, “Монголын мэдээ”, “Өдрийн сонин” зэрэг өдөр тутмын тогтмол хэвлэлд жагсаал, цуглаантай холбоотой, мөн өлсгөлөн зарлах, суулт хийх зэрэг үзэл бодлоо

илэрхийлэх эрхтэй холбоотой олон нийтийн бодол саналыг тусгасан мэдээллийн /мэдээ, тойм, эргэцүүлэл, ярилцлага гэх мэт/ тоймыг судлан дүн шинжилгээ хийн;

2.1.5. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хэрэгжилтийн талаар 2001 онд Монгол Улсад хүний эрхийг хангах төслийн хүрээнд хийгдсэн “Улс төр болон хувийн эрхийн судалгааны тайлан”-д жагсаал, цуглаан хийх эрхийн төлөв байдлыг судлан үзсэн байдалд дүн шинжилгээ хийж;

2.1.6. Монгол Улсын хүний эрхийн олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд жагсаал, цуглаан хийх эрхийн талаар, Монгол Улсын Олон Улсын гэрээ, конвенц, НҮБ-ын Хүний Эрхийн хорооны зөвлөмж зэргийг үндэсний хууль тогтоомжид заасан нөхцөл, заалттай харьцуулан судлан;

2.1.7. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийн талаарх Олон улсын жишиг, стандартыг судлах хүрээнд НҮБ-ын хүний эрхийн хорооны зөвлөмж, Йоханнесбургийн зарчим баримт бичгийг судлан;

2.1.8. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хувийн хэрэг /№75, 1994 он/, уг хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэл /1, 2-р хэлэлцүүлэг, 1994 он/ зэргийг судлан;

2.1.9. Жагсаал, цуглаан хийхэд өгдөг урьдчилсан зөвшөөрөл болон бусад асуудлаар холбогдох байгууллагын удирдах хүмүүс, жагсаал, цуглаан зохион байгуулагчдын төлөөлөгч, олон нийтийн байгууллагын холбогдох хүмүүсийг оролцуулан “Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө” сэдэвт уулзалт ярилцлага зохиож, санал солилцон, санал асуулга явуулж;

2. 2. Энэхүү судалгааны тайланг боловсруулсан болно.

Гурав. Сэдвийн судлагдсан байдал

Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн орчны талаар дагнан хийсэн судалгаа, шинжилгээний бүтээл харьцангуй цөөн байгаа нь судалгааг хийх явцад харагдаж байв. Монгол Улсад хүний эрхийг хангах төслөөс 2001 онд Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлын судалгааг хийжээ. Энэхүү судалгааны хамтлагийн улс төр болон хувийн эрхийн тусгай баг тайван жагсаал, цуглаан хийх эрхийн¹ талаар судлан үзсэн байна.

Энэ судалгааны зарим үр дүнгээс дурьдвал:

¹ Монгол улсад хүний эрхийг хангах төсөл, Улс төр болон хувийн эрхийн судалгааны тайлан, 2001 он, 123-126-р талд

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19 дэх хэсэгт: “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч зөвшөөрөл авна.” гээд мөн зүйлийн 3 дахь хэсэгт: “Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 өдрийн дотор түүнийг зөвшөөрсөн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.” гэж заажээ. Энэ заалтад жагсаал, цуглааныг зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэх хугацаа /ажлын 6 өдөр/ хэт удаан байхаар тусгасны хамт ийнхүү зөвшөөрсөн эсэхээ заавал бичгээр мэдэгдэхийг онцолсон нь Үндсэн хуулиар тодорхойлсон эрхээ хэрэгжүүлэх гэсэн хүмүүст чирэгдэл учруулах, хориг саад хийх, цаг нөхцөөх гэсэн хандлага ажиглагдаж байна.

2. Хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: “Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно” гэж заажээ. Энэ нь төр, засгийн дээд өндөрлөгүүд байрладаг Төрийн ордны аюулгүй байдлыг хангах талаасаа зөв зүйтэй боловч уг талбайд янз бүрийн баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах асуудал чөлөөтэй байгаагаас үзэхэд тэгш эрхийн зарчмын үүднээс зохимжгүй байгаа нь ажиглагдаж байна.

3. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7, 9 дүгээр зүйлийн холбогдох заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 31 дүгээр тогтоол, түүгээр батлагдсан журмыг хүний эрхийг хязгаарлахгүй талаас нь эргэж харж үзэх шаардлагатай” гэж дүгнэсэн нь “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-ийг эргэн харж нягтлах, цаашид боловсронгуй болгож сайжруулах зүйл багагүй байгааг судалгааны үр дүн харуулжээ.

Дөрөв. Судалгааны тайлангийн бүтэц

Энэхүү судалгааны тайлан дараахь бүтэцтэй болно. Үүнд:

I хэсэг. Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан /1989-2003 он/

II хэсэг. Тайван жагсаал, цуглаан хийх эрх түүний эрх зүйн орчины талаарх судалгаа

III хэсэг. Олон нийтийн санал бодлыг судалсан тухай тайлан

Дүгнэлт, санал, зөвлөмж

Товчилсон үгийн тайлал

Хавсралт-1, 2, 3, 4



Тав. Судалгааны баг

Энэхүү судалгааны багийн ахлагчаар ХЭҮК-ын үндэсний зөвлөх, ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Д.Оросоо, багийн гишүүнээр социологч Г.Соёл-Эрдэнэ, хуульч Л.Баттөмөр, ХЭҮК-ын нийслэл дэхь итгэмжлэгдсэн төлөөлөгч, Хүний эрхийг хангах төслийн нийслэлийн хүний эрхийн мэргэжилтэн, хууль зүйн магистр Г.Сувд-Эрдэнэ, М.Баянжаргал, судалгааны ажилд ХЭҮК, Хүний эрхийг хангах төслийн Булган, Өвөрхангай, Баян-Өлгий, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг дахь хүний эрхийн мэргэжилтэн Д.Баяраа, Ш.Бямбаа,

"Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрхийн төлөв байдал, цаашид боловсронгуй болгох асуудал" сэдэвт судалгааны тайлан

Алмагүль, Борчулуун, Н.Цэрэннадмид нарын тэргүүтэй аймгууд дахь хүний эрхийн мэргэжилтэн нар оролцов.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

I хэсэг

Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан (1989-2003 он)

Нэг.Аймаг, нийслэл дэхь тайван жагсаал, цуглаан

Бидний судлан үзсэнээр 1998-2003 оны хооронд Нийслэл болон Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул дүүргийн Засаг Даргын тамгын газарт иргэд, байгууллагаас жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл хүссэн 165 хүсэлт ирүүлжээ. Үүний 141 хүсэлтэд жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл олгож, 21 хүсэлтэд зөвшөөрөл олгохоос татгалзсан байна. /хүснэгт-1/ Харин үлдсэн 3 хүсэлтийн 1 хүсэлт гаргачийн тухайд зөвшөөрөл олгосон эсэх нь тодорхойгүй, 2 хүсэлтийн тухайд зөвшөөрөл хүсэгч эргэж холбогдон хариу аваагүй, мөн харьяалалын бус гэдэг шалтгаанаар зөвшөөрөл аваагүй бол энэ хугацаанд 3 удаа зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан зохион байгуулагдсан байна. Үүний 2 жагсаал, цуглааныг албадан тараажээ. Үүнд, СБД-ийн Засаг даргын 2002 оны 11 сарын 12-ны өдрийн №327 тоот захирамжаар албадан тараасан жагсаал, цуглаан орно. Захирамжаар “МоАХ-ноос хөдөө аж ахуйн машин механизм ашиглан хийж байгаа жагсаал, цуглааныг зохион байгуулагчидад “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-ийн заалтыг байнга зөрчсөнийг сануулан удаа дараа мэдэгдэл өгсөн боловч 2002 оны 11 сарын 5, 12-ны өдөр хуулиар хориглосон газар болох Д.Сүхбаатарын талбайд зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулж, тараахыг шаардсан албан мэдэгдлийг эс биелүүлсэн тул мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн жагсаал, цуглаанд оролцож буй хүн, тээврийн хэрэгсэл, хөдөө аж ахуйн машин механизмыг албадан тараахаар шийдвэрлэсүгэй, албадан тараах ажлыг 2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 19 цаг 16 минутаас эхлэн хуульд заасны дагуу зохион байгуулах тухай” заасан бол удаах нь 2003 оны 11 сарын 30-ны өдөр болсон ХААИС-ийн 800-900 орчим оюутан оролцсон, Нийслэлийн Засаг Дарга болон Нийслэлийн зам тээврийн газарт хандан ХААИС-ийн 1500-аад оюутан автобусны билетгүй хоцорсноос үүдэлтэйгээр оюутны хөнгөлөлтийн билетийг хангалттай тоогоор хэвлүүлэх шаардлага тавьж зөвшөөрөл авалгүй зохион байгуулсан жагсаал, цуглааныг албадан тараажээ.

Түүнчлэн бид Монгол Улсын 21 аймаг дахь ХЭҮК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн туслалцаатайгаар аймгуудад судалгааны ажил хийсэн бөгөөд нийт 18 аймгаас ирүүлсэн судалгааны материалыг энд нэгтгэн дүгнэсэн болно. Судалгаанд хамрагдсан Монгол Улсын 18 аймагт 1989-2003 оны хооронд 160 тайван жагсаал, цуглаан болсон байна. Үүний 21 нь 1989-1991 оны хооронд зохион байгуулагджээ. /хүснэгт-2/ Гэхдээ үүнийг бодитой тоо гэж үзэх боломжгүй юм. Учир нь тухайн үед зохион байгуулагдаж байсан жагсаал, цуглаантай холбоотой бүртгэл, мэдээ материал судалгааны явцад хангалттай түвшинд олдоогүй болно.

Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл, Монгол Улсад 1998-2003 онд Нийслэл, дүүрэгт зохион байгуулагдсан 143 /хавсралт-1/, 1989-2003 онд 18 аймагт болсон 160 /хавсралт-2/, нийт 301 тайван жагсаал, цуглаан болжээ.

Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-1, Нийслэл, дүүрэг дэхь тайван жагсаал, цуглаан /1998-2003 он/

№	Нэрс	Зөвшөөрөл хүссэн хүсэлтийн тоо	Үүнээс:			Зөвшөөрөлгүй хийсэн
			Олгосон	Татгалзсан	Бусад	
1.	НЗДТГ	58	50	8		
2.	СБД-ийн ЗДТГ	53	47	6		1
3.	ЧД-ийн ЗДТГ	51	41	7	3	
4.	БГД-ийн ЗДТГ	1	1			
5.	ХУД-ийн ЗДТГ	2	2			1
6.	БЗД-ийн ЗДТГ					1
	Бүгд	165	141	21	3	2

Хүснэгт-2, Аймаг дахь тайван жагсаал, цуглаан /1989-2003 он/

№	Аймгуудын нэрс	Нийт зохион байгуулагдсан жагсаал, цуглааны тоо	Үүнээс			Зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийн тоо	Албадан тараасан жагсаал, цуглааны тоо	Талбайн нэр
			Зөвшөөрөлтэй хийсэн	Зөвшөөрөлгүй хийсэн	1989-1991 онд хийгдсэн			
1.	Төв	16	13	2	1	2	2	“Мөнх алдар”-ын талбай
2.	Сүхбаатар	7	3	-	4			Сүхбаатарын хөшөөтэй талбай
3.	Булган	5	3	-	2			-Төв талбай /Улсын баатар Лхагвадорж/ -Чин ван Ханддоржийн талбай
4.	Өмнөговь	51	50	-	1			-Т.Борын нэрэмжит талбай, -Улсын Арслан Дэмүүлийн нэрэмжит талбай
5.	Дархан-Уул	3	1	1	1			Найрамдлын талбай
6.	Дорноговь	1	1					Төв талбай
7.	Баянхонгор	6	5	-	1			“Баганат” талбай
8.	Баян-Өлгий	17	15	2	-	2	2	Төв талбай /Партизануудын дурсгалд зориулсан/
9.	Завхан	6	5	-	1			Аймгийн ЗДТГ, МАХН-ын хооронд байрлах талбай
10.	Архангай	20	20	-	-			“Дэмид жанжин”-ны талбай
11.	Дорнод	2	-	1	1			Хүүхдийн төвийн урд байрлах талбай

12.	Өвөрхангай	2	2	-	-	2		“Аюуш Баатар”-ын талбай
13.	Дундговь	3	-	-	3			Сүхбаатарын талбай
14.	Ховд	2	1	-	1			“Ард Аюуш”-ийн талбай
15.	Сэлэнгэ	12	10	2	-			Партизаны талбай
16.	Хөвсгөл	2	1	-	1			С.Даваадоржийн талбай
17.	Говь-Алтай	4	-	-	4			-
18.	Увс	1	1	-	-			Ю.Цэдэнбалын талбай
	Бүгд	160	131	8	21	6	4	

Анхны ардчилсан жагсаал, цуглаанууд

Монгол Улсад зохион байгуулагдсан анхны ардчилсан цуглаан бол 1989 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Ховд аймгийн Ард Аюушийн талбайд болжээ. Энэ нь үндсэндээ Ховд аймгийн УБДС-ийн оюутнуудын санаачилсан жагсаал, цуглаан байсан бөгөөд түүнд багш нар зохих үүрэг ролийг гүйцэтгэсэн байдаг.

“Уг цуглаанд ХоУБДС-ийн 250 гаруй оюутан, багш болон үйл ажиллагааг дэмжсэн ба сонирхсон Ховд хотын зарим иргэд, хөдөлмөрчид оролцжээ. Уг цуглаанд нийт 13 орчим хүн санал бодлоо илэрхийлжээ. Үүнд: ХоУБДС-ийн багш Ц.Одонхүү, Ц.Мөнхтөмөр, Х.Батзангиа, Ө.Батцоож, Эрдэнэцогт, С.Энхбаяр, оюутан С.Эрдэнэцогт, Лхагвасүрэн нарын олон хүн үг хэлэв.

Ийнхүү оюутнууд сургуулийн захиргаа болон зарим хүмүүсээс тэдний үйл ажиллагаанд ихээхэн хориг саад тавьж байсан боловч зорьсондоо хүрч, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоог бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохыг шаардсан өргөх бичгээ, бэлэгдэл бүхий хогийн шүүрийн хамт аймгийн намын хорооны бүгд хурлын төлөөлөгчдөд өргөн барьжээ. Тэд уг шаардлагыг дээд удирдлагууд руу явуулж өгөхөөр болжээ.

Ардчилсан цуглааны орой нь аймгийн намын хорооны товчоо хуралдаж, тус хурал дээр сургуулийн ректор Н.Жадамбыг эмх замбараагүй байдал үүсгэж, төр засгийн эсрэг үйл ажиллагаа явуулсан оюутны үйл ажиллагааг таслан зогсоож чадаагүй тухай хэлэлцэхэд тэрээр “БНМАУ-ын Үндсэн хуульд зааснаар манай оюутнууд жагсаал, цуглаан хийж хүслээ илэрхийлэх эрхтэй. Үүнд бид бүхэн эмзэглэх эрх байхгүй.” гэж хэлж байжээ.”²

Үүнээс хойш 3 хоногийн дараа буюу 1989 оны 12 дугаар сарын 10-нд Нийслэлийн Залуучуудын төвийн өмнөх талбайд МоАХ анхны цуглаанаа зохион байгуулсан бөгөөд уг цуглаанд 200 орчим хүн оролцсон байдаг. Цуглаанд оролцсон хүмүүс “Хэвлэлийн эрх чөлөө”, “Эрх зүйт төрийн төлөө”, “Хүний эрхийг дээд зэргээр эрхэмлээ” гэх зэрэг уриа, лоозон барьж, “Хонх” хамтлагийн дуучин С.Цогтсайхан, Н.Энхбаяр нар “Хонхны дуу” хэмээх дуугаа дуулжээ.

“Тус цуглаан дээр Монголын Ардчилсан Холбоо байгуулагдсаныг албан ёсоор зарлаж, МАХН-ын Төв Хорооны 7 дугаар бүгд хурал, БНМАУ-ын АИХ-ын Чуулганд өргөн

² МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, Б.Нямдорж, Л.Нямсүрэн. “Хөдөөгийн ууган их сургууль-20 жилд”, /1979-1999/, УБ, 2001 он, 43-46 дахь тал

барих бичиг барьсан нь түүхэнд анх удаа зохион байгуулалтай улс төрийн хүчнээс эрх баригчдад тавьсан анхны улс төрийн шаардлага гэж түүхэнд үлдэх билээ.

МАХН-ын тус бүрд хурлын дараа 1989 оны 12 дугаар сарын 17-нд ДБУАТ-ын өмнөх талбайд болсон МоАХ-ны хоёр дахь цуглаанд 2000 орчим хүн, 1990 оны 1 дүгээр сарын 14-нд Лениний музейн өмнөх талбайд болсон МоАХ-ны гурав дахь цуглаанд 10.000 орчим хүн, мөн оны 1 дүгээр сарын 21-нд Сүхбаатарын талбай дээр болсон цуглаанд 20.000 гаруй хүн, 2 дугаар сарын 11-нд Лениний музейн өмнөх талбайд болсон МоАХ-ны тав дахь цуглаанд 30.000 гаруй хүн оролцжээ.³

Зөвшөөрөл ба татгалзал

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг цуглаан, энэхүү асуудлаар хот суурингийн гудамж, талбайгаар зохион байгуулалтайгаар жагсан явж үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг жагсаал гэж ойлгодог.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно.” гэж заажээ. Өөрөөр хэлбэл Сүхбаатарын талбай дээр дурьдсан асуудлаар жагсаал, цуглаан хийх нь хориотой гэсэн үг юм.

Уг нь үзэл бодлын илэрхийлэлийг хөндөн буй асуудлын агуулга, сэдэв, хүрээгээр нь ялгаварлах ёсгүй билээ.

Гэтэл НЗДТГ болон СБД-ийн Засаг дарга “улс төр”, “эдийн засаг”, “хүний эрх, эрх чөлөө”-тэй холбоотой зарим нэг жагсаал, цуглаанд зөвшөөрөл олгосон нь эргэлзээ төрүүлж байна.

Учир нь улс төр, эдийн засаг, нийгэмтэй холбоотой асуудлаар Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан зохион байгуулах нь чөлөөтэй байх учиртай ч үүнийг хуулиар хориглосон байдаг. Иргэд дурьдсан асуудлаар уг талбай дээр жагсаал, цуглаан зохион байгуулах хүсэлт гаргахад хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлан зөвшөөрөл олгохоос татгалздаг тодорхой.

Нөгөө талаас энэхүү зөвшөөрөл олгосон жагсаал, цуглаан нь улс төр, хүний эрх, эрх чөлөө, эдийн засагтай холбоотой асуудлаар төр засагт хандан ямар нэг санал, шаардлага илэрхийлээгүй гэж маргаж болох. Гэвч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн төр засагт хандан санал, шаардлага тавьдаг гэж нэг утгаар ойлгож болохгүй. Хүн бүр үзэл бодлоо өөрийн сонгосон аргаар чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд илэрхийлэх арга, хэлбэр нь ямар ч байж болно, заавал төр засагт хандах шаардлага байхгүй. Тухайлбал, “Бүх нийтийн гүйлт”, “Зул өргөх ёслол”, “Бизнес фестиваль” зэрэг нь үзэл бодлын илэрхийлэл бөгөөд эдгээрийг үзэл бодлын илэрхийлэх биш гэж маргах аргагүй.

³ Х.Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989–1996), УБ., 1998 он, 21–29 дэхь талд.

Түүнчлэн жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар улс төр, эдийн засаг, нийгэм, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлаар зохион байгуулж байгаа спорт, урлаг, уран сайхан, баяр наадмын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээнд уг хууль үйлчилж, дурьдсан сэдэвтэй холбоогүй спорт, урлаг, уран сайхан, баяр наадмын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээнд уг хууль үйлчлэхгүй байхаар заасан /хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/, харин дурьдсан сэдэвтэй холбоогүй спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээнд “Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам”⁴ үйлчлэхээр уг журмын 1.3-ийн а-д заасан байдаг.

Хуульд заасан улс төр, эдийн засаг, нийгэм, хүний эрх, эрх чөлөө гэдэг бол өргөн хүрээтэй ойлголт, энэхүү томъёололоор бол ямар ч жагсаал, цуглаан улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй шууд болон шууд бус утгаар холбогдоно.

Хуулийн энэхүү заалт нь тухайн жагсаал, цуглааныг дурьдсан асуудалтай холбоотой, эсхүл холбоогүй гэж үзэн өөрийн үзэмжээр шийдвэр гаргах боломжыг захиргааны байгууллагад олгосон нь ийм шийдвэр гаргахад нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал, “Улс төр”-тэй холбоотой дор дурьдсан жагсаал, цуглаанд НЗДТГ зөвшөөрөл өгчээ. Үүнд:

1..МАХН-ын сан хөмрөг эрхлэх газар, сонгуулийн сурталчилгааны ажлын төгсгөлийн “Шоу” арга хэмжээ, Сүхбаатарын талбай, 2000 оны 5 сар;

2.Монголын Социал Демократ Намын сонгуулийн төв штаб, “Харилцан итгэж, хамтран бүтээе” сонгуулийн ёслолын арга хэмжээ;

3.Монголын Бүгд Найрамдах намын СБД-ийн хороо, УИХ-д нэр дэвшигчийг сурталчлах арга хэмжээ, Сүхбаатарын талбай, 2000 оны 6 сар;

“Хүний эрх, эрх чөлөө”-тэй холбоотой дор дурьдсан жагсаал, цуглаанд НЗДТГ, мөн СБД-ийн Засаг Дарга зөвшөөрөл өгсөн байна. Үүнд:

1.Зүүн Азийн эмэгтэйчүүдийн чуулганы зохион байгуулах комисс, “Эмэгтэйчүүд хүчирхийллийн эсрэг” сэдэвт цуглаан, Сүхбаатарын талбай, 1998 оны 8 сар;

2.Олон Улсын “Эмнэсти интернейшнл” байгууллагын Монголын Үндэсний зохицуулах хороо, хэлмэгдэгсдийг хүндэтгэх жагсаал, зул өгөх ёслол, Хэлмэгдэгсдийн музей, хөшөө, Сүхбаатарын талбай, 1998 оны 9 сар;

3.Олон Улсын “Эмнэсти интернейшнл” байгууллагын Монголын Үндэсний зохицуулах хороо, “Эдлэх эрхийнхээ төлөө” бүх нийтийн гүйлт, Сүхбаатарын талбай, 2001 оны 5 сар;

4.“21-р зууны Хөх Монгол төв”, “Шударга ёсыг тогтоох ард түмэн”-ний цуглаан, Сүхбаатарын талбай, 2002 оны 5 сар;

“Эдийн засаг”-тай холбоотой асуудлаар НЗДТГ дор дурьдсан байгууллагад зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

1.МХАҮТ, “Бизнес Фестиваль” зохион байгуулах ажиллагаа, Сүхбаатарын талбайн урд хэсэгт, 2002 оны 9 сар;

⁴ НИТХТ-ийн 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор батлагдсан.

• НЗДТГ болон СБД, ЧД-ийн Засаг дарга 1998-2003 онд тайван жагсаал, цуглаан хийхийг хүссэн 21 хүсэлтэд татгалзсан хариу өгчээ. Үүнд:

“Монголын Нэгдсэн Хөдөлгөөн”, “АПУ” ХК-ийн ҮЭ-ийн хороо, “Хохирогсдын түр хороо”, “Чөлөөт Залуучуудын Холбоо”, МоАХ, “Даяар Монгол хөдөлгөөн” зэрэг байгууллагын Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан хийх хүсэлтэд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т заасан “Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно.” гэснийг баримтлан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол “Дэлхийн энх тайвны эв нэгдлийн төлөөх гэр бүлийн Монголын холбоо”-ноос 2001 оны 5 дугаар сарын 27-нд зохион байгуулах “1000 гэр бүлийн баяр” нь Монголын хүүхдийн сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулах арга хэмжээтэй давхардаж байсан учир Д.Сүхбаатарын талбайд зөвшөөрөл өгөх боломжгүй гэж мэдэгдсэн байна. Ардчилсан намаас зохион байгуулах Засгийн газар, УИХ-д тавьсан шаардлагын хариуг олон нийтэд танилцуулах цуглааныг “Эрх чөлөө”-ний талбайд зохион байгуулах хүсэлтэд ЧД-ийн ЗДТГ-аас тус талбай дээр тоглоомын талбай байгуулсан учраас боломжгүй болох тухай хариу өгсөн нь хууль зүйн хувьд үндэслэлтэй байна.

• Харин зөвшөөрөл өгөхөөс татгалзсан хэд хэдэн шийдвэр нь хууль зүйн хувьд үндэслэл муутай байна. Үүнд:

1.НЗДТГ-аас хуульч залуучуудын “Сенатор” групп, “Эв нэгдэл” оюутны хөдөлгөөний 2002 оны 1 дүгээр сарын 13-нд “Төрийн дуулал эгшиглүүлэх” арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд явуулах тухай хүсэлтэд татгалзсан хариу өгчээ. Нийслэлийн ЗДТГ-аас хариу ирүүлсэн 2002 оны 1 дүгээр сарын 11-ны өдрийн №3/332 тоот албан бичигт “...зохион байгуулах гэж байгаа арга хэмжээний хөтөлбөртэй танилцаж, холбогдох байгууллага, албан тушаалтануудаас тодруулахад:

-Монгол Улсын Их Хурлын 2001 оны 73 дугаар тогтоолоор баталсан Үндсэн хуулийн 10 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах комиссын ойг тэмдэглэх төрийн ёслолын арга хэмжээний төлөвлөгөөнд танайхаас зохион байгуулах арга хэмжээ тусгагдаагүй байна.

-Мөн тус арга хэмжээ нь Үндсэн хуулийн 10 жилийн ойн баярын хурал, хүндэтгэлийн концертийн арга хэмжээтэй давхцаж байна.

-Энэ арга хэмжээнд оролцох их, дээд сургуулиудын удирдлага нь /төрийн далбаа гардан авах/ огт мэдээгүй байгаа бөгөөд сонсогчдын парад хийх талаар Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргын тушаал ч гараагүй байна.

-Хөтөлбөрт тусгагдсан Монголын радиогоор сүлд дууллыг орон даяар явуулах асуудлын талаар ч радиогийн удирдлагатай огт тохиролцоогүй байна.

Иймд Д.Сүхбаатарын талбайд уг арга хэмжээг зохион байгуулах зөвшөөрөл олгох боломжгүй гэдгийг мэдэгдье.” гэжээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлд 1.Шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогсоогдсон буюу татан буугдсан, эсхүл албан ёсны бүртгэлгүй улс төрийн нам, олон нийтийн байгууллага жагсаал, цуглаан

хийх мэдэгдэл гаргасан, 2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан газарт жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн бол, 3.Энэ хуулийн 8 дугаар зүйлээр хориглосон жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн бол зөвшөөрөл олгохоос татгалзах тухай заасан байдаг. Дүгнэн үзвэл, Хуульч залуучуудын “Сенатор” групп, “Эв нэгдэл” оюутны хөдөлгөөнөөс 2002 оны 1 дүгээр сарын 13-нд “Төрийн дуулал эгшиглүүлэх” арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахад хууль зүйн хувьд татгалзах үндэслэл байхгүй байна. НЗДТГ-аас зөвшөөрөл олгохоос татгалзсан энэхүү шийдвэр нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчжээ.

2.Монгол Улсын Их сургуулийн Спорт клубт арга хэмжээ зохион байгуулах зөвшөөрөл олгохоос татгалзсан тухай 2001 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №3/2103 тоот албан бичигт “танай байгууллагын 09 тоот албан бичгийг 2001 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авлаа. Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журмын 2 дугаар бүлгийн 2.1-д заасны дагуу зөвшөөрөл авах хүсэлтээ уг ажиллагаа эхлэхээс ажлын 7 өдрийн өмнө холбогдох байгууллагад өгч бичгээр зөвшөөрөл авах ёстой юм. Энэ журмын дагуу танай байгууллага цагийг нь тулгаж хүсэлтээ гаргаж ирүүлсэн тул 4 дүгээр сарын 29-ний 11 цагт уг ажиллагааг явуулах зөвшөөрөл олгох боломжгүй болохыг мэдэгдье.” гэжээ.

Энэхүү зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэл нь Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журмын 2.4-т заасан Засаг дарга зөвшөөрөл өгөхөөс татгалзах үндэслэлд хамаарахгүй юм. Энэ татгалзсан шийдвэр эрх зүйн үндэсгүй байна.

3.Ардчилсан Залуучуудын Холбооноос 2001 оны 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Их дээд сургуулийн багш, оюутны “Явган аялал”-ын нээлтийн ажиллагааг Д.Сүхбаатарын талбай дээр зохион байгуулах зөвшөөрөл хүсчээ. НЗДТГ-аас Нийслэлийн удирдлагаас Ерөнхийлөгчийн сонгууль өнгөртөл Д.Сүхбаатарын талбайд ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулахгүй гэж шийдвэрлэсэн хэмээн зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

4.“Оюутан-төсөл үндэсний төв” Монголын Оюутны холбооны өнөөгийн удирдлагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа, баримталж буй бодлого, гаргаж буй шийдвэр захирамжуудыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлж МЗХ-ны төв байрны өмнөх талбайд 2003 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 14 цагт 400-500 оюутан оролцох цуглаан хийх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 2003 оны 3 дугаар сарын 22-нд ирүүлсэнийг хуульд заасан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй гэсэн үндэслэлээр зөвшөөрөл олгохоос татгалзсан хариу өгчээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд зааснаар жагсаал, цуглаан зохион байгуулагч зөвшөөрөл хүсэх хүсэлтээ уг ажиллагаа эхлэхээс өмнө хэдий ч гаргах эрхтэй бөгөөд энэ талаар тогтоосон хугацаа байхгүй юм. Харин Засаг дарга зөвшөөрөл хүссэн мэдэгдлийг ажлын 6 хоногийн дотор шийдвэрлэн бичгээр мэдэгдэх тухай заасан байна.

Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журамд зааснаар зөвшөөрөл хүссэн

мэдэгдлээ уг ажиллагаа эхлэхээс ажлын 7 хоногийн өмнө мэдэгдэх тухай заасан ч энэ нь зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэлд багтахгүй бөгөөд "Оюутан-төсөл үндэсний төв"-өөс зохион байгуулах арга хэмжээ нь уг журамд бус, жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд хамаарах юм. Иймд “хуульд заасан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй” гэсэн үндэслэл нь ямар хуульд заасан хугацаа болох нь тодорхой бус, ойлгомжгүй байна. Зөвшөөрөл олгохоос татгалзсан нь үндэслэлгүй болжээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч зөвшөөрөл авна. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.”, 3 дахь хэсэгт “Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6 өдрийн дотор түүнийг зөвшөөрсөн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.” хэмээн жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийг зөвхөн засаг дарга олгох тухай заажээ. Гэтэл 1998-2003 онуудад Нийслэлийн Засаг даргын тамгын газраас олгосон зөвшөөрөлийг Нийслэлийн Засаг дарга бус Нийслэлийн Засаг Даргын тамгын газрын дарга олгожээ. Энэ нь “зөвхөн засаг дарга зөвшөөрсөн эсэхээ бичгээр мэдэгдэн зөвшөөрөл олгох” тухай хуульд заасантай нийцэхгүй болно.

Харин Сүхбаатар дүүргийн Засаг дарга хуулийн дагуу жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрсөн эсэхээ иргэд, байгууллагад бичгээр мэдэгддэг байна.

II хэсэг

Тайван жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн орчны талаарх судалгаа

“Өөрийнх нь тухай тааламжгүй үнэнийг түгээхээс айхдаа үг хэлэх эрх чөлөөг хязгаарладаг төр засаг бол эгээ л өөрөө харагдахгүй байа гэхээрээ нүдээ аньчихдаг бяцхан хүүхэдтэй адил загнаж байгаа хэрэг.”

Людвиг Верне

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсгийн зарим зүйлд хийх онолын тайлбар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэгт “...үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй.” гэж заажээ.

Хүний эрх гэдэг бол хүний амьд явахаас эхлэн сурч боловсрох, шашин шүтэх, итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх зэрэг хүн хэвийн ажиллаж, амьдрахад зайлшгүй шаардлагатай бүхий л хэрэгцээнээс үүдэлтэй.

Хүнд материаллаг хэрэгцээнээс гадна үзэл бодол, оюун санааны хэрэгцээ, шаардлага гэж байдаг. Энэ нь хүн өөрийн итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх явдал юм.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь өөртөө хэд хэдэн эрхийг багтаасан “багц” эрх, эрх чөлөөний бүрдэл байдаг. Монгол Улсын Олон Улсын гэрээ, Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тодорхойлон баталгаажуулсан 10 гаруй үзэл бодлоо илэрхийлэх эрх /арга/ байна. Тухайлбал,

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх⁵ нь

- 1.Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар (үг хэлэх)⁶,
- 2.Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх)⁷
- 3.Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх⁸,
- 4.Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх⁹
- 5.Эрж хайх (мэдээлэл хайх)¹⁰,
- 6.Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах)¹¹,
- 7.Түгээх эрх¹²,

⁵ ХЭТТ-ын 19, ИУТЭТОУП-ын 19.2, МУҮХ-ийн 16.16

⁶ МУҮХ-ийн 16.16

⁷ МУҮХ-ийн 16.16

⁸ ИУТЭТОУП-ын 19.2

⁹ ИУТЭТОУП-ын 19.2

¹⁰ МУҮХ-ийн 16.17

¹¹ МУҮХ-ийн 16.17

8. Тайван жагсаал, цуглаан хийх эрх¹³,

9. Эвлэлдэн нэгдэх эрх¹⁴

10. Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх¹⁵

11. Ажил хаях¹⁶

12. Өлсгөлөн зарлах зэрэг “нэгэн багц” эрх, эрх чөлөөний бүрдэл аж.

Эндээс тайван жагсаал, цуглаан хийх эрх нь үзэл бодлоо илэрхийлэх нэг үндсэн арга гэдэг нь харагдаж байна. Гэвч үзэл бодлоо илэрхийлэх эрх нь энд дурьдсан 12 эрхээр хязгаарлагдахгүй, учир нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заасан байна.

Өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүнд өвөрмөц байдлаар үзэл бодлоо илэрхийлэх боломжыг бүрдүүлж байдаг. Манай улсад ийм тохиолдол гарч байсан юм. Жишээ дурьдвал, 2002 оны 4 сарын 24-ны өдөр “Хүчит шонхор” зах дээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг Б.Дамдиндорж гэдэг залуу Туул голын ундарга татарч, ширгэж байна, иймд Туул голоо аврахын төлөө ямар нэг ажил хийгээч гэж бизнесмэнүүд болон төр, засгийн удирдлага, нийслэлчүүдийн анхаарлыг хандуулахын тулд Залуучуудын ордны усан санд өглөөний 9 цагаас өдрийн 15 цаг хүртэл бүтэн 6 цагийн турш тасралтгүйгээр сэлж өвөрмөц байдлаар үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн “эрхэм зорилго”, ач холбогдол, утга учир нь юу гэвэл дараахь хэдэн шинжийг дурьдаж болно. Үүнд:

1. Нийгмийн үзэл бодол, ухамсар, соёлыг бий болгож, хөгжүүлж, төлөвшүүлдэг;
2. Нийгэмд ил тод, нээлттэй байдал, эрүүл саруул орчин бий болгодог;
3. Олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, олон нийтэд үзэл бодол, оюун санааны нөлөө үзүүлдэг;
4. Иргэдийн шүүмжлэлт идэвхийг өрнүүлж, нийгэмд ажил хэрэгч уур амьсгал бий болгодог;
5. Иргэдээс зөрчигдсэн эрхийнхээ төлөө тэмцэх, эрхээ хамгаалах хэрэгсэл болдог;
6. Төр түүний байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, цэгнэхэд чиглэдэг;
7. Нийгэмд олон ургальч үзэл бий болж оршин тогтнох үндсэн нөхцөл болдог.

Эндээс харахад, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний эрх төдийгүй нийгмийг төгөлдөржүүлэх гол хэрэгсэл, иргэний нийгэм, ардчилалын тулгуур баталгаа гэдэг нь харагдаж байна. “Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хувь хүн нийгэмтэй шууд харьцах харилцааны илрэл байдаг бөгөөд энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийн онцгой ач холбогдлыг нотолж байдаг билээ. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь

¹² ХЭТТ-ын 19, ИУТЭТОУП-ын 19.2.

¹³ ХЭТТ-ын 20, ИУТЭТОУП-ын 21, МУҮХ-ийн 16.16.

¹⁴ ХЭТТ-ын 20, ИУТЭТОУП-ын 21, МУҮХ-ын 16.10.

¹⁵ МУҮХ-ийн 16.12.

¹⁶ МУ-ын Хөдөлмөрийн хууль, 119, 120.

нийтийн ач холбогдол бүхий асуудлыг чөлөөтэй ил тод хэлэлцэж, нийгмийн үзэл бодлыг бий болгох явдлын зайлшгүй угтвар нөхцөл мөн.”¹⁷

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хэмээх энэхүү улс төрийн эрх, эрх чөлөөний эх сурвалж, анхдагч суурь эрх бол үзэл бодлын эрх, эрх чөлөө юм. Үзэл бодлын эрх, эрх чөлөө нь дараахь “бүлэг” эрх болох 1.Итгэл үнэмшилтэй байх эрх¹⁸, 2.Үзэл бодолтой байх эрх¹⁹, 3.Чөлөөтэй бодож сэтгэх эрх²⁰, 4.Үзэл бодлоо ямар ч хориг цээргүй баримтлах эрх²¹, 5.Үзэл бодлоо өөрчлөх²² зэрэг эрхүүдээс бүрддэг.

Үзэл бодлоо хүн олон арга замаар илэрхийлж байгаа нь тухайн асуудалд өөрийн үзэл бодлоо илэрхийлж буй арга, хэрэгслээ ашиглан олон нийт, эрх баригчдын анхаарлыг хандуулах, татах, олон нийт болон хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байж, хэлэлцүүлэг, маргааны “бай” болох, олон нийт, шийдвэр гаргагч нарт өөрийн үзэл бодол, санал, шүүмж, шаардлагаа байнга сануулж байх, анхаарлын гадна үлдэж, “мартагдахгүй байх” зорилгоор үзэл бодлоо илэрхийлэх олон арга, хэлбэрийг ашигладаг.

Хүн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж баталгаажуулсан нь нэг талдаа ийм учиртай.

Гэхдээ энэ эрх нь маш эмзэг, байнга хөндөгдөж, зөрчигдөж байдаг тул түүнийг маш зөв, соёлтой хэрэглэх, мөн хамгаалж байх учиртай.

Иргэд үзэл бодлоо янз бүрийн аргаар илэрхийлж ирсэн агаад илэрхийлэх арга, хэлбэрт хэмжээ, хязгаар үгүй ч зөвхөн хуулийн хүрээнд уг эрх чөлөөг эдлэх ёстой. Хуулиар үндэсний аюулгүй байдал, олон нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн хэв журам зэрэг бусад зайлшгүй шалтгаанаар уг эрхийг эдлэхэд тодорхой хязгаарлалт тогтоож болох боловч эл эрхийн мөн чанар, бүрэн цогц, нэгдмэл байдлыг хязгаарлан хөндөх ёсгүй гэсэн шалгуур байдаг.

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь засаг төрийн бодлого, үйл ажиллагааг хянан цэгнэж, дэмжих эсэхийн дэнсэн дээр шүүн тунгааж, шүүмжилж “чимхэж” байгаагаар гол төлөв илэрдэгт оршино. Нөгөө талаар манай оронд энэ талын уламжлал нэн хомс болохоор “хэтрүүлэх”, “чочирдох” хоёр зэрэгцэн гарсаар байна...Ер нь Монголчууд саяхан болтол нам засагт халгаатай үгийг төө зайгүй найз гэсэн хүндээ л шивнэж ярьдаг байснаа, гаж үзэлтнийг хорьж, цөлж байсныг ч мартаж ёсгүй.”²³

“Монгол Улсад социализмын үед хүний эрхийг зөрчиж байсан хамгийн гол хэлбэр нь “тэр үзэлтэнтэй” эвлэршгүй тэмцэл явуулдаг байсанд оршино. Тэр үед эрх баригч хүчний бодлого, явуулж байгаа арга хэмжээнд шүүмжлэлтэй хандсан хүнийг “сэхээтний төөрөгдөл”, “намын эсрэг бүлэг” мэтийн нэр томъёо өгч ажил албанаас халж, захиргааны журмаар нутаг зааж цөлөх, мэргэжлийн ажил эрхлэх болон улс төрийн амьдралд оролцох эрхийг нь хасах

¹⁷ ХБНГУ-ын Пассау хотын их сургуулийн хуулийн факультетийн референдар Мориц Лоренц. “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь”. “Эргэцүүлэл” сэтгүүл. 2000. 4 сар. №07

¹⁸ МУҮХ-ийн 16.16.

¹⁹ ХЭТТ-ын 19, ИУТЭТОУПактын 19.2, МУҮХ-ийн 16.16

²⁰ ХЭТТ-ын 18, ИУТЭТОУПактын 18.1.

²¹ ХЭТТ-ын 19, ИУТЭТОУПактын 19.1.

²² ХЭТТ-ын 18, ИУТЭТОУПактын 18.2.

²³ Б.Чимид. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө. “Үндсэн хуулийн үзэл баримтлал”, УБ. 2002 он.

зэргээр хэлмэгдүүлж байснаар барахгүй төрийн эсрэг...онц хүнд гэмт хэрэг болгон хуульчилсан байсан билээ.”²⁴

Жишээ дурьдвал, 1944 онд Баян-Өлгий аймгийн Хужирт сумын харъяат Толобай овогтой Касен гэдэг хүнийг нам засгаас явуулж байсан арга хэмжээнүүдийг унагах, бусниулах, сулруулахын тулд хувьсгалын эсэргүү зорилгоор худал цуурхал тарааж, үг холбон дуулсан гэж тэр үеийн эрүүгийн хуулийн 66 дугаар зүйлийн 1-д зааснаар 10 жил хорьж, хувьд оногдох хөрөнгийг хураахаар шийтгэсэн байдаг.

Т.Касен гэдэг хүн харьцангуй урлагийн авъяастай, өөрөө үг холбож дуу, шүлэг зохиож дуулдаг хүн байжээ. Түүнийг УДШ-ээс 2001 онд цагаатгасан юм. Тэрээр ийнхүү дуулсан аж:

“Монгол Улс хуучны түшмэд, лам молдой нарыг гэмт хэрэг
хийгээгүй байхад баривчлав,
Шинэ залуу хүчин хэмээн залуучууд бидний эрхийг барив,
Эд нар гараагүй бол хуучин феодалын ба мусалмааны ёс суртал байх ёстой,
Бид нарын багачууд хүүхдийг цэрэг, сургууль хэмээн бараг авч,
Үлдсэн муусайн эхнэр, хүүхэд амьдрах аргагүй болов,
Ингэж казакийн үндэс угсааг баллах гэсэн бодлогыг ардууд мэдэж байна уу,
Албан татвар, зээллэг, сугалаа, бэлэг, тусламж гэж бидний гар дээр байгаа мөнгийг
авч дуусгав,
Малын ноос, үсийг жил тутам авч хөлд өмсөх оймс, гэрт хаах эсгийгүй болгож
байна, бэлтгэл гэж төрөл бүрийн малыг жил тутам авч дуусгав.”²⁵

“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” гэдэгт хэл зүйн үүднээс тайлбар хийж үзвэл, “үзэл бодол” гэдэг нь ямар нэг зүйлийн талаар бодож, сэтгэж, эргэцүүлэн оюун дүгнэлт хийсний үр дүнд тухайн зүйлийн талаарх тогтсон бодол, санал, үзэл, “чөлөөтэй” гэдэг нь ямар нэг дур зоргын, зүй бус хязгаарлалт, албадлагаас ангид байх явдал, харин “илэрхийлэх” гэдэг нь эс үйлдэл, үйлдлээр дамжуулан тодорхой асуудлыг илэрхий болгож, тодотгон тодорхойлох, тоочихын нэр аж.

Хүний эрхийг материаллаг болон процессын эрх гэж ангилан үзэх нь бий. Материаллаг эрх гэдэг нь хүний эдлэх ёстой тодорхой эрх, эрх чөлөөг, харин процессын эрх гэдэг нь материаллаг эрх, эрх чөлөө, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчлийг арилгах, бусдаас хангах, биелүүлэх, хамгаалуулахыг шаардах үйлдлийн аргыг /эрх/ хамааруулдаг байна. Энэ утгаар нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхүүд нь цөм процессын эрхүүд гэж ойлгож болох юм. Жишээ нь: Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх /материаллаг эрх/ зөрчигдөж байна хэмээн үзэж иргэд төр засгаас уг эрхийг хамгаалах, хангахыг шаардан тайван жагсаал, цуглаан хийж /процессын эрх/ үзэл бодлоо илэрхийлэх гэх мэт.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь иргэдийн улс төрийн үндсэн эрхийн нэг юм. “Жагсаал” гэдэг бол иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг хэлдэг. Харин “Цуглаан” гэдэг бол иргэд хамтаараа гудамж, талбай, орон байранд өөрсдийн хүсэл зоргийн дагуу хуран

²⁴ Г.Совд. “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх (харьцуулсан эрх зүй), УБ.1999 он., 139 дэхь талд.

²⁵ Баян-Өлгий аймагт сургалтын ажлаар явж байхад хичээлд оролцсон нэгэн сонсогч энэ тухай ярьсан болно.

цугларч үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлэх, солилцох зэргээр үг хэлэх эрх чөлөөгөө эдэлж буй нэг хэлбэр юм.

Жагсаал, цуглаан тайван байдлаар хийгдэх ёстой. “Тайван” гэдэг нь жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг алдагдуулахгүй, эмх замбараагүй байдал үүсгэхгүй, хүчирхийлэл, халдлага, үймээн самуун дэгдээхгүйгээр жагсаал, цуглаан хийнэ гэсэн үг юм.

Хүн бүр үзэл бодлоо тайван жагсаал, цуглаан хийх замаар илэрхийлэх эрхтэй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан **“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”**-тэй гэсэн заалтаар /зарчим/ баталгаажна.

Хоёр. Жагсаал, цуглаан түүний эрх зүйн орчинд хийх дүн шинжилгээ

1989 оны сүүлч 1990 оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хувьсгалын үед жагсаал, цуглаан цөөнгүй зохион байгуулагдаж байсан нь өнөөдөр түүх болон үлджээ. Чухам энэ үеэс эхлэн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг баталгаажуулах, нөгөө талаар нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах гээд олон чухал асуудал гарч ирсэн юм. Түүх сөхөн, зарим нэг зүйлийг эргэн санавал, “1989 оны 2 дугаар сарын 9-нд “Үнэн” сонинд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг орчуулж нийтэллээ. Гэвч уг тунхаглалын 20 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад **“Хүн бүр тайван жагсаал, цуглаан, хуралд оролцох...эрхтэй”** гэснийг **“Хүн бүр энх тайвны жагсаал, цуглаан, хуралд оролцох...эрхтэй”** гэж өөрчилсөн байв.”²⁶

Тэр үед жагсаал, цуглаан их гарах болсон учир Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “Нийслэл хотын гудамж, талбайд олон нийтийн үүсгэл санаачлагаар хурал, цуглаан хийх, жагсаал, ёслол үйлдэх тухай түр журам”²⁷-ыг баталсан байна.

Энэ журмаар Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглосон тул МоАХ, АСХ, ШДХ, МОХ-ноос хамтран 1990 оны 3 дугаар сарын 4-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулахаар төлөвлөж байсан цуглааныг Ленинийн музейн өмнөх талбайд зохион байгуулж байжээ. Энэ үед цуглаанд оролцож буй хүмүүс **“Сүхбаатарын талбай эрх чөлөөний индэр байх ёстой”** гэсэн утгатай лоозонгууд барьсан байж, гэвч дараа дараагийн жагсаал, цуглаан Сүхбаатарын талбайд болсон билээ.

Үүний дараа БНМАУ-ын АИХТ-ээс 1990 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр “БНМАУ-ын хот, суурингийн гудамж, талбайд хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх журмын тухай” №86 дугаар зарлигийг баталжээ²⁸. Эл зарлиг нь 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр /энэ өдөр жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол улсын хууль батлагдсан юм./ хүртэл 4 жил гаруй хугацаанд үйлчилсэн юм.

Энэхүү зарлигаар БНМАУ-ын иргэдийн хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх БНМАУ-ын Үндсэн хуульд заасан эрх чөлөөг баталгаажуулан, хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэх, зөвшөөрөл авах, нийгмийн хэв журам сахин биелүүлэх журмыг тогтоосон байдаг.

²⁶ Х. Дашзэвэг. МҮАН-ын түүхэн тэмдэглэл (1989–1996), УБ., 1998 он, 19 дэхь талд.

²⁷ Нийслэлийн төр, захиргааны архив, Улаанбаатар хотын АДХТ-ийн тогтоол, 1990 он,

²⁸ БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхтгэл, №5, 1990 оны 5 дугаар сар, 176–179 дэхь талд

Зарлигаар аймгийн төв, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх зөвшөөрлийг тухайн аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, сум, хорооны төв, орон нутгийн хотод тэдгээрийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа тус тус олгох, хурал цуглаан, жагсаал ёслолыг иргэд сайн дураар нэгдэн зохион байгуулбал тэдний зохион байгуулагч, нам, олон нийтийн байгуулага зохион байгуулбал түүний удирдлага зөвшөөрөл авах тухай тухай өргөдлөө уул хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө тухайн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд бичгээр гаргах, өргөдөлд хурал цуглаан, жагсаал ёслолын зорилго, эхлэх дуусах цаг, оролцох хүний тоо, ашиглах техник хэрэгсэл, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх болон жагсагчдын цугларах, тарах гудамж, талбай, явах зам, зохион байгуулагчийн овог нэр, ажлын болон оршин суугаа газрын хаяг буюу олон нийтийн байгууллагын нэр, хаягийг тодорхойлон бичих, улмаар АДХ-ын гүйцэтгэх захиргаа хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэхийг зөвшөөрөх эсэх тухай асуудлыг уул өргөдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор хянан шийдвэрлэж, хариуг зохион байгуулагчид бичгээр мэдэгдэх, шаардлагатай гэж үзвэл хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх болон жагсагчдын цугларах, тарах гудамж, талбай, явах зам, эхлэх, дуусах цагийг өөрчлөх, арга хэмжээг 10 хүртэл хоногоор хойшлуулах, БНМАУ-ын үндсэн хууль, улс түмний найрамдал, Монголын ард түмний эв нэгдлийн үзэл санаанд харш, хөтөлбөрт дурьдсан арга хэмжээ хууль тогтоомжид нийцэхгүй байвал хууль бус гэж үзэж зөвшөөрөл олгохгүй байх эрхтэй, хурал цуглаан, жагсаал ёслолын явцад хууль ёс, нийгмийн хэв журмыг зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй бол БНМАУ-ын эрүүгийн хуульд зааснаар хариуцлагад татах, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх талаар тогтоосон журам зөрчсөн бол уг зөрчлийг таслан зогсоохын тулд шаардлага тавьсан засгийн төлөөлөгч, цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, ардын нөхөрлөлийн гишүүн, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байгаа төр, олон нийтийн бусад байгуулага, тэдгээрийн төлөөлөгчийг доромжилсон, эсэргүүцсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал түүнийг шүүгч 30 хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу цагдан сэргийлэх байгуулага 500 хүртэл төгрөгөөр торгох эрхтэй байхаар заажээ.

Дүгнэн үзвэл, энэ зарлиг нь БНМАУ-ын үндсэн хуульд заасан эрх чөлөөг баталгаажуулан, хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэх, зөвшөөрөл авах, нийгмийн хэв журам сахин биелүүлэх зэрэг журмыг тогтоож, Сүхбаатарын талбай дээр хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэхийг хориглоогүй зэрэг давуу талтай ч шүүмжлэлтэй хандах хэд хэдэн зүйл байгаа юм. Тухайлбал,

- Хурал цуглаан, жагсаал ёслол зохион байгуулагчийн ажлын болон оршин суугаа /гэрийн хаяг/ газрын хаягийг өргөдөлд бичихийг заасан, энэ нь жагсаал, цуглаан зохион байгуулагчид засаг захиргаанаас ямар нэг байдлаар хяналт тавих боломжыг олгож байсан;
- БНМАУ-ын үндсэн хууль, Монголын ард түмний эв нэгдлийн үзэл санаанд харш бол хууль бус гэж үзнэ хэмээн хурал цуглаан, жагсаал ёслол ямар зорилготой, хэний эрх ашигт нийцсэн байхыг заасан;

- Хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэхийг зөвшөөрлийн системд оруулсан;
- Хурал цуглаан, жагсаал ёслолыг хууль бус гэж үзэх, зөвшөөрөл олгохгүй байх, АДХ-ын гүйцэтгэх захиргаа шаардлагатай гэж үзвэл хурал цуглаан, жагсаал ёслол үйлдэх гудамж, талбайг өөрчлөх, хугацааг хойшлуулах зэрэг хэт өргөн эрхтэй байхаар заасан;
- Хурал цуглаан, жагсаал ёслол зохион байгуулсны улмаас улсын үйлдвэрийн газар, байгууллага, иргэдэд эд хөрөнгийн хохирол учирсан бол түүнийг зохион байгуулсан этгээд хариуцна гэж заасан нь иргэдээс хурал цуглаан, жагсаал ёслол зохион байгуулах, оролцох эрхийг дам байдлаар хязгаарлахад чиглэгдэн, бодит байдал дээр жагсаал, цуглаан хийх эрх нь ямар нэг эрх зүйн хамгаалалт, баталгаа байхгүй байсан зэрэг болно.

Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “Монгол улсын иргэн...тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж заасныг үндэс болгон Монгол Улсын Засгийн газраас “Жагсаал, цуглаан хийх журмын тухай” хуулийн төслийг боловсруулан 1994 оны 5 дугаар сарын 9-нд өргөн мэдүүлжээ. Хууль зүйн байнгын хороо уг төслийг хэлэлцэн УИХ-ын чуулганаар хэлэлцэх шаардлага хангахгүй гэдэг үндэслэлээр хууль санаачлагчид буцаажээ. Засгийн газраас 1994 оны 6 дугаар сарын 11-нд 2 дахь төслийг өргөн мэдүүлсэн байна.

Харин УИХ-ын гишүүн Ц.Нямдорж Засгийн газрын өргөн мэдүүлсэн 2 дахь төсөлтэй танилцан, Засгийн газрын анхны төсөл үндсэндээ хэвээр байна гэж үзэн өөрийн боловсруулсан төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд энэхүү төслийг УИХ 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хэлэлцэн баталжээ.²⁹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль³⁰ нь 15 зүйлтэй бөгөөд 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оржээ.

Уг хууль нь тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн үндсэн хуулийн эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал, цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван зорилтын хүрээнд түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Цуглаан ба үзэл бодлоо илэрхийлэх эрх

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар “цуглаан” гэдэг нь Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг ойлгох тухай заажээ.

Хуулиар “цуглаан” гэсэн нэр томъёог хэт өргөн хүрээтэй тодорхойлсон нь жагсаалаас бусад үзэл бодлоо илэрхийлж буй бүх аргыг “цуглаан” гэж ойлгоход хүргэж байна. Жишээ дурьдвал, Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчид Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас явуулсан 2002 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн №1/4197 тоот тайлбар хүсэх тухай албан бичигт “сүүлийн үед нийслэл хотын төвд

²⁹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хувийн хэрэг /№75, 1994 он/, уг хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэл /1, 2-р хэлэлцүүлэг, 1994 он/ УИХ-ын номын сан,

³⁰ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 1994 он, №9, “Ардын эрх” сонин, 1994 он, №140

улс төрийн суулт, өлсгөлөн зэрэг арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн дэг журам зөрчиж, эмх замбараагүй байдал бий болгоход хүргэж байна...энэ заалтад өлсгөлөн, суулт, цуглаан зэрэг дээр дурьдсан агуулгатай бүх хэлбэрийн үйл ажиллагаа хамрана гэж бид ойлгож байгаа боловч “өлсгөлөн”, “суулт” гэдэг үг байхгүй байгаа гэдгээр уг ажиллагааг зохион байгуулагчид үндэслэл болгож байгаа юм. Иймд “цуглаан” гэсэн ойлголтод өлсгөлөн, суулт зэрэг бусад үйл ажиллагааг хамруулж ойлгох талаар Дээд шүүхийн тайлбар даруй гаргаж өгөхийг хүсье.” гэжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх олон арга бий, тэдгээрийг тус тусад нь Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлон баталгаажуулсан байдаг, үүний нэг нь “цуглаан” юм. Энэ талаар дээр дэлгэрэнгүй авч үзсэн билээ.

Өөрийн үзэл бодлоо өлсгөлөн зарлах, суулт хийх, ажил хаях зэрэг аргаар илэрхийлж байгааг нийтэд “цуглаан” гэж тодорхойлж болохгүй юм. Цуглаан нь иргэд хамтаараа гудамж, талбай, орон байранд өөрсдийн хүсэл зоргийн дагуу хуран цугларч улс төр, эдийн засаг, нийгэм, хүний эрх, эрх чөлөө зэрэг асуудлаар өөрийн үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлэх, үзэл бодлоо солилцох замаар үг хэлэх эрх чөлөөгөө эдэлж буй хүний улс төрийн эрх, эрх чөлөөний нэг хэлбэр билээ.

Үүнээс гадна “цуглаан” гэдэгт баярын цэнгүүн, урлаг, спортын арга хэмжээний нээлт, хаалтын ажиллагаа, фестиваль, өдөрлөг, хэвлэл, номын яармаг, ойн болон ёслолын арга хэмжээ зэрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагаа болгон хамаарахгүй байхаар хуулиар тогтоожээ.

Зөвшөөрлийн тогтолцоо ба журам

Монгол Улсад тайван жагсаал, цуглаан хийх асуудал, мөн иргэд, байгууллагууд хуран цугларч зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ бүр “бүрэн” хэмжээгээр зөвшөөрлийн тогтолцоонд шилжсэн гэж дүгнэж болох юм. Учир нь Монгол Улсад жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авахгүй, хууль үйлчлэхгүй ганц субъект нь төр юм. Төр, түүний эрх бүхий байгууллагад жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авахгүй байх өргөн боломж олгогдсон байдаг бол иргэд, төрийн бус байгууллага, улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөнөөс тайван жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авах журам үйлчилж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн ёслолын болон төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа жагсаал, цуглаан”-нд энэ хууль үйлчлэхгүй гэж заасан. Гэвч амьдрал дээр “төр түүний эрх бүхий байгууллага” гэдэгт төрийн ямар байгууллага хамрах нь тодорхой бус. 1998-2003 оны хооронд НЗДТГ болон ЧД, СБД-ийн Засаг даргаас төрийн 23 байгууллага зөвшөөрөл авч жагсаал, цуглаан зохион байгуулсан байгаа.

Жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авдаг журам нь 1990 онд Улаанбаатар хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан “Нийслэл хотын гудамж, талбайд олон нийтийн үүсгэл санаачлагаар хурал, цуглаан хийх, жагсаал, ёслол үйлдэх тухай түр журам”-аас эхтэй юм. Тухай үед жагсаал, цуглаан хэний эрх ашигт нийцсэн, ямар зорилготой байх,

Дүгнэн үзвэл,

а/ журмаар зохицуулах харилцааг зохицуулсан зорилт /журмын 1.1/, уг журмын үйлчлэх хүрээ /журмын 1.3-ийн б, в/ нь хоорондоо зөрчилтэй.

б/ “Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам” хэмээсэн нэрнээс нь үзэхэд эл журам ямар арга хэмжээнүүд үйлчлэх нь хүнд ойлгогдохоор товч тодорхойлогдсон гэж ойлгож болохоор, гэвч зохицуулахаар зорилт болгосон хүрээ, хэмжээнээс өргөн хүрээг хамарчээ.

в/ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсдаас тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар зохион байгуулж байгаа хурал, цуглаан, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ”-г зохион байгуулахад уг хууль нь үйлчлэхгүй гэсэн нь зөвхөн хот, суурингийн гудамж талбайд болох жагсаал, цуглааныг зохицуулах үүднээс, нөгөө талаар байгууллага дээр болох цуглаан, хуралд зөвшөөрөл авах шаардлага байхгүй, тэгээд ч байгууллага дээр болж байгаа цуглаан, хурлыг зохицуулах боломжгүй, энэ нь амьдрал дээр хэрэгжихгүй гэдэг үүднээс энэ асуудлын тухайд уг хууль үйлчлэхгүй байх нь зүйтэй юм гэж үзэж байсан нь жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы 2 дахь хэлэлцүүлэгийн тэмдэглэлд тэмдэглэгдэн үлдсэн байна³¹.

Энэ нь бодит байдалтай нийцсэн, зөв зохицуулалт болсон юм, харин аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсдаас тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар зохион байгуулж байгаа уулзалт тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээг зохион байгуулахад энэ журам үйлчлэх тухай заасан нь амьдралд төдийлөн нийцэхгүй байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19 дэх хэсэгт: “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч зөвшөөрөл авна.” гээд мөн зүйлийн 3 дахь хэсэгт: “Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 өдрийн дотор түүнийг зөвшөөрсөн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.” гэж заажээ. Цаг үеийн онцлог байдлаас хамааран улс төр, эдийн засаг, нийгэм, хүний эрхийн тулгамдсан чухал асуудлаар өөрсдийн үзэл бодлоо тайван жагсаал, цуглаан хийх замаар богино хугацаанд /1-24 цагийн дотор эсхүл 1-3 хоногийн дотор/ илэрхийлэх боломж хомс аж. Зарим нэг тодорхой асуудлыг хөндсөн үйл явдал хурдан шуурхай өрнөдөг. Үүнтэй холбоотойгоор тухайн асуудлаар үзэл бодлоо богино хугацаанд илэрхийлэх шаардлага гардаг. Нэгэнт асуудал үүссэн бол түүнийг олон нийтийн эрх ашиг, олон нийтийн мэдэх эрхийг хангах үүднээс нэн даруй олон нийтэд үзэл бодлоо илэрхийлэн, тухайн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах учиртай. Гэтэл уг хуульд зааснаар Засаг дарга жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрсөн эсэхээ ажлын 6 өдрийн дотор мэдэгдэх, цаашлаад жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрөхөөс татгалзсан шийдвэрт гаргасан гомдлыг шүүгч ажлын

³¹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэл, 1994 он, 2 дахь хэлэлцүүлэгийн тэмдэглэл, 6-7 дахь талд, УИХ-ын номын сан,

6 өдрийн дотор багтаан хянан шийдвэрлэх гээд асуудал наад зах нь 12 хоног хүртэл хугацаагаар сунжирч болохоор аж. Угаас жагсаал, цуглаан нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлын эсрэг зүйл биш, энэ нь үндсэн эрхийн асуудал тул хүн өөрийн үндсэн эрх чөлөөгөө эдлэхийн тулд ажлын 12 хүртэл хоног “хүлээх” нь “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн заалттай нийцэхгүй байна. Үндсэн хуулийн “чөлөөтэй” гэдэг үг нь зүй бус албадлага, хязгаарлалтаас ангид байх гэсэн санааг илэрхийлэх бөгөөд цаг хугацааны хувьд нэн даруй, түүгээр үл хязгаарлагдан үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй гэсэн үг юм.

Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хязгаарлалт

Тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах үндэслэл, зарчим нь нэлээд чухал асуудал болно. Монгол Улсын иргэн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг баталгаатай эдлэх учиртай. Төрөөс тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээдэг.

Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх учиртай эрх, эрх чөлөө, онцлон үзвэл, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “...хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор...”, үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “...эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар хязгаарлаж болно” гэсэн нь хүний эрхийг хязгаарлах нийтлэг үндэслэлийг дурьджээ.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулиар тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж буй гол үндэслэл нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах явдал болохыг хуулийн 1 дүгээр зүйлээс харж болно.

Монгол Улсад тайван жагсаал, цуглаан хийх эрхийг ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай гэсэн үндэслэлийг шалгуур болгон хуульд зааснаар объект, субъект, жагсаал, цуглааны зорилго, онцгой нөхцөл байдал гэсэн дөрвөн хүрээнд хязгаарлалт тогтоожээ. Үүнийг тус бүрээр нь дэлгэрүүлэн авч үзье.

а/ объектийн хүрээнд:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд Жагсаал, цуглаан хийхийг хориглох газрыг заажээ. Үүнд:

1.1. нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэл дэх төв холбооны газар;

1.2. цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар;

1.3. радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгуулага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар;

1.4. олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах;

1.5.эмнэлгийн байгууллага;

1.6.Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай.

2.Монгол Улсын төрийн ордоны тухай хуулийн 11 дүгээр зүйлд төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт хориглох зүйлийг заажээ. Үүнд:

2.1.төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлэх, төрийн ордонд нэвтрэгчид саад хийх

3.“Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам”-ын 1.5-д зааснаар дор дурьдсан байгууллага, цэг оршин байгаа газар, түүний орчимд баяр ёслолын ажиллагаа явуулахыг хориглох тухай заасан байна. Үүнд:

1.нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, зорчигч тээврийн төв, нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, буудлууд;

2.цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар;

3.радио, телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, төв холбооны газар;

4.хүнсний болон барааны зах;

5.эмнэлгийн байгууллага.

Дүгнэн үзвэл, хууль болон журамд зааснаар улс, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах үүднээс тодорхой байгууллага, газарт жагсаал, цуглаан хийхийг хориглож байгаа нь зөв билээ. Гэвч эдгээрээс 2 зүйлийн тухайд эргэн харж, анхааралтай судлан үзвэл зохилтой байна. Үүнд:

Нэг. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглож буй нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах асуудалтай холбоотой юм.

Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан хийх хүсэл зориг, хэрэгцээ шаардлага олон нийтэд байдаг. Энэ нь удаа дараагийн оролдлого, үйл явдлаас харагдаж байгаа билээ.

Сүхбаатарын талбайгаас гадна “Эрх чөлөө”-ний талбайд жагсаал, цуглаан хийж болох боловч энэ талбай “ачаалал” ихтэй байдагаас болж эл эрх чөлөөгөө эдлэх боломжгүйд хүрээд байна. Жил бүр “Эрх чөлөө”-ний талбайд өвөл нь “Мөсөн хотхон” байгуулж, хавар нь “Цагаан идээ”-ний худалдаа, зун нь “Хөх хулганы орон” хэмээх хүүхдийн тоглоомын хотхон, намар нь эрт ургацын хүнсний ногооны худалдаа зохион байгуулдаг уламжлал тогтоод байгаа билээ.

Сүхбаатарын талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслол, наадам, төрийн баяр, ёслолын арга хэмжээг зохион байгуулдаг, үүнийг хууль тогтоомжоор хориглоогүй атал Монгол Улсын иргэд зарим асуудал, сэдвийг хөндөн тайван жагсаал, цуглаан хийх замаар өөрийн үзэл бодол, санал, шаардлагаа Сүхбаатарын талбай дээр илэрхийлэхийг хориглосон байна. Энэхүү зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзвэл,

1.1. Хүн бүр өөрийн итгэл үнэмшил, үзэл бодолтой байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Монгол Улсын иргэн бүр улс орныхоо эдийн засаг, улс төр, хүний эрх, нийгмийн болон бусад асуудлаар өөрийн гэсэн үзэл бодолтой. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заасан байдаг.

Гэтэл жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Монгол Улсын иргэдээс **улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар** Сүхбаатарын талбайд үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хориглож, харин **Монгол Улсын иргэн улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдолгүй бусад сэдвээр** Сүхбаатарын талбай дээр үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийхэд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль үйлчлэхгүй байхаар заажээ.

Энэ нь Монгол Улсын иргэдээс **улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар** Сүхбаатарын талбайд үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийхийг хориглон, харин **улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдолгүй бусад сэдвээр** Сүхбаатарын талбайд тайван жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрсөн гэсэн үг.

Жишээ нь: Бодит байдал дээр улс орны эдийн засаг, банк санхүүгийн байдал доройтсон гэж үзье, үүнийг засгийн газрын явуулж буй бодлого, үйл ажиллагаатай холбон, тэрхүү бодлого, үйл ажиллагааг шүүмжлэн, аль нэг улс төрийн нам, хүчин өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх замаар Сүхбаатарын талбайд цуглаан хийхийг хориглосон гэсэн үг, ийм зорилго бүхий цуглаан хийх хүсэлт гаргавал зөвшөөрөл өгөхгүй байхаар хуульд заасан, гэвч энэ нь улс орны эдийн засаг, банк санхүүгийн байдлын талаарх иргэдийн үзэл бодлын илэрхийлэл юм, харин Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 1998 онд Сүхбаатарын талбайд “Эмэгтэйчүүд хүчирхийллийн эсрэг” сэдэвт жагсаал зохион байгуулах зөвшөөрөл олгосон байна. Энэ нь сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд их өртөх болсон, иймд эмэгтэйчүүдийн хүчирхийлэлийг багасгах, үүний эсрэг бүх нийтээр тэмцэхийг уриалж, энэ талаар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлсэн жагсаал байжээ.

Дүгнэн үзвэл, Монгол Улсын иргэн өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар ялгаварлан, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой сэдвээр Сүхбаатарын талбайд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар тайван жагсаал, цуглаан хийхийг шууд хориглож, бусад асуудлыг хөндөн үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрчээ.

Энэ нь Монгол Улсын иргэний өөрийн итгэл үнэмшилтэй, үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй баримтлах зэрэг үзэл бодлын эрх, эрх чөлөөг ялгаварлан хязгаарласан хэрэг юм.

Гэвч нөгөө талаар аль ч жагсаал, цуглаан нь улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй шууд болон шууд бус байдлаар холбогдоно. Энэ нь тухайн жагсаал, цуглааныг улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой, эсхүл холбоогүй гэж өөрийн үзэмжээр хандах боломжыг шийдвэр гаргагчид олгож байгаа нь нууц биш юм.

1.2. Тайван жагсаал, цуглаан нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдалд хохирол учруулах зорилго, санаа, сэдлээр хийгддэггүй билээ. Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн “эрхэм” зорилго, гол агуулга бол иргэд өөрсдийн үзэл бодол, санал, гомдол, шүүмж, шаардлагаа төр засагтаа илэрхийлэх, тухайн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх, төр, түүний байгууллагын үйл ажиллагааг үнэлж, цэгнэсэн дүгнэлт, үг хэлэх эрх чөлөөгөө эдлэх зорилгоор зохион байгуулагддаг.

Иймд Сүхбаатарын талбайд нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлж, зарим асуудлаар жагсаал, цуглаан зохион байгуулахыг шууд хориглож байгаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай үндэслэл болж чадахгүй юм. Тухайлбал,

-Сүхбаатарын талбай дээр тодорхой асуудал, зарим сэдвийг хөндсөн жагсаал, цуглаан хийх явдлыг нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлэн, шууд хориглож байгаа явдлыг угаас зарим асуудлыг хөндсөн жагсаал, цуглааны зорилгыг нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлын эсрэг зүйл мэт ойлгон дүгнэхэд хүргэж байна.

-Жагсаал, цуглаан хийх нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлд “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасныг иш болговол жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журмыг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах ажлыг төр хариуцан хийх юм.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалах, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй болохыг, Дотоодын цэргийн тухай хуулийн 10 дугаар зүйлд цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй үед тэдэнд туслах зорилгоор дотоодын цэрэг баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийгмийн хэв журмыг сахиулахад туслах талаар заасан байдаг.

- Зарим нэг жишээ дурьдвал, Англи улсад байрладаг, “19 дүгээр зүйл” байгууллагын хуулийн хөтөлбөрийн захирал Тоби Мендель ийм нэг жишээг ярьсан юм. Тэрээр “АНУ-д нацистууд еврейн хороолол, гудамжаар жагсаал хийх хүсэлтээ засаг захиргааны байгууллагадаа гаргажээ. Засаг захиргаанаас нацистуудад зөвшөөрөл өгөхөөс татгалзсан байна. Тэд татгалзсан үндэслэлээ нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс зөвшөөрөл олгоогүй гэж тайлбарласан байдаг. Харин нацистууд шүүхэд гомдол гарсан бөгөөд шүүх захиргааны шийдвэрийг хүчингүй болгож, нацистууд еврейн хороолол, гудамжаар жагсаал хийх эрхтэй гэж шийдвэрлэсэн байна. Шүүх нийгмийн хэв журмыг хангах нь засаг захиргааны байгууллагын үүрэг учраас, нацистууд жагсаал хийх үед энэ үүргээ засаг

захиргаа гүйцэтгэх ёстой, түүнчлэн нацистууд, еврей нарын хоорондын дайсагнасан харьцаа дэлхийн 2-р дайны үеийнх шиг хүчтэй биш гэж үзсэн байдаг.”

Үүний адил бид нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хэн хамгаалах ёстой вэ гэдгийг ялгаж, салган үзэх, жагсаал, цуглаан нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг эсрэг зүйл бус, үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөө гэдгийг байнга санаж байхад илүүдэхгүй болов уу.

-Нийгмийн хэв журмыг хангах асуудлыг хүний эрх чөлөөтэй сөргөлдүүлэн, эл үндэслэлээр хүний эдлэх ёстой эрхийг хязгаарлах нь зохилтой биш. Нийгмийн хэв журмыг хүний эрх чөлөөнөөс дээрд үзэж хүний эрх, эрх чөлөөг зохих үндэслэлгүйгээр хязгаарлах нь дарангуйллын тогтолцоог санагдуулж байгааг нуух юун.

-Жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах тухай асуудал нь яван явсаар нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс жагсаал, цуглаан хийх эрхийг хориглох болтолоо өнгөө хувиргажээ.

-Нэгэнт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн төр засаг нь жагсаал, цуглааны үед хэв журам хангах талаар ажиллах ёстой атал жагсаал, цуглаан хийх эрхийг хориглон байж, нийгмийн хэв журам хангах, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүргээ “хялбар” аргаар гүйцэтгэж байгааг зөвтгөх боломжгүй юм.

Хүний эрхийн зүй ёсны хязгаарлалт нь зохистой хэмжээнээсээ хэтэрч гарвал эргээд хүний эрхийг зөрчдөг. Хуулиар үндэсний аюулгүй байдал, олон нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн хэв журам зэрэг бусад зайлшгүй шалтгаанаар тайван жагсаал, цуглаан хийх эрхийг эдлэхэд тодорхой хязгаарлалт тогтоож болох боловч эл эрхийн мөн чанар, бүрэн цогц, нэгдмэл байдлыг хязгаарлан хөндөх ёсгүй юм.

1.3. Жагсаал, цуглаан журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэлийг судлан үзэхэд Сүхбаатарын талбай бол “Монгол Улсын төрийн төв байгууллага байдаг”, “Монгол Улсын зүрх болсон газар”, “Монгол Улсад ганц байдаг”, “Монголчуудын хайрлаж хүндэтгэж байх талбай” учир жагсаал, цуглаан хийхийг хориглох нь зүйтэй гэх зэргээр УИХ-ын гишүүд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж байжээ. Тухайлбал:

“УИХ-ын гишүүн Д.Мөнхөө: Миний хувийн санал бол...ялангуяа нийслэл хотын Сүхбаатарын талбайд жагсаал хийхийг л энэ хуулиар хориглох ёстой л гэж би бодож байна. Яагаад гэхээр энэ бол үнэхээр Монгол Улсын төрийн төв байгууллага байж байгаа, Монгол Улсын зүрх болсон газар, бид түрүүн харсан, би түүнийг энэ нь зөв, буруу гэж надад хэлэх юм алга, өндөр хэмжээний гурван, хоёр том зочин, хоёр гурван зочин ирэхэд бид ямар байдалтай байв, энэ бол Монгол Улсын нэр төртэй, цаашдаа их олон юмтай холбоотой ийм эрх ашиг энд нийт ард түмний эрх ашиг байна гэж би ойлгож байгаа.

Ийм учраас энд ямар нэг хэмжээгээр үүнийг эрх зүйн зохицуулалт хийх ёстой вэ? ямар хэмжээгээр хийхийг эрхэм гишүүд бас ярьж байгаад шийдэх ёстой, миний хувийн санал бол нийслэл хотын төв талбай гэдгийг бүр хуульд зааж өгөх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байна.

УИХ-ын гишүүн Ч.Баянжаргал: Нийслэлийн төв талбай /Сүхбаатарын талбайд/ гээд жагсаал, цуглаан хийхийг хориглоно гээд энэ хуулин дотор тодорхой зааж өгсөн байх ёстой гэж би бас бичсэн зүйл бий, өгөгдөөгүй болохоос.

УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж: 8 дугаар зүйлд жагсаал, цуглаан хийхийг хориглох газар гэсэн ийм зүйл дээр би 3 санал өгч байгаа юм аа. Тэгэхээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд улс төрийн аливаа шалтгаанаар жагсаал, цуглаан хийхийг хориглоно гэсэн ийм заалтыг би оруулахын төлөө байна. Аливаа улсад үндэс гэж байдаг. Хайрлаж байдаг тийм ариун нандин газар бол заавал байдаг л даа. Миний бодоход Монгол Улсын маань нийслэлийн Сүхбаатарын талбай бол Монголчуудын хэн бүгдийн хайрлаж хүндэтгэж байдаг талбай.

Энд хүмүүс уулзаж, энд хүмүүс дурсгалынхаа зургийг татуулж, энд амарч, энд үр хүүхэдтэйгээ зугаалж амарч байдаг л даа. Тэгэхээр Монголдоо ганцхан байдаг, талбайгаа Монголын ард түмэн амар тайван байлгаж болох байх л даа. Бусад газар нь жагсаал, цуглаан хийж, өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх бол хангалтай талбай бий. Тэгэхээр энийг их бодмоор байна. Ер нь тэгээд өнгөрсөн 4 сарын үед ч гэсэн Сүхбаатарын талбай дээр болсон жагсаал, цуглааны үр дагаврыг бид өнөөдрийг хүртэл харж байгаа. Тэрэн дээр Сүхбаатарын талбай байтугай, хөшөө рүүгээ асчихсан, өнөөдөр тэр зүлэг нь одоо болтол улаан халцгай, хажуугийн хамгааллын арслангуудын гинжүүд нь одоо хүртэл эвдэрчихсэн ийм л байгаа шүү дээ. Төрийн маань далбаа намирч байдаг тэр тугандаа нэгэн нам юм уу, эсрэг хүчний туг нь өдөр болгон хийсч, бас л цаг болон газраа оносон тийм үйл явдал биш болов уу гэж боддог.

Ийм учраас улсынхаа зүрх болсон Монголдоо ганц байдаг Сүхбаатарын талбайгаа бид амар байлгахын төлөө энэ талбайд аливаа улс төрийн шалтгаанаар жагсаал, цуглаан хийхийг хориглох нь зүйтэй гэсэн ийм саналыг би оруулж байна.”³² гэжээ.

Сүхбаатарын талбай нь Монгол Улсын төв талбай, хайрлан хүндэтгэж байх учиртай зүйл, Монгол Улсад ганц байдаг, ариун нандин байх ёстой гэсэнтэй санал нэгдэх боловч энэхүү үндэслэл маань үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй зүйл хараахан биш юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад заасан хүний эрхийг хязгаарлах нийтлэг үндэслэлд хамаарахгүй байна.

1.4.Иргэдийн үг хэлэх эрхээ эдлэх, хүсэл зориг, санал, шаардлага илэрхийлэх “тайван” тэмцэл, эсэргүүцлийн гол хэлбэр нь “тайван” хэмээх тодотголтой жагсаал, цуглаан хийх явдал юм. Хэнд өөрийн үзэл бодол, санал, шаардлага, шүүмжээ илэрхийлэхийг хүсч байна, түүнд мэдрэгдэхээр ойрхон очиж илэрхийлэх нь мэдээж үр дүнтэй.

Харин эрх баригчид иргэдийн үзэл бодол, санал шаардлага, шүүмж, эсэргүүцлийн хүчийг сулруулах, хариуцлагаас зайлсхийх, олон нийтийн анхаарлыг татуулахгүй байх үүднээс Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийх явдлыг нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах, уг талбай нь ариун нандин зүйл, хайрлан хүндэтгэх ёстой гэсэн

³² Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэл, 13, 27, 29-р талд, УИХ-ын номын сан,

зайшлгүй шаардлагатай бус үндэслэлээр халхавч хийж, уг эрхийг хязгаарлах оролдлого хийсэн гэж дүгнэж болохоор байгааг нуух хэрэггүй биз ээ.

2.1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6-д “жагсаал, цуглаан зохион байгуулагч нь жагсаал, цуглаан хийх газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангаагүй” бол хариуцлага хүлээлгэх тухай заажээ.

Түүнчлэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлд жагсаал, цуглааныг зохион байгуулагч, санаачлагч /улс төрийн нам, олон нийтийн байгууллага/ нь жагсаал, цуглаан хийх газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах “төрийн үүргийг” жагсаал, цуглаан зохион байгуулах нүсэр ажлын зэрэгцээ цуг гүйцэтгэн “төрдөө туслах” үүрэг хуулиар хүлээжээ.

Гэтэл жагсаал, цуглаан зохион байгуулагчид нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүргийг бус үндсэн эрхийн хүрээнд санал, шаардлага илэрхийлж буй этгээд юм. Жагсаал, цуглаан зохион байгуулагч нь үндсэн эрхээ эдлэхийн зэрэгцээ нийгмийн хэв журмыг хангах томоохон чиг үүргийг гүйцэтгэх боломжгүй төдийгүй энэ нь жирийн иргэний эрх хэмжээнээс хэтэрсэн зүйл билээ.

Иймд жагсаал, цуглаан зохион байгуулагч нь жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журмыг хангах, хамгаалах үүргийг бус нийтээр тогтоосон хэв журмыг сахих үүрэг хүлээх нь зүйтэй юм.

2.3. Төрийн ёслолын үйл ажиллагаа, төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа баяр, ёслолын арга хэмжээг зохион байгуулахад Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам, түүгээр тогтоосон зөвшөөрлийн тогтолцоо төр, түүний эрх бүхий байгууллагуудад үйлчлэхгүй байгаад дүгнэлт хийж төрийн үйл ажиллагааны ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал гэсэн үндсэн зарчим, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх талаар хүлээсэн үүргийг санаж дахин эргэн харах нь зүйтэй байна.

2.4. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”-тэй гэсэн заалт байдаг. Энэхүү Үндсэн хуульд заасан “чөлөөтэй” гэдэг нь орон зай, хил хязгаар, нутаг дэвсгэрийн хувьд зүй бус хязгаарлалт, хориглолт, үл нэвтрэх байдлаас ангид орших гэсэн санааг илэрхийлж байна. Хүн үзэл бодлоо орон зай, нутаг дэвсгэр, хил хязгаар үл харгалзан чөлөөтэй илэрхийлэх эрхтэй юм. Хүний үзэл бодлоо илэрхийлэх орон зай, нутаг дэвсгэрийг хязгаарлах асуудал нь хүний эрхийг хязгаарлах ерөнхий зарчимд нийцсэн байх учиртай.

Хоёр. Судлан үзвэл зохих дараагийн асуудлын тухайд авч үзвэл, Монгол Улсын төрийн ордон тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Төрийн ордон гэдэг нь Монгол

Улсын төрийн эрх барих дээд байгууллага болон төрийн тэргүүн, гүйцэтгэх дээд байгууллага байнга байрлаж, үйл ажиллагаа явуулж байгаа барилгыг хэлэх бөгөөд төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг УИХ тогтоохоор заасан. УИХ-ын 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Монгол Улсын төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг дор дурьдсанаар тогтоожээ. Үүнд:

1. Монгол Улсын Төрийн ордны зүүн, баруун зүгт тус бүр 33 метр,

2. Монгол Улсын Төрийн ордноос урд, хойд зүгт тус бүр 80 метр хүртэлх орчин, нутаг дэвсгэрийг Төрийн ордны нутаг дэвсгэрт тооцох тухай заасан байна. Төрийн ордны нутаг дэвсгэрт ойролцоогоор Сүхбаатарын талбайн хоёр хуваасны нэг нь хамаарч байгаа юм. Харин хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлага илэрхийлэхийг хориглож буй нь үзэл бодлоо **“чөлөөтэй”** илэрхийлэх эрхийг хязгаарлаж байна.

Төрийн ордон халдашгүй дархан байх ёстой, энэ нь төрийн үйл ажиллагаа тасралтгүй явагдах, улс, үндэсийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах гээд олон асуудалтай холбоотой нь мэдээж. Харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван, жагсаал, цуглаан нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмын эсрэг бус, төр засагт санал, шүүмж, шаардлага илэрхийлэх зорилготой, нэг талаар Монгол Улсын иргэн, иргэний нийгмийн төрийг удирдах хэрэгт оролцож буй, төртэй харилцах харилцааны нэг хэлбэр юм.

Энд төрийн ордны халдашгүй байдал, нөгөө талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх гэсэн 2 асуудлыг дэнслэн авч үзэх асуудал гарч ирнэ. Энэ хоёрт өөр өөрийн ашиг сонирхол бий. Нэгийг нь нөгөөгөөр нь устгаж үл болно. Гагцхүү зохистой хэмжээг барих нь чухал. “Хүн төрлөхтний түүхэн сурвалжаас үүдэн дүгнэхэд иргэн хүний эрх чөлөөг дөвийлгөх, төрийн эрх мэдлийг хязгаарлахад чиглэсэн” тал нь нилээд түлхүү анхаарах ёстой элемент байдаг гэдэг нь нотлогдож буй юм.”³³ гэсэнтэй санал нэгдэж байна.

Нөгөө талаар төр засагт үгээ хэлэх нь төрийн ордон, эрх баригч, шийдвэр гаргагч нарт хэдий чинээ ойр байх тусам үр дүнд хүрдэг.

Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан хийх, өлсгөлөн зарлах, суулт хийх зэргээр шаардлага, үзэл бодлоо илэрхийлэх бүх хэлбэрийг Монгол Улсын Төрийн ордны хуулиар хориглосон байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”-ийг бүхэлд нь хязгаарласан явдал бөгөөд асуудал төрийн ордны хамгаалалт, үйлчилгээг журамлах хэр хэмжээнээс хэтэрсэн мэт.

Энэ нь Монгол Улсын үндсэн хуульд заасан гүн гүнзгий утга санаа агуулсан, дээд хүчин чадалтай, шууд хэрэгжих шинж чанар бүхий **“үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”**-тэй гэсэн заалт³⁴ хэрэг дээрээ хэрэгжихгүй, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж, баталгаа бүрэн гүйцэт бүрдээгүй байгааг тод харуулах жишээ юм.

³³ Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Ц.Сарантуяа. “Эрх зүй” сэтгүүл. УБ, 1/2000 он. 23 дахь талаас үзнэ үү.

³⁴ Хүний эрхийг шууд хэрэгжих шинж чанартай (*self-executing*), эсхүл шууд хэрэгжих шинж чанаргүй (*non-self executing*) гэж үзэх нь бий. Өөрөөр хэлбэл, шууд хэрэгжих шинж чанартай гэдэг нь мөрдлөг болгохуйц тов тодорхой “заалт” гэсэн үг. Энэхүү “шууд хэрэгжих” чанар нь хүний эрхийг хангахын тулд хууль тогтоогчоос заавал хэм хэмжээ тогтоосон акт батлан гаргах шаардлагагүй гэсэн утгатай бөгөөд өөрөөр хэлбэл: шүүгчид хүний баталгаажуулсан эрхийг

Б/ субъектийн хүрээнд

1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гол арга болох тайван жагсаал, цуглаан хийх эрхийг дотор нь:

1.2. Тайван жагсаал, цуглааныг санаачлах эрх;

1.3. Тайван жагсаал, цуглааныг зохион байгуулах эрх;

1.4. Тайван жагсаал, цуглаанд оролцох эрх гэж гурав ангилан авч үзэж болно.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Монгол улсын иргэн дээр дурьдсан 3 эрхийг бүгдийг нь эдлэх эрхтэй. Харин хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд зөвхөн оролцох эрхтэй байхаар заажээ.

Энэхүү зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзвэл, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад зааснаар хүн бүр /ямар улсын иргэн байхаас үл хамааран хүн бүр/ тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Монгол Улсын үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан “Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.” гэснийг хөндөж байна.

Үндсэн хуульд заасан агуулгаар авч үзвэл гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм зэрэг Монгол Улсын төрийн дотоод хэрэгтэй холбоотой асуудал, мөн улс төрийн шинжтэй асуудлаар тайван жагсаал, цуглаан хийх явдлыг улс, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хуулиар зохих хязгаарлал тогтоож болох тухай заасан гэж ойлгож байна.

Харин гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн өөрийн хөндөгдөж, зөрчигдөж буй эрх, эрх чөлөө, ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор, үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийхийг санаачлах, зохион байгуулах эрх нь нээлттэй байх учиртай. Энэ асуудал нь мэдээж улс, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг алдагдуулахуйц ноцтой зүйл биш. Иймд энэ хоёр асуудлыг зааг ялгаатай тогтоох замаар гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг сэргээн баталгаажуулах нь зүйтэй юм.

2. Монгол Улсын хууль тогтоомжоор цагдаа, төрийн тусгай хамгаалалтын албан хаагч, цэргийн албан хаагч, шүүгч, прокурор, Хүний эрхийн үндэсний Комиссын гишүүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд тодорхой хязгаарлалт тогтоосон байна. Энэхүү хязгаарлалтыг хоёр түвшинд авч үзвэл,

2.1. үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандах нь:

Монгол улсын шүүхийн тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай, Прокурорын байгууллагын тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд шүүгч, Хүний эрхийн үндэсний

Комиссын гишүүн, прокурор, цагдаагийн албан хаагч “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.” гэж заасан байдаг.

Хэдийгээр “жагсаал, цуглаан” гэсэн зүйл байхгүй байгаа ч энэхүү нийтлэг зарчим нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нэг арга болсон тайван жагсаал, цуглаан хийх эрхэд хамаарна.

Энэ зохицуулалт нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд тодорхой, зүй ёсны хязгаарлалт тогтоосон хэрэг мөн гэж үзэж болно. Гэхдээ шүүгч, прокурор, цагдаагийн албан хаагч, хүний эрхийн үндэсний комиссын гишүүн нь тайван жагсаал, цуглаан хийх эрхтэй бөгөөд шууд хориглосон зүйл байхгүй байна.

2.2. тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хориглосон нь:

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн тусгай хамаалалтын тухай хуулийн 17 дугаар зүйлд тус тус цэргийн албан хаагч, төрийн тусгай хамгаалалтын алба хаагч жагсаал, цуглаан хийхийг шууд хориглосон байна. Тухайлбал,

- Цэргийн албан хаагч нь захирагч, даргын зөвшөөрөлгүй цэргийн дүрэмд зааснаас бусад жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хориглоно.
- Төрийн тусгай хамгаалалтын албан хаагч нь удирдах байгууллага, захирах даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, албан үүргийн бус шугамаар тэдгээрт оролцох, байлцахыг хориглоно гэж тус тус заасан.

Жагсаал, цуглаан хийх эрхийг шууд хориглож буй байдалд болгоомжтой хандах үүднээс цаашид хориглож буй үндэслэл, хүрээг нарийн тодорхой заах шаардлагатай юм.

В/ Жагсаал, цуглаан хийх зорилгын хүрээнд

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар дор дурьдсан зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглосон байна. Үүнд:

1. дайн сурталчлах;
2. үндэстэн, ястны хооронд хагарал гаргах;
3. үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаврлан гадуурхах;
4. аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах;
5. төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;
6. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох;

7. хуулиар хориглоогүй анх зохион байгуулагдсан жагсаал, цуглааны явцад түүний зорилго өөрчлөгдөж дээр дурьдсан агуулга, шинжтэй болбол уг жагсаал, цуглааныг цаашид үргэлжлүүлэхийг хориглох тухай заажээ. Эдгээр нь хүний эрхийн түгээмэл тунхаглал,

иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан тайван жагсаал, цуглааныг хязгаарлах шалгуурын үүднээс авч үзвэл түүнтэй нийцэж байна.

Г/ онцгой нөхцөл байдлын хүрээнд

Жагсаал, цуглаан хийх журмын хуульд зааснаар дараахь онцгой нөхцөл байдалд жагсаал, цуглаан хийхийг хориглож байна. Тухайлбал,

1. Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг,

2. Зохиох журмын дагуу зөвшөөрөгдсөн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийхийг тус тус хориглохоор заасан.

Гэхдээ онц болон дайны байдал зарласан шалтгааныг эсэргүүцэх, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үр дагаврыг арилгах зорилгоор зохион байгуулах цуглааныг хориглоогүй байна.

Тайван жагсаал, цуглаан түүний эрх зүйн баталгаа ба хариуцлага

Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн хууль зүйн баталгааг хуульд дараахь байдлаар заажээ. Уг хуулийн 6 дугаар зүйлд хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхах, жагсаал, цуглааны хийхэд зориуд саад учруулах, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тараахыг хориглосон байна. Мөн 15 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “жагсаал, цуглааныг хууль бусаар тараасан болон хууль бусаар зөвшөөрөл олгоогүйгээс зохион байгуулагч, оролцогч, байгууллага, иргэдэд учирсан хохирлыг төр хариуцна.” гэж заасан.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг мөрдөн мөшгөсөн, эрх чөлөөг нь хязгаарласан, аливаа хэлбэрээр гадуурхсан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2000-50.000, албан тушаалтанд 5000-50.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.” гэж заажээ, харин судалгаа хийж үзэхэд, нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхэд 1994-2003 онд, Сүхбаатар дүүргийн шүүхэд 1992-2003 онд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай шийтгэвэрийг шүүж үзэхэд дурьдсан зүйлээр захиргааны хариуцлага хүлээсэн иргэн, албан тушаалтан байхгүй байна.

Харин 2002 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүх Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсээс ирүүлсэн “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөний тэргүүн, дээд боловсролтой, багш мэргэжилтэй, Э.Бат-Үүлд холбогдох материалыг хянан захиргааны шийтгэл оногдуулах тухай 1059 тоот шийтгэвэр гаргажээ.

Шүүх “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөнийн тэргүүн Э.Бат-Үүлийн 2002 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” жагсаал, цуглаан нь Монгол Улсын жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн болох нь тогтоогдож байна гэж үзэн, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3-д зааснаар “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөний тэргүүн Э.Бат-Үүлийг 25.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

Мөн дүүргийн шүүхээс 1998 оны 6 дугаар сарын 12-ны өдөр иргэн А нь 1998 оны 6 дугаар сарын 11-ний өдөр согтуугаар Сүхбаатарын талбай дээр суулт хийж байсан хүмүүс дээр очиж агсан тавьж, айлган сүрдүүлж иргэн Б-г цохиж танхайрсан байх тул Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар 7 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулжээ.

1994 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхээс “Тэмүүжин Менч” компанид оёдолчин, эмэгтэй, Чөлөөт ҮЭ-ийн гишүүн Г, С нарыг 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдөр үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хууль бусаар зогсоход нөлөөлж ажилчдыг цуглуулж яриа хийхэд оролцож, танхайрсан гэж үзэн, тус бүр 2000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

Монгол Улсын 2002 оны 9 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хуулийн 132 дугаар зүйлд “жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих” гэсэн гэмт хэргийн талаар заасан юм. Судалгаа хийж үзэхэд 2002 оны 9-12 сар, 2003 онд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн шүүхэд энэ зүйл ангиар хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд 1995 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 15 дугаар зүйлд дараахь байдлаар, үндсэндээ торгох шийтгэлийн хэмжээнд өөрчлөлт оржээ.³⁵ Үүнд:

№	өөрчлөлт орсон хуулийн зүйл, заалт, хэсэг	өөрчлөлт орохын өмнө	орсон өөрчлөлт
1.	15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээгэхээргүй бол 1000-25.000 гэснийг	иргэнд эрүүгийн хариуцлага хүлээгэхээргүй бол 2000-50.000, албан тушаалтанд 5000-50.000
2.	2 дахь хэсэг	25.000 хүртэл гэснийг	100.000-250.000
3.	3 дахь хэсэг	10.000-25.000	20.000-50.000
4.	4 дэх хэсэг	Этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээгэхээргүй бол 10.000-25.000 гэснийг	Байгууллагад 150.000-250.000 төгрөгөөр торгох, эрүүгийн хариуцлага хүлээгэхээргүй бол иргэд 20.000-50.000, албан тушаалтанд 25.000-50.000
5.	5 дахь хэсэг	15.000 хүртэл гэснийг	10.000-30.000
6.	6 дахь хэсэг	10.000-25.000 гэснийг	20.000-50.000
7.	7 дахь хэсэг	10.000-25.000 гэснийг	20.000-50.000

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх бөгөөд жагсаал, цуглаан зохион байгуулагч иргэн, улс

³⁵ “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 1995 оны 5-6 сар, №5-6 /36-37 дахь тал/

төрийн нам, олон нийтийн байгууллага тогтоосон журам зөрчсөн тохиолдолд торгох, баривчлах хариуцлага хүлээлгэх тухай заажээ. Харин зарим нэг хязгаарлалт нь үндэслэл муутай байна. Үүнд:

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д “Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно.”, 15 дугаар зүйлийн 4-д “гудамж, талбайд хөндлөнгөөс зориуд өлсгөлөн зарлахыг уриалсан буюу зохион байгуулсан гэм буруутай байгууллага, иргэн, албан тушаалтан”-д хариуцлага хүлээлгэх тухай тус тус заажээ.

Иргэд олон аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй, түүний нэг нь өлсгөлөн зарлах явдал юм. Өлсгөлөн зарлаж буй иргэд өөрсдийн тавьж буй санал, шаардлагыг дэмжиж буй иргэдийг үзэл бодлоо илэрхийлэн тэмцэхийг уриалж, тэдний дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах, хамтран тэмцэх явдлыг хориглох ёсгүй юм.

Харин өлсгөлөнд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, шахалт дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр албадах явдлыг хориглох нь зүйтэй. Иймд асуудлыг ялгавартай тогтоох хэрэгтэй байна.

Жагсаал, цуглаан хийх эрх түүний олон улсын жишиг

АНУ-ын Үндсэн хууль түүнд орсон анхны нэмэлтэд “Засгийн газарт хандаж санал гомдлоо барагдуулах тухай өргөх бичиг барьж тайван жагсаал, цуглаан хийх ард түмний эрхийг хязгаарласан нэг ч хуулийг Конгресс гаргах ёсгүй.” хэмээн анх удаа Үндсэн хуулийн хэмжээнд тайван жагсаал, цуглаан хийх эрхийг баталгаажуулсан байдаг.

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд “тайван замаар цуглаан хийх эрхийг зөвшөөрнө. Энэ эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд улсын буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсвэл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт байж болохгүй”, мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлд “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг дэг журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалтад л захирагдана.” гэж заасан.

Монгол Улсын үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан хүний эрхийг хязгаарлах нийтлэг үндэслэлийг жагсаавал:

	Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар	Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад зааснаар:	Эдгээрийг нэгтгэн авч үзвэл
1.	Хүний эрх	Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол, алдар хүнд	Бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхол /хүний нэр төр, алдар хүнд/
2.	Хүний нэр төр, алдар хүнд	Хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун	Хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун
3.	Улсыг батлан хамгаалах	Нийгмийн аюулгүй байдал	Улсыг батлан хамгаалах
4.	Үндэсний аюулгүй байдал	Улсын аюулгүй байдал	Улс, нийгмийн аюулгүй байдал

5.	Нийгмийн хэв журам	Нийгмийн хэв журам	Нийгмийн хэв журам
----	--------------------	--------------------	--------------------

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг ямар үндэслэлээр хязгаарлах вэ ?, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгэмд амин чухал, түүний хөгжил дэвшил, сайн сайхан, түүнчлэн хүний бусад эрх, үндсэн эрх чөлөөг эдлэхэд зайлшгүй шаардлагатай хэмээн олон улсын ба бүс нутгийн эрх зүй, хүний эрхийг хамгаалах жишиг, олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн ерөнхий зарчмуудад үндэслэн Йоханнесбургийн зарчмуудыг 1995 оны 10 дугаар сард “19-р зүйл” байгууллага, Хэвлэлийн цагдан хяналтын эсрэг олон улсын төв, олон улсын эрх зүй, үндэсний аюулгүй байдал, хүний эрхийн мэргэжилтнүүдээс Йоханнесбург дахь Витвотерсрэндын Их сургуулийн салбар эрх зүйн төвтэй хамтран баталсан байна.

Уг зарчимд /1-р зарчим/ зааснаар “Хүн бүр үзэл бодлоо хөндлөнгийн оролцоогүй илэрхийлэх эрхтэй...эрхийг эдлэхэд олон улсын эрх зүйгээр тогтоосон тодорхой үндэслэлээр, түүний дотор үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндэслэлээр хязгаарлаж болно...Засгийн газар хязгаарлалтыг хуулиар тогтоох бөгөөд тэр нь ардчилсан нийгэмд үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалахад шаардлагатай гэдгийг нотолж чадсанаас бусад тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гэсэн шалтгаанаар хязгаарлалт тогтоож болохгүй. Хязгаарлалт үндэслэлтэй болохыг нотлох үүргийг засгийн газар хүлээнэ.” гэж заасан нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах нэг гол үндэслэл бол үндэсний аюулгүй байдлын хууль ёсны сонирхлыг хамгаалах явдал юм гэдгийг онцлон үзжээ. Мөн 7-р зарчимд “үзэл бодлоо тайван байдлаар илэрхийлснийг үндэсний аюулгүй байдалд аюул учруулж байна гэж үзэх, аливаа хориглол, шийтгэл хүлээлгэж болохгүй”³⁶ заасан.



III хэсэг

Олон нийтийн санал бодлыг судалсан тухай тайлан

³⁶ “Глоб интернейшнл” ТББ, Йоханнесбургийн зарчим, “Олон нийтийн мэдэх эрх ба мэдээллийн эрх чөлөө”, гарын авлага, УБ, 2002 он, 52-54-р тал

3.1. Жагсаал, цуглаан хийх эрхийн талаар олон нийтийн санал бодлыг тандах зорилгоор зарим аймаг, сумдын иргэд, эрх бүхий байгууллагын албан хаагч нартай уулзаж ярилцан, 2004 оны 2 дугаар сарын 9-нд Улаанбаатар хотод ХЗДХЯ, Нийслэл болон Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар, ЦЕГ-ын нийгмийн хэв журам хамгаалах газар, Ардчилсан нам, МАХН, МҮЭ зэрэг 20 гаруй байгууллагын төлөөлөгч нарын оролцуулсан “Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө” сэдэвт уулзалт ярилцлага зохион байгуулан, санал асуулга явуулсан болно.

Уулзалт ярилцлагаар жагсаал, цуглаан хийх эрхийн талаар оролцогчид өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэн идэвхтэй оролцсон юм.

3.2. Уулзалт-ярилцлагад оролцсон хүмүүсийн ихэнх нь зөвшөөрлийн тогтолцоог хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байна гэж үзэж байгаагаа илэрхийлж байв. Тухайлбал, Ардчилсан Намын ажилтан, хуульч Ц.Энхцэнгэл: “Зөвшөөрөл өгөх механизм нь хүний эрхийг хязгаарлах нэг хүчин зүйл болдог...зөвшөөрөл авахад тодорхой хугацаа шаарддаг”, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, хуульч Д.Чилхаажав: “...зөвшөөрөл өгөх тухай асуудал нь эрх чөлөөг хязгаарлаж байна. Тайван жагсаал, цуглаан хийх тухайгаа мэдэгдэх нь хангалттай.”, “Хүний эрх ба хөгжил” төвийн ажилтан, хуульч Д.Цэнд-Аюуш: “Зөвшөөрлийн механизм буруу байна. Зөвшөөрлийг болиулах нь зүйтэй, би таны эсрэг юм хэлье, зөвшөөрөөч гэж гуйх нь утгагүй хэрэг.” гэсэн бол Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын төрийн захиргаа, хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн, хуульч Ц.Ижилмөрөн: “Зөвшөөрөл өгдөг, авдаг байх нь ямар нэг хэмжээгээр хэрэгтэй. Машин зам сааталтай байдаг. Аваар осол гарах нь элбэг. Жагсаал, цуглааны үед нийтийн эмх замбараагүй байдал үүсэх нь элбэг байдаг. Үүнээс урьдчилан сэргийлэх ёстой.”, ЦЕГ-ын нийгмийн хэв журам хамгаалах газрын дарга, хурандаа Ц.Бумнанжид: “Хамаагүй зөвшөөрөл өгдөггүй гэж яриад байж болохгүй. Жагсаал, цуглаан зохион байгуулахтай хамт зохицуулах өөр бусад өчнөөн асуудал байдаг. Цагдаагийн байгууллага өнөөг хүртэл хуулийн хүрээнд л ажиллаж ирсэн, ямар нэг хуулийн заалтыг зөрчиж байгаагүй. Цагдаа төрийн үйлчилгээ, албадлага гэсэн 2 чиг үүргийг гүйцэтгэж ажилладаг онцгой байгууллага.” хэмээн санал бодлоо илэрхийлжээ.

Харин “Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн”-гийн хуулийн хөтөлбөрийн шинжээч Д.Ламжав: “хэрвээ зөвшөөрөл байвал, нэгдүгээрт: хугацааг нь богинсгох шаардлагатай. Хугацаандаа хариу өгөөгүй бол зөвшөөрсөн гэж үзэх хэрэгтэй. Татгалзсан хариу өгөх үндэслэлийг хуульд тодорхой заах хэрэгтэй. Ийм үндэслэл нь Үндсэн хууль, нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцэд нийцсэн байх ёстой.”, Ц.Оюунтунгалаг: “Одоогийн мөрдөж байгаа зөвшөөрлийн тогтолцооны хувьд цаг хугацаа алддаг, үүнтэй холбоотой зөвшөөрөлгүй жагсаал, цуглаан хийх үзэгдэл байдаг. Зөвшөөрөлгүй хийж байгаа жагсаал, цуглааныг тараах нь манай мөрдөж байгаа хуулиар бол зөв хэрэг. Хөдөлмөрийн хуульд “ажил хаялт зохион байгуулж байгаа үед үйлдлээ дэмжих зорилгоор жагсаал, цуглаан зохион байгуулж болно” гэж заасан байдаг. Харин жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар “аж ахуй нэгж байгууллага, тэдгээрийн ажилчдаас зохион байгуулж байгаа байгууллагын үндсэн үйл

ажиллагаатай холбоотой жагсаал, цуглаанд энэ хууль үйлчлэхгүй” гэсэн заалт байдаг. Энэ хоёр зүйл заалтын холбоо хамаарлыг харах нь зүйтэй.” гэв.

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг Даргын Тамгын газрын дарга Д.Сайнбилэг: “Жагсаал, цуглаан хийхэд захирамж гардаггүй. Албан тоотоор хариу зөвшөөрөл өгдөг. Албан байгууллагууд албан бичгээр хүсэлтээ тавьдаг, манайх хариу болгож зөвшөөрлөө цаг хугацааг нь заагаад албан бичиг өгдөг, зарим үед амаар зөвшөөрөл өгдөг.” гэсэн бол тус аймгийн Ардчилсан намын гишүүн А.Баяр: “2001 онд манай намаас төв талбайд цуглаан зохион байгуулах гээд зөвшөөрөл хүссэн боловч өгөөгүй, зөвхөн Драмын театрын өмнө хийх зөвшөөрөл өгсөн, зарим хүмүүсийн яриагаар бол аймгийн засаг дарга улс төрийн шинжтэй жагсаал, цуглааныг төв талбайд хийлгэхгүй байх бодлого барьж байгаа гэсэн” гэж ярьсан юм.

3.3.Уулзалт-ярилцлагаар оролцогчдын анхаарал татсан нэг асуудал бол зөвшөөрлийн тогтолцооноос гадна Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглосон тухай асуудал байв. Тухайлбал, НҮБ-ын зөвлөх Ван Хи Ли: “Нэгэнт тайван замаар жагсаал, цуглаан явуулна гэж зарласан бол үүнд ямар нэг хязгаарлалт хийх хэрэггүй юм. Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглосон хориглолт нь нэлээд сонирхол татахуйц юм. Хэдийгээр улс орны аюулгүй байдал, нийтийн дэг журмын үүднээс ийм хязгаарлалт тогтоох нь зүйн хэрэг ч бид энэ ярилцлагын үр дүнд зарим нэг зүйл дээр хязгаарлалт тогтоох шаардлагагүй байгааг олж харна байх гэж итгэж байна. Талбайн хувьд төрийн ордноос тодорхой зайд жагсаал, цуглаан хийхийг хориглоод, цагдаагийн байгууллагын ажилтнууд зөвхөн тэр хэсгийг л хамгаалдаг байх нь зохистой гэж үзэж байна.”

“Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн”-гийн хуулийн хөтөлбөрийн шинжээч Д.Ламжав: “асуудал зөвхөн Сүхбаатарын талбайтай ч холбоотой биш, аймгийн засаг даргын тамгын газруудын үүдний талбай, сумдын индэртэй ч холбоотой. Зөвхөн тухайн байгууламжаас 50 метрийн зайтай л жагсаж, цуглахыг хориглоно гэвэл болно...ямар нэг талбайд Монгол Улсын Үндсэн хууль үйлчлэхгүй болно гэдэг утгагүй.” гэсэн бол сэтгүүлч Г.Жамъян: “Манай улсад зохион байгуулж байгаа жагсаал цуглаан хор аюулын хувьд хамгийн аюулгүй зүйл. Үүнийг эрх мэдэлтнүүд хамгийн аюултай зүйл болгож сүржигнээд байна. Хуульд оруулах 2 санал байна. Нэгдүгээрт, жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл өгдөг байдлыг больё, зөвхөн мэдэгддэг больё, хоёрдугаарт, жагсаал, цуглааныг зөвхөн Сүхбаатарын талбайд хийдэг больё, Төрийн ордоноос 20 метрийн зайтай л жагсаал, цуглаан явуулдаг больё.” гэхэд Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын хуулийн зөвлөх А.Нэргүй: “бидний уулзалт ярилцлага үзэл бодлоо илэрхийлэх асуудал биш зөвхөн Сүхбаатарын талбайн асуудал уруу хэтэрхий ороод байна.

Урьд нь бид ийм жагсаал, цуглааныг боройхойдож тараасан гэсэн асуудалд орж байсан хэдий ч энэ үйлдлээ тодорхой хуулийн хүрээнд ажилласан гэж үзэж байгаа. Захиргааны байгууллага зөвхөн хуулийн заалтаа л хэрэгжүүлж байсан. Гэхдээ Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийх эрхийг зөвшөөрөх нь зарим нэг сөрөг үр дагавартай гэж үзэж

байна. Монголчууд төрөө дээдэлдэг ард түмэн, өлсгөлөн, суулт хийж байгаа хүмүүс тэр газар орчиндоо ялгадасаа гаргах ч юм уу, өөр янз бүрийн зүйл хийж л байгаа. Гэхдээ төрт ёсны хүндэтгэлийн арга хэмжээ болдог талбайд ийм зүйл зөвшөөрөх нь зохисгүй. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг эргэж харах цаг болсон. Үүн дээр санал нэг байна. Ялангуяа Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын хувьд нэг талаас хүний эрхийг зөрчөөд байгаа мэт боловч, нөгөө талаас нийтийн дэг журмыг хангах гэсэн хоёрдмол асуудал байнга гарч ирээд байдаг.” Г.Халтар: “Би Шведэд байхдаа жагсаал, цуглаан хийх асуудал ямар зохицуулалтай байдаг талаар сонирхож байсан. Манайх шиг ийм хатуу зохицуулалтгүй юм байна лээ. Төр, цагдаа зөвхөн хөндлөнгийн ажиглагчийн үүргийг гүйцэтгэдэг. Харин нийтийн дэг журам зөрчих тохиолдолд хүч хэрэглэдэг. Жагсаал, цуглаан хийх, нийгмийн хэв журам хангах гэсэн 2 асуудлыг ялгах шаардлагатай. Олон улсын гэрээнүүдийг баримтлан хязгаарлалтуудыг багасгах хэрэгтэй. Манайд энэ асуудал зохицуулалтын механизмаа олоогүй байна. Хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг бид дэмжиж байна. ХЭҮК-оос ийм арга хэмжээг зохион байгуулж байгаад талархаж байна гэдгийг хэлье.” гэжээ.

3.4. Тайван жагсаал, цуглаан хийх эрхийн төлөв байдал, олон нийтийн санал бодлыг тандах үүднээс 26 хүнийг хамарсан санал асуулга явуулсан болно. Санал асуулгад оролцсон хүмүүсээс:

Хүйс:

Эрэгтэй - 9

Эмэгтэй –17

Боловсрол:

Дээд боловсролтой – 24

Бүрэн дунд боловсролтой – 2

Ажил, мэргэжил:

Төрийн байгууллагад ажилладаг - 5

ТББ ажилладаг- 13

Хувийн хэвшилд ажилладаг - 2

Улс төрийн намд ажилладаг - 6



Судалгаанд оролцсон хүмүүс “Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан хийхийг хуулиар хориглосон байдаг. Та үүнийг юу гэж үздэг вэ ?” гэсэн асуултад “буруу” гэж 16, “зөв” гэж 8, “мэдэхгүй” гэж 2 хүн тус тус хариулжээ. “Буруу” гэж хариулсан хүмүүс үндэслэлээ “уг талбайд жагсаал, цуглаан хийх нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдалд муугаар нөлөөлөхгүй”, “уг талбай эрх чөлөөний индэр байх ёстой”, “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэж тайлбарлаж байна.

Мөн судалгаанд оролцсон хүмүүсээ “Жагсаал, цуглаан зохион байгуулахад нийслэл болон дүүргийн засаг даргаас зөвшөөрөл авдаг. Та тайван жагсаал, цуглаан зохион

байгуулахад зөвшөөрөл авах шаардлагатай гэж үзэж байна уу?” гэсэн асуултад “шаардлага байхгүй” гэж 16, “шаардлагатай” гэж 10 хүн тус тус хариулсан байна.

“Шаардлага байхгүй” гэж үзсэн хүмүүс “үндсэн хуульд заасан эрх чөлөөгөө эдлэхдээ зөвшөөрөл авах ёсгүй”, “зөвшөөрлийн бус бүртгэлийн тогтолцоо байх нь зүйтэй”, “зарим үед зөвшөөрөл авах шаардлага байж болно” гэх зэргээр хариулжээ.

Дүгнэн үзвэл, уулзалт ярилцлагад оролцсон хүмүүсийн нилээд нь зөвшөөрлийн тогтолцоонд шүүмжлэлтэй хандаж байгаагаа илэрхийлэн, цаашид бүртгэх, мэдэгдэх зарчимаар тайван жагсаал, цуглаан хийх эрхээ эдлэх боломжтой төдийгүй ийм хэрэгцээ шаардлага байна хэмээн үзэв. Зарим тохиолдолд зөвшөөрөл авч болох боловч зөвшөөрөл өгөх хугацаа нь богино байх ёстой гэдэгтэй санал нэгдэж байв.

Мөн Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан хийхийг хориглосон асуудлыг хөндөн ярилцаж, хориглож буй үндэслэлийн талаар өөр өөрсдийн байр суурийг илэрхийлсэн юм. Сүхбаатарын талбай дээр жагсаал, цуглаан хийх явдлыг хориглож байгаа нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй хэрэг болно. Төрийн ордны аюулгүй байдлыг хангах үүднээс түүний нутаг дэвсгэрээс 20-50 метрийн зайд уг эрх чөлөөгөө эдлэх боломжтой. Иймд Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийх эрхийг бүхэлд нь хориглосон нь үндэслэл муутай хэмээн үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Дүгнэлт, санал

Нэг.Ерөнхий зүйл:

1. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь өөртөө хэд хэдэн эрхийг багтаасан “багц” эрх, эрх чөлөөний бүрдэл бөгөөд Монгол Улсын Олон Улсын гэрээ, Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тодорхойлон баталгаажуулсан 10 гаруй үзэл бодлоо илэрхийлэх эрх байдаг. Гэвч үзэл бодлоо илэрхийлэх эрх нь дурьдсан 10 гаруй эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд хүн бүр өөрийн сонгосон аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь хүний үзэл бодлоо илэрхийлэх нэг гол арга юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хүний эрх төдийгүй нийгмийг төгөлдөржүүлэх гол хэрэгсэл, иргэний нийгэм, ардчилалын тулгуур баталгаа болно.

2. Монгол Улс дахь тайван жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн орчны талаар дагнан хийсэн судалгаа, шинжилгээний бүтээл харьцангуй цөөн байгаа нь уг сэдэв харьцангуй бага судлагдсан болохыг илтгэх аж. Монгол Улсад хүний эрхийг хангах төслөөс 2001 онд Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлын судалгааг хийсэн бөгөөд судалгааны үр дүнд жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг эргэн харж нягтлах цаашид боловсронгуй болгож, сайжруулах зүйл багагүй байгаа талаар тодорхой дүгнэлт хийж, санал дэвшүүлжээ.

3. Нийслэл болон СБД, ЧД, БГД, ХУД, БЗД-т 1998-2003 онд жагсаал, цуглаан 143, 1989-2003 онд Монгол Улсын 18 аймагт жагсаал, цуглаан 160, нийт 301 жагсаал, цуглаан болжээ. Нийслэл болон СБ, ЧД, ХУД-ийн Засаг Даргын Тамгын газарт иргэд, байгууллагаас мөн хугацаанд жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл хүссэн 165 хүсэлт ирүүлсэнээс 141 хүсэлтэд зөвшөөрөл өгч, 21 хүсэлтэд татгалзсан хариу өгчээ. Энэхүү татгалзсан 21 шийдвэрийн 12 шийдвэрийг судлан үзэхэд 4 шийдвэр нь хууль зүйн хувьд үндэслэл муутай байжээ. Энэ хугацаанд 3 жагсаал, цуглаан зөвшөөрөлгүй хийгдсэнээс 2-ыг нь албадан тараасан байна. Төв, Баян-Өлгий, Өвөрхангай аймгуудад тус бүр 2 удаа жагсаал, цуглаан хийх хүсэлтэд татгалзсан хариу өгч, Төв, Баян-Өлгий аймагт тус тус 2 жагсаал, цуглааныг албадан тараасан тохиолдол гарчээ.

Хоёр. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн талаар:

1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь өнөөдөр 10 дахь жилтэйгээ золгож байгаа ч өнгөрсөн хугацаанд хүний эрх, эрх чөлөөг хангахуйц зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй бөгөөд тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний эрх зүйн баталгааг боловсронгуй болгох үүднээс уг хуулийг эргэн харах цаг нэгэнт болсон гэдэг нь энэхүү судалгааны тайлангаас тодорхой харагдаж байна. Уг хуульд 1995 онд зөвхөн торгуулийн хэмжээг нэмэх төдийхөн өөрчлөлт орсон юм. Иймд хуульд зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулах бус, бүхэлд нь шинэчлэн найруулах саналыг дэвшүүлж байна.

Судалгаагаар энэ хуульд дор дурьдсан үндэслэл муутай хязгаарлалт, хийдэл, согог үзэгдэнэ. Үүнд:

2.1.Хуулиар “цуглаан” гэдгийг үзэл бодол, санал, шаардлага нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа **“үйл ажиллагаа”** гэж хэт өргөн хүрээтэй тодорхойлсон нь үзэл бодлоо илэрхийлэх бусад олон аргыг “цуглаан” гэж ойлгоход хүргэж байна. Уг тодорхойлолтоор бол үзэл бодлоо нийтэд илэрхийлэн суулт, өлсгөлөн, ажил хаялт зохион байгуулж буй нь “үзэл бодол, санал, шаардлага нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаа” учраас “цуглаан” гэдэгт хамаарах болж байгаа юм. Иймд “цуглаан” гэсэн нэр томъёог бусад үзэл бодлоо илэрхийлэх арга, хэлбэрээс ялгавартай, оновчтой тодорхойлох шаардлага байна.

2.2.Хуулиар Монгол Улсад иргэд, төрийн бус байгууллага, улс төрийн нам, хөдөлгөөнөөс тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад зөвшөөрлийн журам үйлчилж, харин төр, түүний эрх бүхий байгууллагаас хийх жагсаал, цуглаанд зөвшөөрөл авахгүй, хууль үйлчлэхгүй байх хэт ялгавартай байдал тогтжээ. Иймд ялгавартай байдлыг арилгах, иргэд, төрийн бус байгууллагаас жагсаал, цуглаан хийх эрх чөлөөгөө эдлэх боломжыг хөнгөвчлөх үүднээс зөвшөөрлийн болон бүртгэлийн тогтолцоог аль алиныг нь хослуулан хэрэглэх шаардлага байна.

2.3. Хуулиар улс төр, эдийн засаг, нийгэм, хүний эрхийн тулгамдсан чухал асуудлаар өөрсдийн үзэл бодлоо тайван жагсаал, цуглаан хийх замаар богино хугацаанд /1-3 хоногийн дотор/ илэрхийлэх боломж байхгүй байна. Нэгэнт асуудал үүссэн бол түүнийг олон нийтийн эрх ашиг, олон нийтийн мэдэх эрхийг хангах үүднээс нэн даруй олон нийтэд үзэл бодлоо илэрхийлэн, тухайн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах учиртай. Угаас жагсаал, цуглаан нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлын эсрэг зүйл биш, энэ нь үндсэн эрхийн асуудал тул хүн өөрийн үндсэн эрх чөлөөгөө эдлэхийн тулд 6 хүртэл хоног “хүлээх” нь “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэсэн Монгол Улсын үндсэн хуулийн заалттай нийцэхгүй байна. Үндсэн хуулийн “чөлөөтэй” гэдэг үг нь зүй бус албадлага, хязгаарлалтаас ангид байх гэсэн санааг илэрхийлэх бөгөөд цаг хугацааны хувьд нэн даруй, түүгээр үл хязгаарлагдан үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй гэсэн үг юм.

2.4.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлд жагсаал, цуглааныг зохион байгуулагч, санаачлагч нь жагсаал, цуглаан хийх газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээж, 15 дугаар зүйлийн 6-д нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангаагүй бол хариуцлага хүлээлгэх тухай заажээ. Жагсаал, цуглаан хийх нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлд “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” хэмээн эрхийг хэн эдлэх, дэг журмыг хэн хангахыг ялгавартай, тодорхой заажээ.

Иймд жагсаал, цуглаан зохион байгуулагч нь жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам хангах үүргийг хүлээх ёсгүй юм.

2.5. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд зөвхөн оролцох эрхтэй байхаар тогтоожээ. Үндсэн хуульд заасан агуулгаар авч үзвэл гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм зэрэг Монгол Улсын төрийн дотоод хэрэгтэй холбоотой асуудал, мөн улс төрийн шинжтэй асуудлаар тайван жагсаал, цуглаан хийхийг улс, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хуулиар зохих хязгаарлалт тогтоож болох тухай заасан гэж ойлгож байна. Харин гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн өөрийн зөрчигдөж байгаа эрх, эрх чөлөө, ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийхийг санаачлах, зохион байгуулах эрх нь нээлттэй байх учиртай.

Иймд энэ хоёр асуудлыг зааг ялгаатай тогтоох замаар гадаадын иргэн, харьяалалгүй хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг сэргээн баталгаажуулах нь зүйтэй юм.

2.6. “Жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл олгохгүй байх үндэслэлийг засаг захиргаа тун амархан олдог” гэсэн ам дамжсан яриа зарим талдаа ортой байж магадгүй. Энэ нь зөвшөөрлийг Засаг дарга олгож байгаатай холбоотой. Учир нь Засаг дарга бол улс төрийн албан тушаалтан юм. Иргэдээс үзэл бодол, санал, шаардлагаа тайван жагсаал, цуглаан хийх замаар илэрхийлэн хандаж буй этгээд нь ихэвчлэн засаг захиргаа байдаг. Нэг үгээр хэлбэл өөрөөс нь зөвшөөрөл авч өөрт нь үзэл бодол, шүүмж, санал, шаардлагаа илэрхийлнэ гэсэн үг юм. Энэ нь мэдээж ашиг сонирхлын зөрчил ямар нэг хэмжээнд үүсгэнэ.

Иймд жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь өөрөө ашиг сонирхлын зөрчилгүй 3 дахь этгээд байх нь зүйтэй юм.

2.7. Нийслэл хотын Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглосон талаар:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар Монгол Улсын иргэн улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой сэдвээр Сүхбаатарын талбайд үзэл бодлоо илэрхийлэх замаар тайван жагсаал, цуглаан хийхийг шууд хориглож, харин бусад асуудлыг хөндөн үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан хийж болохоор тогтоожээ. Энэ нь Монгол Улсын иргэний үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ялгаварлан, хориг зааг тогтоож үзэл бодлоор ялгаварлан гадуурхсан хэрэг юм. Үзэл бодлын эрх, эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зайлшгүй шаардлагатай бус үндэслэлээр хязгаарласан байна.

Алив жагсаал, цуглаан нь улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй шууд болон шууд бус байдлаар холбогдоно. Энэ байдал нь тухайн жагсаал, цуглаан нь улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой, эсхүл холбоогүй гэж өөрийн үзэмжээр хандах боломжыг шийдвэр гаргагчид олгож байгаа нь нууц биш юм.

2. Тайван жагсаал, цуглаан нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдалд хохирол учруулах зорилго, санаа, сэдлээр хийгддэггүй бөгөөд түүний “эрхэм” зорилго, гол агуулга бол иргэд өөрсдийн үзэл бодол, санал, гомдол, шүүмж, шаардлагаа төр засагтаа илэрхийлэх, тухайн асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх, төр, түүний байгууллагын үйл ажиллагааг үнэлж, цэгнэсэн дүгнэлт, үг хэлэх эрх чөлөөгөө эдлэх зорилгоор зохион байгуулагддаг. Иймд Сүхбаатарын талбайд нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлж, зарим асуудлаар жагсаал, цуглаан зохион байгуулахыг шууд хориглож байгаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай үндэслэл болж чадахгүй байна. Тухайлбал:

-Сүхбаатарын талбай дээр тодорхой асуудал, зарим сэдвийг хөндсөн жагсаал, цуглаан хийх явдлыг нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлэн, шууд хориглож байгаа явдлыг угаас зарим асуудлыг хөндсөн жагсаал, цуглааны зорилгыг нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлын эсрэг зүйл мэт ойлгон дүгнэхэд хүргэж байна.

-Жагсаал, цуглаан хийх нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлд “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж заасныг иш болговол жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журмыг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах ажлыг төр хариуцан хийх юм.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалах, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй болохыг, Дотоодын цэргийн тухай хуулийн 10 дугаар зүйлд цагдаагийн байгууллагын хүч хүрэлцэхгүй үед тэдэнд туслах зорилгоор дотоодын цэрэг баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийгмийн хэв журмыг сахиулахад туслах талаар заасан байдаг.

- Зарим нэг жишээ дурьдвал, Англи улсад байрладаг, “19 дүгээр зүйл” байгууллагын хуулийн хөтөлбөрийн захирал Тоби Мендель ийм нэг жишээг ярьсан юм. Тэрээр “АНУ-д нацистууд еврейн хороолол, гудамжаар жагсаал хийх хүсэлтээ засаг захиргааны байгууллагадаа гаргажээ. Засаг захиргаанаас нацистуудад зөвшөөрөл өгөхөөс татгалзсан байна. Тэд татгалзсан үндэслэлээ нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс зөвшөөрөл олгоогүй гэж тайлбарласан байдаг. Харин нацистууд шүүхэд гомдол гарсан бөгөөд шүүх захиргааны шийдвэрийг хүчингүй болгож, нацистууд еврейн хороолол, гудамжаар жагсаал хийх эрхтэй гэж шийдвэрлэсэн байна. Шүүх нийгмийн хэв журмыг хангах нь засаг захиргааны байгууллагын үүрэг учраас, нацистууд жагсаал хийх үед энэ үүргээ засаг захиргаа гүйцэтгэх ёстой, түүнчлэн нацистууд, еврей нарын хоорондын дайсагнасан харьцаа дэлхийн 2 дайны үеийнх шиг хүчтэй биш гэж үзсэн байдаг.”

Үүний адил бид нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хэн хамгаалах ёстой вэ гэдгийг ялгаж, салган үзэх, жагсаал, цуглаан нь нийгмийн хэв журам, иргэдийн

аюулгүй байдлыг эсрэг зүйл бус, үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөө гэдгийг байнга санаж байхад илүүдэхгүй болов уу.

-Нийгмийн хэв журмыг хангах асуудлыг хүний эрх чөлөөтэй сөргөлдүүлэн, эл үндэслэлээр хүний эдлэх ёстой эрхийг хязгаарлах нь зохилтой биш. Нийгмийн хэв журмыг хүний эрх чөлөөнөөс дээрд үзэж хүний эрх, эрх чөлөөг зохих үндэслэлгүйгээр хязгаарлах нь дарангуйллын тогтолцоог санагдуулж байгааг нуух шаардлага алга гэж үзнэ.

-Жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах тухай асуудал нь яван явсаар нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс жагсаал, цуглаан хийх эрхийг хориглох болтолоо өнгөө хувиргажээ.

-Нэгэнт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн төр засаг нь жагсаал, цуглааны үед хэв журам хангах талаар ажиллах ёстой атал жагсаал, цуглаан хийх эрхийг хориглон байж, нийгмийн хэв журам хангах, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүргээ хялбар аргаар гүйцэтгэж байгааг зөвтгөх боломжгүй юм.

3. Жагсаал, цуглаан журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн УИХ-ын чуулганы тэмдэглэлийг судлан үзэхэд Сүхбаатарын талбай бол “Монгол Улсын төрийн төв байгууллага байдаг”, “Монгол Улсын зүрх болсон газар”, “Монгол Улсад ганц байдаг”, “Монголчуудын хайрлаж хүндэтгэж байх талбай” учир жагсаал, цуглаан хийхийг хориглох нь зүйтэй гэх зэргээр УИХ-ын гишүүд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж байжээ.

Сүхбаатарын талбай нь Монгол Улсын төв талбай, хайрлан хүндэтгэж байх учиртай зүйл, Монгол Улсад ганц байдаг, ариун нандин байх ёстой гэсэнтэй санал нэгдэх боловч энэхүү үндэслэл маань үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй зүйл хараахан биш юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад заасан хүний эрхийг хязгаарлах нийтлэг үндэслэлд хамаарахгүй байна.

Иймд Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар хориглосон нь үндэслэл муутай байх тул уг хуулийн 7 дугаар зүйлийн 2 нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцэд хандах боломжтой болно.

Гурав.Төрийн ордоны тухай хуулийн холбогдох зүйл, заалтын талаар:

3.1.УИХ-ын 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 16 дугаар тогтоолоор Монгол Улсын төрийн ордоны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг дор дурьдсанаар тогтоожээ. Үүнд:

1.Монгол Улсын Төрийн ордоны зүүн, баруун зүгт тус бүр 33 метр,

2.Монгол Улсын Төрийн ордноос урд, хойд зүгт тус бүр 80 метр хүртэлх орчин, нутаг дэвсгэрийг Төрийн ордоны нутаг дэвсгэрт тооцох тухай заасан байна. Төрийн ордоны нутаг дэвсгэрт ойролцоогоор Сүхбаатарын талбайн хоёр хуваасны нэг нь хамаарч байгаа юм. Төрийн ордоны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлэхийг хориглосон нь байна. Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх явдлыг бүхэлд нь хориглосон нь буруу гэж үзэж байна.

Төрийн ордон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хаасан “хаалттай бүс” байх ёсгүй. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлж байгаа хэрэг нь төрийн ордоны халдашгүй байдалд халдаж байгаа хэрэг огтхон ч биш юм.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, тайван жагсаал, цуглаан, өлсгөлөн зарлах, суулт хийх нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, төрийн ордоны халдашгүй байдлын эсрэг бус, төр засагт санал, шүүмж, шаардлагаа илэрхийлэх зорилготой, нөгөө талаар нийгмийг жолоодох, хянахад иргэний нийгмийн оролцох арга зам, нийгэм, төр, түүний байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж цэгнэх, ариусгахад болон хүн өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах гол арга зам юм. Төр засагт хандан үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлэх, үгээ хэлэх нь төрийн ордон, эрх баригч, шийдвэр гаргагч нарт хэдий чинээ ойр байх тусам үр дүнд хүрдэг билээ.

Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор тайван жагсаал, цуглаан хийх, өлсгөлөн зарлах, суулт хийх явдлыг хориглож байгаа үндэслэл нь тодорхой бус, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлага харагдахгүй байна. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй бол тийнхүү хязгаарлаж буй үндэслэлээ хуульд тодорхой заах учиртай. Монгол Улсын Үндсэн хуульд заасан “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх”-ийг бүхэлд нь хязгаарласан явдал нь асуудал төрийн ордоны хамгаалалт, үйлчилгээг журамлах хэр хэмжээнээс хэтэрсэн мэт. Иймд төрийн ордоны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-ийг хүчингүй болгох саналтай гаргаж байна.

Дөрөв.Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журмын талаар:

4.1.“Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журам”-ын хоорондоо зөрчилтэй байдлыг өөрчлөн, зарим ойлгомж муутай зүйлийг тодотгох, зөвшөөрөл авах жагсаал, цуглаан, арга хэмжээний хүрээг багасгаж, заримыг нь бүртгүүлэх, мэдэгдэх замаар хийх боломжыг бүрдүүлэх.

4.2.Нийслэлийн гудамж, талбайд спорт, урлаг, уран сайхан, баяр ёслолын болон тэдгээртэй адилтгах арга хэмжээг зохион байгуулах журамд заасан “аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажиллагсдаас тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар зохион байгуулж байгаа хурал, цуглаан, тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ”-г зохион байгуулахад уг журам үйлчлэх тухай заасныг хүчингүй болгох:

Тав.Хууль зүйн баталгаа

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Хуульд заасан журмын дагуу жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан, жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэнийг мөрдөн мөшгөсөн, эрх чөлөөг нь хязгаарласан, аливаа хэлбэрээр гадуурхсан иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 2000-50.000, албан тушаалтанд 5000-50.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.” гэж заажээ, харин судалгаа хийж үзэхэд, нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхэд

1994-2003 онд, Сүхбаатар дүүргийн шүүхэд 1992-2003 онд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн тухай шийтгэвэрийг шүүж үзэхэд дурьдсан зүйлээр захиргааны хариуцлага хүлээсэн иргэн, албан тушаалтан байхгүй байна. Монгол Улсын 2002 оны 9 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хуулийн 132 дугаар зүйлд “жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчих” гэсэн гэмт хэргийн талаар заасан юм. Судалгаа хийж үзэхэд 2002 оны 9-12 сар, 2003 онд Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн шүүхэд энэ зүйл ангиар хэрэг шүүхээр шийдвэрлэгдээгүй байна.

Товчилсон үгийн тайлал

АДХГЗ	Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаа
АДХТ	Ардын Депутатуудын Хурлын Тэргүүлэгчид
АХГЗ	Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргаа
АИХТ	Ардын Их Хурлын Тэргүүлэгчид
АЗХ	Ардчилсан Залуучуудын Холбоо
АЭХ	Ардчилсан Эмэгтэйчүүдийн Холбоо
БХЯ	Батлан Хамгаалах Яам
БНСРУ	Бүгд Найрамдах Социалист Румын Улс
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
МоАХ	Монголын Ардчилсан Холбоо
ШДХ	Шинэ дэвшилт холбоо
МОХ	Монголын оюутны холбоо
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
УДШ	Улсын Дээд Шүүх
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
МЭТНБХ	Монголын Энх Тайван Найрамдлын Байгууллагуудын Холбоо
БНБАУ	Бүгд Найрамдах Болгар Ард Улс
СБ	Сүхбаатарын талбай
МНХ	Монголын Нэгдсэн Хөдөлгөөн
МҮЭ	Монголын Үйлдвэрчний Эвлэл
УИХ	Улсын Их Хурал
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЦГ	Цагдаагийн газар
ЖЦХЖТХ	Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль

Нийслэлийн Засаг даргын тамгын газар

№	Он, сар, өдөр	Ямар байгууллага болох	Зөвшөөрөл		Зохион байгуулах газар	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн огноо, дугаар, цаг	Жагсаал, цуглааны нэр, сэдэв, зөвшөөрлийн агуулга
			Олгосон эсэх	Олгохоос татгалзсан үндэслэл			
1998 он							
1.	1998.05.26	Монголын нэгдсэн хөдөлгөөнд	-	СБ-ын талбайд жагсаал хийхийг хуулиар хориглосон тул.	Д.Сүхбаатарын талбайд	1998.05.26 №4/3918	Тодорхойгүй
2.	1998.05.28	Эх үрсийн баярыг тэмдэглэх нийслэлийн комисст	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайд	1998.06.01 №4/3929 10.30-11.00 цагийн хооронд	Эх үрсийн баярыг нийслэлд тэмдэглэн өнгөрүүлэх өдөр.
3.	1998.06.18	Нийслэлийн эрүүл мэндийн газарт	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайд хөшөөний урд хэсэгт	1998.06.20 №4/4793 11.00-14.00 цагийн хооронд	Эрүүл мэндийн газрын 60 жилийн ойг угтсан ажлын хүрээнд зохиогдож байгаа эрүүл мэндийн байгууллагад ажиллагсдын явган аялал.

4.	1998.06.19	Нийслэлийн ЗД-ын дэргэдэх Эрүүл мэндийн газарт	олгосон		Д.Сүхбаатарын хөшөөний урд хэсэгт	1998.06.20 №4/4793	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын ажиллагсдын эрүүл мэндийн газрын 60 жилийн ой угтсан спартакиадын хаалтын ажиллагаа.
5.	1998.08.12	Авто замын газарт	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1998.08.23 №4/6954	Авто замын байгууллага үүсэж байгуулагдсаны 70 жилийн ойн нэрэмжит дугуйт аялалын арга хэмжээ.
6.	1998.08.26	Зүүн азийн эмэгтэйчүүдийн чуулганы зохион байгуулах комисс	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1998.08.26 №4/7449 12.30-14.00 цагийн хооронд	“Эмэгтэйчүүд хүчирхийллийн эсрэг” сэдэвт жагсаал цуглаан.
7.	1998.09.03	ОУ-ын хүний эрхийн “Эмнэсти интернейшнл” байгууллагын монголын үндэсний зохицуулах хороо	олгосон		Хэлмэгдэгсдийн музей, Д.Сүхбаатарын талбай, Хэлмэгдэгсдийн хөшөө	1998.09.10 №4/7693 19.30-21.30 цагийн хооронд	Хэлмэгдэгсдийг хүндэтгэх жагсаал, зул өргөх ёслол.
1999 он							
1.	1999.05.13	Монголын оюутны спортын холбоо, нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар	олгосон		Д.Сүхбаатарын талбай, Энхтайвны гүүр, Зайсан толгой, Танктай хөшөө гэсэн маршрут	1999.05.16 №4/4398 10.00-12.00 цагийн хооронд	“Оюутан залуучуудын-БЗХӨ/ДОХ-ын эсрэг” бүх нийтийн уламжлалт гүйлтийн цэмцээн.
2.	1999.05.28	Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газарт	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1999.06.01 №4/4945 11.30-12.30 цагийн хооронд	“Эх үрсийн баяр”-аар явагдах арга хэмжээ.

3.	1999.06.09	Монголын үндэсний олимпийн хороонд	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайд	1999.06.13 №4/5152 11.00 цагт	ОУ-ын олимпийн өдрийн бүх нийтийн гүйлт.
4.	1999.06.30	Биеийн тамир спортын үндэсний төв	олгосон	.	Зайсан толгой, Д.Сүхбаатарын талбай гэсэн чиглэлтэй	1999.07.06 №4/5740 10.00-11.00 цагийн хооронд	Монголын бүх ард түмний Спартакиадын нийтийн гүйлтийн шигшээ тэмцээн.
5.	1999.11.12	Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газар	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайд	1999.11.17 №4/8918 15.00 цагт	Хүн эмнэлэгийн автомашин олгох ёслолын арга хэмжээ.
2000 он							
1.	2000.01.24	“АПУ” ХК-ийн ҮЭ-ийн хороо	.	СБ-ын талбайд жагсаал хийхийг хуулиар хориглосон тул.	.	2000.01.24 №4/988	ХХААҮЭ-ийн холбоо, “АПУ” ХК-ийн ҮЭ
2.	2000.05.03	Эх орон МАШСН-ын дарга Б.Эрдэнэбат	олгосон	.	ДБАТеатрын талбайд	2000.05.07 №4/4505 14.00-16.00 цагийн хооронд	Сонгуулийн ажлын нээлтэд зориулан баярын өдөрлөг хийх тухай.
3.	2000.05.03	Монголын АН-ын ерөнхий нарийн бичгийн дарга	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн зүүн хэсэгт	2000.05.06 №4/4504 16.00-19.00 цагийн хооронд	МоАЗХ-ны нэрэмжит “Хаврын баяр” цэнгүүн.

4.	2000.05.05	Монголын оюутны спортын холбоо, нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар	олгосон		Төв цэнгэлдэх хүрээлэн Их тэнгэрийн зам Зайсан толгой Богд хааны музей	2000.05.07 №4/4537 10.00-12.00 цагийн хооронд	“Сидней-2000” уриан дор явагдах оюутан залуучуудын уламжлалт бүх нийтийн гүйлтийн тэмцээн.
5.	2000.05.24	Нийслэлийн МАХН-ын хороо	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.05.26 №4/5216 15.00-19.00 цагийн хооронд	Тус намын хорооноос өөрийн байгууллагын 75 жилийн ойн арга хэмжээ.
6.	2000.05.24	Монгол Улсын циркийн захиргаа	олгосон		МҮЭ-ийн Соёлын төв ордноос цирк хүртэл Сөүлийн гудамжаар явах	2000.06.01 №4/5215 10.00-11.00 цагийн хооронд	“Эх үрсийн баяр”-ын өдрийг тохиолдуулан зохион байгуулах циркийн амьтад оролцсон жүжигчдийн жагсаал.
7.	2000.05.24	Монголын улаан загалмай нийгэмлэг	олгосон		ДБАТеатрын өмнөх талбайд	2000.05.27 №4/5214 15.00-16.00 цагийн хооронд	Байгалийн гамшигт нэрвэгдсэн аймгуудын малчдад туслах тусламжийн цувааг үдэн гаргах арга хэмжээ.
8.	2000.05.26	МАХН-ын сан хөмрөг эрхлэх газар	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.06.30 №4/5384 20.00-23.00 цагийн хооронд	Сонгуулийн сурталчилгааны ажлын төгсгөлийн “Шоу” арга хэмжээ.
9.	2000.05.26	Монголын авто спорт аялалын холбоо	Олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.05.27 №4/5383 09.00-10.00 цагийн хооронд	“Батхүлэг” автомашины бартаат замын уралдааны нээлт, хаалтын ажиллагаа.
10.	2000.05.26	Монголын Социал Демократ намын сонгуулийн төв штаб	Олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.06.03 №4/6382 12.00-13.00 цагийн хооронд	“Харилцан итгэж, хамтран бүтээе!” сонгуулийн ёслолын арга хэмжээ.

11.	2000.05.29	Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.06.01 №4/5390 10.00-13.00 цагийн хооронд	“Эх үрсийн баяр”-ыг тэмдэглэх нэгдсэн арга хэмжээ.
12.	2000.06.20	Батлан Хамгаалахын Их Сургууль	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.06.25 №4/6114 10.00-12.40 цагийн хооронд	Тус сургуулийн төгсөлтийн арга хэмжээ.
13.	2000.06.21	Монголын улаан загалмай нийгэмлэг	олгосон		ДБУАТеатрын урд хэсэгт	2000.06.26 №4/6120 12.00-13.00 цагийн хооронд	Байгалийн гамшигт нэрвэгдсэн аймгуудын малчдад туслах тусламжийн цувааг үдэн гаргах арга хэмжээ
14.	2000.06.21	Нийслэлийн ахмадын хороо	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2000.06.23 №4/6119 11.00-12.00 цагийн хооронд	Монголын хувьсгалчдын өдрийг тохиолдуулан Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх арга хэмжээ
15.	2000.06.23	Монголын Бүгд найрамдах намын СД-ийн хороонд	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2000.06.24 №4/6341 11.00-14.00 цагийн хооронд	УИХ-д нэр дэвшигчийг сурталчлах арга хэмжээ
16.	2000.08.28	Монголын Залуучуудын холбоонд	олгосон		Хавсралтад заасан маршрутын дагуу	2000.09.09 №4/8164 10.00-12.00 цагийн хооронд	“Архидалтгүй орчин-бидний сонголт” сэдэвт бүх нийтийн гүйлт.


17.	2000.08.31	Батлан хамгаалахын яаманд	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайн хойд хэсэгт	2000.09.03 №4/8176 10.00-14.00 цагийн хооронд	Дэлхийн II дайны төгсгөл, 1945 оны чөлөөлөх дайны ялалтын 45 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд болох цэргийн ёслол, хүндэтгэл, урлаг спортын арга хэмжээ.
2001 он							
1.	2001.04.27	МУИС-ийн спорт клуб	-	Цагийг нь тулгаж хүсэлтээ гаргаж ирүүлсэн	Тодорхойгүй	2001.04.29 №3/2103 11.00 цагт	Тодорхойгүй
2.	2001.05.10	Ардчилсан залуучуудын холбоонд	-	Ерөнхийлөгчийн сонгууль өнгөртөл ямар нэгэн арга хэмжээ з/б-гүй	Д.Сүхбаатарын талбайд	2001.05.11-12 №3/2454	Их, дээд сургуулийн багш, оюутны "Явган аялал"-ын нээлт.
3.	2001.05.10	Дэлхийн энхтайвны эв нэгдлийн төлөөх гэр бүлийн монголын холбоонд	-	Өөр арга хэмжээтэй давхардаж байгаа учир	Д.Сүхбаатарын талбайд	2001.05.27 №3/2452	"1000 гэр бүлийн баяр"

UJLMN
СУДАЛГААНЫ САН

4.	2001.07.03	“Бува” ХХК-нд	олгосон	.	ДБАТ театрын урд талбайд	2001.07.03 №3/3800 12.00-15.00 цагийн хооронд	Автомашин хөгжлийг харуулсан цуглаан.
5.	2001.10.08	Монголын улаан загалмай нийгэмлэг	олгосон	.	СУАТ театрын урд талбайд	2001.10.11,12 №3/6050 16.00 цагт	Байгалийн гамшигт нэрвэгдсэн 11 аймгийн 80 суманд, хүнсний болон эмийн бүтээгдэхүүн хүргэх цувааг үдэх ёслолын арга хэмжээ.
2002 он							
1.	2002.01.11	Хуульч залуучуудын “Сенатор” групп, Эв нэгдэл оюутны хөдөлгөөн	.	Үндсэн хуулийн 10 жилийн арга хэмжээтэй давхцсан тул	Д.Сүхбаатарын талбайд	2002.01.13 №3/332	“Төрийн дуулал эгшиглүүлэх” арга хэмжээ.
2.	2002.03.14	Зэвсэгт хүчний ерөнхий штаб	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.03.15 3/1301 10.00-14.00 цагийн хооронд	Монгол Улсын Зэвсэгт хүчин байгуулагдсаны 81 жилийн ойн арга хэмжээ.
3.	2002.04.03	Биеийн тамир спортын үндэсний төв	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.04.07 3/1928 11.00-12.00 цагийн хооронд	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажил.
4.	2002.04.05	Монголын Таеквондогийн холбоо	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.04.07 3/2126 12.00-12.30 цагийн хооронд	Монголын Таеквондогийн холбооны 10 жилийн ойд зориулсан өсвөр үеийн таеквондогийн тамирчдын үзүүлэх тоглолт

5.	2002.04.24	Хохирогсдын түр хороо	-	“Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-ийн 1 дэх заалтын 2, 7-р зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн тул.	-	2002.04.26 №1/2539	БНСУ-ын Элчин сайдын яаманд эсэргүүцэл илэрхийлэх зорилгоор НХХЯ-аас эхлэн ЗГ-ын ордон, Нийслэлийн ЗДТГ, Төв шуудан, ГХЯ-ны дэргэдүүр гарч автомашины төв замыг дайрч БНСУ-ын Элчин сайдын яам хүрэх маршрутаар жагсаал зохион байгуулах.
6.	2002.04.30	Монгол Улсын Байгаль орчны яам	олгосон	-	Соёлын төв өргөөний өмнөх талбайд	2002.05.03 3/2734 11.00-13.00 цагийн хооронд	“Тужийн нарсны ойг нөхөн сэргээх” ажлын хүрээнд зохион байгуулах арга хэмжээ
7.	2002.04.30	Нийслэлийн татварын алба	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайд	2002.05.06 №3/2739 14.00-16.00 цагт	“Татвар төлөгчдийн өдрүүд” арга хэмжээний нээлтийн ажиллагаа
8.	2002.05.16	Монголын Ардчилсан Социалист залуучуудын холбоо	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайд	2002.05.18 №3/3107 09.00-09.40 цагт	“Туриад 2002” явган аялалын тэмцээний гаргаа.
9.	2002.05.17	Дэлхийн Энхтайвны эв нэгдлийн төлөөх гэр бүлийн Монголын холбоо	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.05.26 №3/3233	“Мянган гэр бүлийн баяр” өдөрлөгийн ажиллагаа.
10.	2002.05.27	Монголын хүүхдийн сагсан бөмбөгийн холбоо	олгосон	-	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.06.16 3/3474	М-Си- Эс Коко кола компанитай хамтран Хүүхэд багачуудын дунд гудамжны сагсан бөмбөгийн тэмцээн.

11.	2002.05.27	Монголын Улаан загалмай нийгэмлэг	олгосон	.	ДБАТ-ын урд талбайд	2002.05.30-06.03 3/3473	Байгалийн гамшигт өртсөн аймгуудад үзүүлэх тусламжийн цуваа гаргах.
12.	2002.05.27	“Их Монгол жуулчин” ХХК	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт /40x30/	2002.05.30-ны өдрөөс 6-р сарын 03-ны өдөр хүртэл №3/3409	“Хөх хулганы орон” хүүхдийн тоглоомын цогцолборыг байгуулах
13.	2002.05.29	“Улаанбаатар ротаракт” клуб	олгосон	.	ДБАТ-ын урд талбайд	2002.05.31 3/3481 12.00-15.00 цагийн хооронд	“Дэлхий нийтийн тамхигүй өдөр”-ийг тохиолдуулан өсвөр үеийнхний дунд тамхинаас урьдчилан сэргийлэх, тамхины хор уршгийн талаар сурталчилгаа явуулах.
14.	2002.06.04	“ХХI зуун-Хөх Монгол” төвийн удирдах зөвлөл	-	“ЖЦХЖТХ”-ийн 7-р зүйлийн 2, 9-р зүйлийн 2 дахь заалт зөрчсөн тул	Д.Сүхбаатарын талбайд	2002.06.05 №3/3647 15.00 цагт	
15.	2002.06.24	М-Си-Эс холдинг компани	олгосон	.	“Лас вегас” төвийн болон ҮЖАТ-ын өмнөх талбайд	2002.06.24 3/4189 11.00-16.00 цагийн хооронд	Коко-Кола компанийн бүтээгдэхүүнийг Монголд үйлдвэрлэж эхэлсэнтэй холбогдуулан.



16.	2002.06.27	Монголын авто спортын аялалын холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.06.29 3/4227 08.00-11.00 цагийн хооронд	Автомашины бартаат замын “Батхүлэг” цуврал уралдаануудын IV үеийн Их-сорилго 2002 уралдааны нээлтийн ажиллагаа.
17.	2002.07.26	Монголын авто машин мотоциклийн спортын холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.07.27 3/5080 08.00-09.30 цагийн хооронд	Цомын төлөө авто машин мотоциклийн холын зайн уралдааны нээлтийн ажиллагаа.
18.	2002.08.02	Эрүүл мэндийн газар	олгосон		ДБАТ-ын урд талбайд	2002.08.03 3/5212 11.00-15.00 цагийн хооронд	Хүүхдийг хөхөөр хооллох “Дэлхийн 7 хоног” –ийн ажлын хүрээнд “Хөхөөр хооллолтыг дэмжье” уриан дор зохион байгуулах арга хэмжээ
19.	2002.08.06	Монголын авто машин мотоциклийн спортын холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.08.19 3/5364 17.00-20.00 цагийн хооронд	Rally Riad 2002 авто мотоциклийн холын зайн уралдааны хаалтын ёслолын ажиллагаа.
20.	2002.08.30	Биеийн тамир спортын үндэсний төв	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.08.31 3/6136 12.00-13.00 цагийн хооронд	“Дугуйн аялал” арга хэмжээний нээлтийн ажиллагаа.
21.	2002.08.30	Монголын сонины холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.09.01 3/6058 11.00-18.00 цагийн хооронд	Монголын сонины холбооноос зохион байгуулах хэвлэлийн яармаг.

22.	2002.08.30	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим	олгосон	'	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.09.21 3/6058 12.00-18.00 цагийн хооронд	МХАҮТ-аас зохион байгуулах бизнес фестивалын арга хэмжээ.
23.	2002.08.30	Монголын авто спортын аялалын холбоо	олгосон	'	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.08.31 3/6057 09.00-10.30 цагийн хооронд	Улсын аварга шалгаруулах тэмцээний нээлтийн ажиллагаа.
24.	2002.09.06	Замын цагдаагийн газар	олгосон	'	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэгт	2002.09.07 3/6547 12.00-14.00 цагийн хооронд	“Хүүхэд-замын хөдөлгөөн” сэдэвт өдөрлөг.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар

№	Он,сар, өдөр	Ямар байгууллага боллох	Зөвшөөрөл		Зохион байгуулах газар	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн огноо, дугаар, цаг	Жагсаал, цуглааны нэр, сэдэв, зөвшөөрлийн агуулга
			Олгосон эсэх	Олгохоос таггалзсан үндэслэл			
1998 он							
1.	1998.05.04	Монголын оюутны холбоо	олгосон	-	-	1998.05.04 №А/210	Залуучуудын жилийн хүрээнд зохион байгуулах оюутны жагсаал цуглаан нь ард иргэдээ аюулт өвчнөөс хамгаалах, сурталчлах, сэрэмжлүүлэх
2.	1998.06.04	Чөлөөт залуучуудын холбооны зохицуулах зөвлөлд	-	Жагсаал, цуглаан хийх тухай хуулийг зөрчиж байна	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэг	1998.06.04 №А/271 20.00 цагт зогсоох	Ямар нэг материал байхгүй.
1999 он							
1.	1999.05.13	Монголын оюутны холбоо	олгосон	-	-	1995.05.13 №168	-
2.	1999.02.29	Монгол Улсын Эрүүл мэнд нийгмийн хамгаалалын яам	олгосон	-	Д.Сүхбаатарын хөшөөний дэргэдээс	1999.10.02 №В/351	ОУ-ийн Ахмадын жилийг тохиолдуулан “Нэг дэлхий” уриан дор явагдах явган аялал.

3.	1999.06.08	Шри Чин Мойн энхтайвны төвд	олгосон		-	№А/206	Энх тайвны гүйлт-99
4.	1999.06.09	МУ-ын Засгийн газар хамтран зохион байгуулж байгаа	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1999.06.11-12 №Б/208	Мэдээлэл холбооны технологийн үндэсний чуулга уулзалтын арга хэмжээ.
5.	1999.06.13	Монголын авто спорт аялалын холбоонд	олгосон		ДУАТ-ийн өмнө талбайд	1999.06.19 №А/230 10.00-11.00 цагийн хооронд	“Батхүлэг-99” уралдааны нээлтийн ажиллагаа.
6.	1999.06.23	Монголын Улаан загалмай нийгэмлэг	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1999.06.30 №4/236 19.00-22.00 цагийн хооронд	МУЗН-ийн 60 жилийн ойд зориулсан цэнгүүн.
7.	1999.08.17	“Коника” гэрэл зургийн төв	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	1999.08.23 №В/304 14.00-15.00 цагийн хооронд	“Коника” гэрэл зургийн салбаруудын төвийн нээлтийн арга хэмжээ.
8.	1999.09.13	Шри Чинмойн Энхтайвны төвд	олгосон		-	№А/329	Тодорхойгүй.
9.	1999.09.22	Монголын БН намын нарийн бичгийн дарга нарын газар	олгосон		-	№А/334	Урлаг, спортын тоглолт, цэнгүүн.
10.	1999.10.01	Монголын ардчилсан холбоонд	олгосон		-	№А/354	Тодорхойгүй.

11.	1999.10.10	Шри Чинмойн Энхтайвны төв	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайд	1999.10.24 №А/387 11.00-12.30 цагийн хооронд	Тодорхойгүй.
12.	1999.10.19	Монголын Үндэсний чөлөөт зохиолчдын холбоонд	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайд	1999.10.19 №А/385 13.00-14.00 цагийн хооронд	МУ-ын Төрийн шагналт УИХ-ын гишүүн агсан О.Дашбалбарыг дурсан санах "Хүмүүс ээ! Амьддаа бие биеэ хайрлая" сэдэвт цуглаан.
13.	1999.10.20	Шри Чинмойн Энхтайвны төвд	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн урд хэсэг	1999.10.24 №А/387 11.00-12.30 цагийн хооронд	Тодорхойгүй.
2000 он							
1.	2000.03.22	Оюутан-төсөл үндэсний төв	.	Хуульд заасан хугацаанд хүсэлтээ ирүүлээгүй	Монголын залуучуудын холбооны төв байрны өмнөх талбай	2003.03.23 №356 14.00 цаг	Монголын оюутны холбооны өнөөгийн удирдлагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа, баримталж буй бодлого, шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлэх
2.	2000 он	Монголын Ардчилсан шинэ социалист намд	Цэцэг өргөхийг нь зөвөөрсөн	Цуглаан зохион байгуулахыг нь зөвшөөрөөгүй	Д.Сүхбаатарын талбайд	2000.05.07 №361 14.00-16.00 цагийн хооронд	Сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан Д.Сүхбаатарын талбайд цэцэг өргөх, цуглаан зохион байгуулах.
2001 он							

1.	2001.05.13	ОУ-ын Эмнести-Интернэйшл байгууллагын Монголын үндэсний зохицуулах хороо	олгосон		Д.Сүхбаатарын талбайгаас	2001.05.13 12.00 цагаас эхэлнэ	“Эдлэх эрхийнхээ төлөө” бүх нийтийн гүйлт
2.	2001.05.15	Дэлхийн Энхтайвны эв нэгдлийн төлөөх гэр бүлийн Монголын холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбайд	2001.05.27 №3/2640 13.00-13.00 цагийн хооронд	Дэлхийн Энхтайвны эв нэгдлийн төлөөх гэр бүлийн Монголын холбооноос ирүүлсэн “1000 гэр бүлийн баяр”
3.	2001.05.29	Хүүхдийн төлөө үндэсний хороо, НХЗХ газар	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2001.06.01 №3/3003 10.00.13.00 цагийн хооронд	“Эх үрсийн баярын нэгдсэн арга хэмжээ”
4.	2001.06.21	Монголын Улаан загалмай нийгэмлэг	олгосон		ДБЭТ-ын урд талбай	2001.06.21 №3/3454 15.00-17.00 цагийн хооронд	“Цас зудын гамшигт нэрвэгдсэн малчдад үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа
5.	2001.06.20	Монголын хөдөлмөр эрхлэгч тахир дутуу, одой хүмүүсийн чөлөөт үйлдвэрчдийн эвлэл	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2001.07.01 №3/3448 10.00-14.00 цагийн хооронд	“Хатан зориг-2001 энэрхүй”-н аялалын арга хэмжээ
6.	2001.09.25	Монголын сонины холбоо	олгосон		-	2001.09.29 №5/504 11.00-17.00 цагийн хооронд	Дэлхийн шуудан холбооны өдрийг тохиолдуулан “Сонин, сэтгүүл, ном”-ын яармаг худалдаа.

7.	2001	Шинээр хэлмэгдэгсэдийн эрх ашгийг хамгаалах түр хороо	.	Нутаг дэвсгэрийн харьяалалаар хандах (ЧД-ийн ЗДТГ-т)	“Хэлмэгсэдийн хөшөөн”-ий дэргэд	2001.09.10 11.00 цагаас	Улс төрийн хэлс хэрэгт хэлмэгдэгсэдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулсан цуглаан.
8.	2001	Монгол-Японы хамтарсан “Нимонс” ХХК	олгосон	.	ДБЭТ-ын өмнөх талбай	2001.10.07 №В/532 09.00-17.00 цагийн хооронд	Япон автомашин, мотоциклийг сурталчлах “Нимонс-Фестиваль”
2002 он							
1.	2002.03.22	МАСоЗа-ын холбоо	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.04.05 №06 16.00-20.00 цагийн хооронд	Тус холбоо үүсч байгуулагдсаны 5 жилийн ойн баярт зориулсан нийтийн зугаалга.
2.	2002.04.30	МУЗН, Залуучуудын хөтөлбөрийн газар	олгосон	.	Монголын хүүхдийн ордны өмнөх талбай	2002.05.08 №3/2738 21.00-23.00 цагийн хооронд	“Дэлхийн эрүүл мэндийн өдөр”, “ОУ-ын улаан загалмайн өдөр”-т зориулсан өдөрлөг.
3.	2002.05.22	НЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.06.01	“Эрүүл орчин-гоо сайхан” цэцгийн баяр, цэнгүүн
4.	2002.05.24	“Монгол шуудан транс” ХХК	олгосон	.	ДБЭТ-ын зүүн хойт өнцөгт	2002.06.01 11.00-18.00 цагийн хооронд	Автомашин сурталчилгааны ажил.
5.	2002.05.30	XXI зууны Хөх – Монгол төв	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.05.31 №1/280 15.00 цагт	“Шударга ёсыг тогтоох ард түмэн”-ий цуглаан.


6.	2002.06.11	Архи, тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг	олгосон	.	Улсын циркийн хойд талбайд	2002.06.26 10.00-12.00 цагийн хооронд	Эрүүл мэндийн сурталчилгаа.
7.	2002.06.14	Батлан Хамгаалахын Их Сургууль	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.06.16 №3/3864 10.00-12.30 цагийн хооронд	Төгсөгчдийн баярын ажиллагаа.
8.	2002.06.19	Биеийн тамир спортын хороо	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.06.22 №1/20 12.00-15.00 цагийн хооронд	Биеийн тамир, спорт үүсч хөгжсөний 80 жилийн ойг тохиолдуулан “Хөдөлгөөн эрүүл мэнд” бүх нийтийн өдөрлөг.
9.	2002.06.20	Даяар монгол хөдөлгөөн	-	ЖЦХЖТ хуулийн 7-р зүйлийн 2, 9-р зүйлийн 3 дахь заалттай зөрчиж байна.	ДБЭТ-ын өмнөх талбай	2002.06.27 №До/21 12.00-14.00 цагийн хооронд	Газар өмчлөх тухай хуулийн төслийг гэнэт оруулж ирж батлуулах гэж байгааг эсэргүүцсэн суулт, цуглаан.
10.	2002.06.24	“Улаанбаатар хэвлэл” ХХК	олгосон	.	ДБАТ-ын баруун талбай	2002.06.24 15.00-15.30 цагийн хооронд	“Хүмүүс” сонины 5 жилийн ой болон II улирлын азтануудад шагнал гардуулах ажиллагаа.
11.	2002.07.26	Монголын автомашин мотоциклийн холбоо	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.07.27 №3/5020 12.00-13.00 цагийн хооронд	Цомын төлөө автомашин мотоциклийн холын зайн уралдааны нээлтийн ажиллагаа.

12.	2002.08.04	Монголын сонины холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2002.09.01 11.00-13.00 цагийн хооронд	Дэлхийн шуудан холбооны өдөрт зориулсан “Хэвлэлийн яармаг”.
13.	2002.08.20	Монголын улаан загалмай нийгэмлэг	олгосон		Д.Сүхбаатарын талбайн зүүн урд хэсэгт	2002.08.26,30 2002.09.05 №3/5829 16.00-17.30 цагийн хооронд	Байгалийн гамшигт нэрвэгдсэн 6 аймаг 65 суманд тусламжийн цувааг гаргах ажиллагаа.
14.	2002.09.02	Замын цагдаагийн газар	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2002.09.07 №3/6547 12.00-14.00 цагийн хооронд	“Хүүхэд, замын хөдөлгөөн” сэдэвт өдөрлөг.
15.	2002.09.10	Эрчим хүчний удирдах газар	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2002.10.09 №3/6851 12.00-13.00 цагийн хооронд	ЭХ-ний салбар үүсч хөгжсөний 80 жилийн ойн баярт оролцсон төлөөлөгчид Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагаа.
16.	2002.09.12	МУИС	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2002.10.05	“Бид МУИС-ийнхан” рок, поп эстрад хамтлагийн дуучид оролцсон тоглолт.
17.	2002.09.18	Дүүргийн цагдаагийн хэлтэс	олгосон		Улсын циркийн өмнөх талбай	2002.09.21 17.00-19.00 цагийн хооронд	“Цагдаа олон нийтийн хөтөлбөр” сурталчлах өдөрлөг.
18.	2002.09.26	Монголын оюутны холбоо	олгосон		Д.Сүхбаатарын талбай	2002.10.02 №3/234 09.00 цагт	Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх ёслол үйлдэх.

19.	2002.09.27	ДБЭТ	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн зүүн урд хэсэгт	2002.10.02 №3/7300 18.30-19.30 цагийн хооронд	Тус театрын 40 дэх жилийн нээлтийн ажиллагаа.
20.	2002.10.01	Эрүүл мэндийн яам	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.10.05 10.00-12.00 цагийн хооронд	ОУ-ын ахмадын өдрийг тохиолдуулан “Хөдөлгөөн-идэвхтэй амьдрал” өдөрлөг.
21.	2002.10.24	МоАХ /дарга Ш.Түвдэндорж/	.	ЖЦХЖТ хуулийн 7-р зүйлийн 2 дахь заалт зөрчиж байна.	Д.Сүхбаатарын талбай	2002.11.05 №1/20 10.00-18.00 цагийн хооронд	“Газрыг шудрагаар хувьчлахын төлөө” цуглаан.
22.	2002.12.09	“GAG” ХХК (женко группээс)	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайн зүүн хойд хэсэгт	2002.12.13 14.00-15.00 цагийн хооронд	Коника гэрэл зургийн корпорацийн лабораторийн нээлтийн ажиллагаа.
23.	2002	“АА” төв, Архидалт мансуурлын эсрэг ассоциаци	олгосон	.	Д.Сүхбаатарын талбай	2002.05.25 12.00-14.00 цагийн хооронд	“Архигүй өдөр” арга хэмжээ.
24.	2002	“Монфрэш” ХХК	олгосон	.	Хүүхдийн ордны дэргэд буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн орох хаалганы дэргэд	2002.06.01 10.00-18.00 цагийн хооронд	Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан Хүүхдийн дунд урамшуулалттай худалдаа, уралдаан тэмцээн, компанийн бүтээгдэхүүнийг сурталчлах ажиллагаа.

25.	2002	МАСоЗ-ын холбоо	олгосон	.	Д.Сүхбаатарын талбайгаас эхлэх	2002.05.18 09.00-09.40 цагийн хооронд	“Туриад-2002” явган аялал.
26.	2002	Монгол Компус, Крусейд фор Крайст шашны байгууллага	.	татгазсан	Орон сууцнуудын дунд	Тодорхойгүй 22.00-24.00 цагийн хооронд	“Есүс” киног үзүүлэх.
2003 он							
1.	2003.06.10	Мансуурлын эсрэг үндсэний төв	олгосон	.	ДБЭТ-ын өмнөх талбайд	2003.06.26	“Хар тамхи мансууруулах бодисын талаар ярилцацгаая” сэдэвт өдөрлөг.
2.	2003.06.23	Монголын авто спорт аялалын холбоо	олгосон	.	ДБЭТ-ын өмнөх талбай	2003.06.28 №3/345 09.00-10.00 цагийн хооронд	“Батхүлэг УБ-2003” оны уралдааны нээлтийн ажиллагаа.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар



№	Он,сар,	Ямар байгууллага	Зөвшөөрөл	Зохион	Зөвшөөрөл	Жагсаал, цуглааны
---	---------	------------------	-----------	--------	-----------	-------------------

					хотын Д.Сүхбаатарын талбайд цөөнгүй хүн оролцсон, 4 цаг орчим үргэлжилсэн жагсаал, цуглааныг дур мэдэн зохион байгууллаа. Тэд Засгийн газрын ордон, зарим гол байгууллагыг бүслэн хаахыг санаархаж байгаа нь нэгэнт тодорхой болсон учраас хууль хамгаалах байгууллага жагсаал цуглааны үеэр зохих газруудыг сэргийлж хамгаалах арга хэмжээ авсны дүнд ноцтой хэрэг явдал гарсангүй, Харин жагсаал, цуглаанд оролцогчид албан ёсны мэдээллийн хэрэгслээр өгсөн хариуг үгүйсгэн Түр хурал, Ард түмний онц зөвлөлийг байгуулсан МАХН-ын төв хорооны аппаратыг ЗГ-ын ордноос гаргах тулган шаардлагаа үргэлжлүүлэн тавьж байв. Монголын АХ, МоАН энэ жагсаал, цуглааныг зохион байгуулахдаа “БНМАУ-ын хот суурингийн гудамж талбайд хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх журмын тухай” БНМАУ-ын Ардын ИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 4-р сарын 07-ны өдрийн зарлигаар тогтоосон журмыг ноцтой зөрчиж, ямар ч зөвшөөрөлгүйгээр хийснээрээ хууль бус, хэт даварсан үйл ажиллагаа явуулж байгаагаа харуулав. Тус холбоо, нам ийнхүү хууль бус ажиллагаа явуулахаар эхэлж, зэхэж байгаатай холбогдуулан БНМАУ-ын прокурор бүрэн эрхийнхээ ёсоор урьдчилсан сануулга өгч хууль биелүүлэхийг МоАХ-ны удирдлагад албан ёсоор шаардсан боловч тэд хуулийн утга санааг зориуд мушгин гуйвуулж зарлигийн заалт; Прокурорын сануулгыг хайхралгүйгээр ийм ажиллагаа хийсэн байна. Энэ талаар 1990.4.24-ний өглөөнөөс эхлэн хөдөөгийн хөдөлмөрчид, хамт олноос олон зуун захидал ирсээр байна.
3.	Үнэн	1990.12.05 Лхагва 284 /17814/	Балж. Ганбат	Өлсгөлөн зарлав.	Увс аймаг дахь зарим шинэ, нам хөдөлгөөний салбарууд 1990.11.21 нд өргөн барих бичиг гардуулж аймгийн ардын хурлын гүйцэтгэх захиргааны дарга, орлогчид, хэлтсийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорхыг шаардаж 1990.12.04 өдөр өлсгөлөн зарлав.
4.	Үнэн	1990.12.11 Мягмар 289/17819/	Д. Сэнэднасаа	Өлсгөлөн зарлав.	Төв аймаг дахь зарим шинэ нам, эвсэл, хөдөлгөөний салбарын 5 хүн 12 сарын 10-нд өлсгөлөн зарлав. Тэд аймгийн Ардын хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны удирдлагыг огцрох, хэрэв одоо огцорвол албан тушаалдаа дахин өрсөлдөхгүй байх шаардлага тавьжээ.

5.	Үнэн	1990.12.14 Баасан 292/17822/	Х. Ганбат /Үнэн сонины сурвалжлагч/	Өлсгөлөнгөөр айлгасаар байх уу?	МоАХ-ны төмөр замын нэгдсэн зохицуулах зөвлөлийн 10 залуу ТЗХЭГ-ын удирдах албан тушаалтнуудыг огцорхыг шаардаж, хэрэв огцрохгүй бол 12 сарын 10 буюу олон улсын хүний эрхийн өдрөөр өлсгөлөн зарлахаа мэдэгджээ. Хэрэг эрхлэх газрын удирдах хүмүүс нэр нүүрээ бодсон уу? Аль эсвэл албан тушаалаа хамгаалж хүмүүс өлсгөлөө гэж хэлүүлэхээс ичсэн үү бүү мэд 12 сарын 9-ний өдөр албан тушаалаасаа огцорчээ.
6.	Үнэн	1990.12.27 Пүрэв. 303/178833/	Д. Пүрэвдорж	Суултаар далайлгажээ.	БХЯ-ны мэдэлд 10 байр хуваарилсаны нэгийг ахмадууддаа өгчээ. Гэтэл уг байранд 32 хүн орохоор булаацалдаж Ш. Жадамбаа сайд тэдэнтэй учир зүйгээ ололцох гэж бүтэн 6 цаг ярилцсан байна. Гэтэл тэд ямар ч тохиролцоонд хүрэлгүй 10 хүн нь суулт хийнэ гэж эргэж иржээ.
1991 он					
1.	Ардын эрх	1991.04.09 Мягмар /66/138/		Ардчилал нэг нас хүрлээ.	“Ардчилал” сонины анхны дугаар хэвлэгдэн гарсны нэг жилийн ойд зориулсан цуглаан Сүхбаатарын талбайд боллоо. Цуглаан дээр тус сонины эрхлэгч С. Амарсанаа хэлэхдээ: Өнөөдөр “Ардчилал” сонин нэг ой хүрэв. МоАН-ын их хурал хуралдсаны нэг жилийн ой болж байна. Манай орны уншигчид олон сонин хэвлэлтэй болсноороо үнэнийг эрж олж унших боломжтой боллоо гэв.
2.	Ардын эрх	1991.08.28 Лхагва 144/216/	Манай сурвалжлагч	Цуглаан боллоо.	Өнгөрсөн ням гаригт МоАН, МоАХ-ны санаачилгаар, ЗХУ-д төрийн эргэлт хийх гэсэн балмад хэсэг этгээдийн оролдлогыг тас цохисон оросын ард түмнийг талархан дэмжих цуглаан эрх чөлөөний талбайд боллоо. Цуглаан дээр Улсын бага хурлын зарим гишүүн, нам, эвсэл, холбоодын удирдагчид оролцож үг хэллээ. Цуглаан дээр үг хэлсэн хүмүүс ЗХУ-д төрийн эргэлт хийх гэсэн оролдлогын үед төр, засгийн байгууллага, нам, эвсэл холбоодоос баримталсан байр суурийн талаар үнэлэлт, дүгнэлт өгч яриу.
1992 он					
1.	Засгийн газрын мэдээ	1992.02.10 38/51/	Манай сурвалжлагч	Дугуй танхимд болсон цуглаан.	Өнгөрсөн бямба гаригт МУИС-ийн дугуй танхимд УБ хотын хүүхдийн цэцэрлэг, ЕБС, сургалтын төв, коллеж, Их сургуулиудын захирал, эрхлэгчид, ҮЭ-ийн ажилтнууд цугларсан байв. Цуглаанд оролцсон эрхлэгч захирлууд хүүхдийн цэцэрлэгийн хангалт доройтож, багш нарын амьжиргааны түвшин буурч байгааг болон хойч үеийнхний мэдлэг боловсрол болсон сургуулиа өөд татах цаг хэтрээд

					байгааг шүүмжлэн ярьж, багш нарын цалинг 2-3 дахин нэмэх шаардлага тавьж байлаа. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд багш нарын цалин хөлс, үнийн өсөлтөөс ихээхэн хоцорч байгааг олон хүн баримт дурдан ярьж мөн дотуур байрны хүүхэд өлсч, олон сайн багш нар мэргэжлээ орхин өөр зам хөөж байгааг дурджээ. С. Ганбат: энэ цуглаан дээр үг хэлсэн хүмүүсийн шаардлагыг төр засгийн газар хүлээн авч яаралтай арга хэмжээ авахгүй бол бид тэмцлээ өөр хэлбэрээр үргэлжлүүлнэ гэж мэдэгдлээ.
2.	Ардын эрх	1992.03.19 Пүрэв 34/338/	С.Пүрэвдорж	Бухимдсан олны цуглаан.	Улиастай хотын хуралдааны байгууллага чанаргүй бүтээгдэхүүнээ өндөр үнээр худалдаалж байгаад бухимдсан хөдөлмөрчид тус хотод цуглаан хийв. Үнийг нь нэмээгүй талх, картны архийг дэлгүүрт алдаг оног гаргадаг атлаа чанар муутай өндөр үнэтэй гурилан бүтээгдэхүүн, “шаг”-ийн архийг элбэгшүүлсэн, махны үйлдвэрийн цувдайн үнэ өссөн ч дотор нь элэг, уушиг, бөөрнөөс өөр зүйл байхгүйг цуглаанд үг хэлсэн хүмүүс дурьдав.
3.	Ардын эрх	1992.03.26 Пүрэв 37/341/	МОНЦАМЭ	Багш нарын цуглаан	Говь-Алтай аймагт “Багш нарын эрх ашгийг хамгаалъя” уриан дор цуглаан болжээ. Цуглаанд оролцогчид Засгийн газрын 1992 оны 12, 35 дугаар тогтоолыг амьдралд хэрэгжүүлж, багш нарын цалинг нэмэх талаар аймгийн захиргаа, боловсролын байгууллага тодорхой арга хэмжээ авахгүй бол одоогийн өгч буй төсвөө хэрэглэж дуусаад сургуулиа хаах, эсвэл багш нарын ажлын цагийг багасгаж, хувийн хөдөлмөр эрхлэх гэх зэрэг олон санал гаргажээ. Цуглаанаас МУ-ын ЗГ-т өргөн барих бичиг илгээж, аймгийн захиргаанд тодорхой зүйлтэй шаардлага гардуулсан байна.
4.	Ардын эрх	1992.05.06 Лхагва 57/361/	Г. Жамц	Экологийн цуглаан	Өнгөрсөн ням гаригт нийслэлийн Эрх чөлөөний талбайд Монголын ногоонтны хөдөлгөөн, ойчдын нэгдсэн холбоо, сэтгүүлдийн “Байгаль эх” хамтлаг зэрэг олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагаас зохион байгуулсан хөдөлмөрчин олны экологийн цуглаан болов. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед хууль тогтоомж боловсронгуй бишээс байгаль орчинд ноцтой сүйтгэл учирч байгааг цуглаан дээр үг хэлсэн хүмүүс баримт нотолгоотой харамсан ярив.

Цуглаанд оролцогсдоос МУ-ын Ерөнхийлөгч, УБХ-д сонордуулах бичиг илгээв.

1993 он

1.	Ардын эрх	1993.08.17 Мягмар 129/629/	Манай сурвалжлагч	Үйлдвэр зогсч цуглаан болов.	Өдөр шөнөгүй ажиллаж байсан Б.Жаргалсайхан захиралтай УБ-ын ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэрийн үйлдвэрлэл өчигдөр гэнэт зогсч, ажилчдын өргөн цуглаан болжээ. Энэ нь тус үйлдвэрээс саявтар халагдсан 4 эмэгтэй хамт олныг үймүүлж, дэг журам, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байгаа гэж үзсэнтэй уялдаатай ажээ.
----	-----------	----------------------------------	-------------------	------------------------------	--

1994 он

1.	Засгийн газрын мэдээ	1994.03.22 25/169/	Манай сурвалжлагч	Цуглаан болов.	Энэ сарын 18-ны өдөр МоАХ-ноос ялалтын талбайд цуглаан зохион байгууллаа. Цуглаанд хот, хөдөөгөөс нийт 10 шахам хүн үг хэлсний дотор МҮАН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Э. Бат-Үүл: УИХ нь Монголын ард түмнээс сонгуульд өгсөн саналын бодит тусгал болж чадахгүй байна гээд УИХ-ын хаврын чуулганы нээлт дээр МУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат, УИХ-ын гишүүн Ц.Элбэгдорж нарын хэлсэн үгэндээ дэвшүүлсэн саналыг УИХ эс хүлээн авбаас бид УИХ дахь 6 гишүүнээ татаж авах болно. Тэгээд УИХ Засгийн газрыг огцруулахын төлөө тэмцэл эхэлнэ хэмээн мэдэгдэв. Уг цуглаан 2 цаг шахам үргэжиллээ.
2.	Засгийн газрын мэдээ	1994.04.12 Мягмар 28/174/		Цуглаан болов.	МоАХ-оос эрх чөлөөний талбайд цуглаан хийв. Цуглаанд Э. Бат-Үүл: "Одоогийн засгийн газар огцрох хүртэл МоАХ тэмцлээ үргэлжлүүлнэ, шаардлагатай бол өнөөдөр ч маргааш ч тэмцлээ үргэлжлүүлэн хийнэ, өлсгөлөн ч зарлана." гэж мэдэгдэв.
3.	Засгийн газрын мэдээ	1994.04.22 Баасан 31/177/	Манай сурвалжлагч	Цуглаан хийв.	Өчигдөр 13 цаг 30 минутнаас эрх чөлөөний талбайд Монголын тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ийн холбооноос цуглаан зохион байгуулав. Уг цуглаанд төрийн соёрхолт зохиолч З. Дорж, яруу найрагч О.Дашбалбар, Говь Алтай аймгийн Алтай сумын малчин Цэрэндорж нарын олон хүн үг хэлж одоогийн Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж буйгаа илэрхийлэв.
4.	Өнөөдөр	1994.07.10 Пүрэв №136/174/	Д.Гал	Автобус-1 ажил хаяж магадгүй.	Хотын тээврийн удирдах газрын дарга асан Ш.Дашцэрэнг "Автобус-1" компанийн захирлаар томилсныг ажилчид нь эсэргүүцэж Ерөнхий сайд М.Энхсайхан, Нийслэлийн ЗД бөгөөд УБ хотын захирагч Ш.Наранцацралт нарт өргөх бичиг

					барьжээ. “Автобус-1” компанийн ажилчид түр хороо байгуулж Ш.Дашцэрэнг захирлаар томилсон асуудлаа эргэн харах, мөн ХТУГ болон “Автобус-1” компанид санхүүгийн шалгалт хийх шаардлага тавьсан байна. Хэрэв асуудлыг шийдэж 7-р сарын 16-ны дотор хариу өгөхгүй бол ажил хаяхаар шийдвэрлээд байгаа аж.
5.	Засгийн газрын мэдээ	1994.12.02 Баасан 89/235/	Манай сурвалжлагч	Тайван жагсаал болов.	Саяхан Монгол улсад цалингийн доод хэмжээг үйлчлэгчийн цалингаар бодож тооцож 260 төгрөгөөр тогтоогоод амьдралын баталгаат цалин гэж үзэж байлаа. Тэгвэл өнөөдөр доод цалинг 6400 төгрөгөөр тооцож байна. Гэвч өнөөдрийн доод цалингийн худалдан авах чадвар нь 260 төгрөгийн худалдан авах чадвараас 3 дахин буурчээ. Тухайн үедээ 260 төгрөгөөр 260 кг II р гурил худалдан авдаг байсан бол 6400 төгрөгөөр өнөөдөр II гурил 64 кг-г худалдан авах юм. Үнэ цалин хоёрын хоорондын зөрөөнд хийсэн статистик судалгааг үндэслэн нийгмийн шударга харилцааг тогтоохын төлөө тайван жагсаал 12-р сарын 3-нд МҮЭ-үүдийн байгууллагуудаас орон даяар зохион явуулахаар болов. Энэ цуглаанд зориулсан хэвлэлийн бага хурал дээр МҮЭХ-ны ерөнхийлөгч Адъяа хэлэхдээ: Нийгмийг хамарсан ажилгүйдэл, ядуурал, тэгш биш эдийн засгийн харилцааны эсрэг хийх ҮЭ-ийн байгууллагын ажлын зөвхөн эхлэл юм. Бид шат дараалсан арга хэмжээг авч үр дүнд хүрэх зөв тогтолцоог бүрдүүлэхийн тулд хууль ёсны хүрээнд тэмцлийн бүх арга хэрэглэх болно гэжээ.
6.	Засгийн газрын мэдээ	1994.12.06 90/236/	Д. Баяр	Жагсаалд 16000 хүн оролцлоо.	УБ хотын эрх чөлөөний талбайд 12-р сарын 3-нд болсон тайван жагсаалд худалдаа, эрүүлийг хамгаалах, боловсрол, шинжлэх ухаан зэрэг 14 салбарын 15000-16000 ажилчид оролцжээ. Тэд хөдөлмөрчдийн нийгмийн баталгааг хангахын төлөө энэхүү жагсаалыг зохион байгуулсан гэж ярилаа.
1995 он					
1.	Ардын эрх	1995.04.19 Лхагва 76/1035/	Ц. Ганхуяг	Багш нар ажил хаяв.	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын багш нар цалин хөлсөө нэмэгдүүлэхийг шаардан хугацаагүй ажил хаяв. Монголын БШУ-ны ҮЭ-үүдийн чөлөөт холбоонд 2,3,4,6,7,10,11,15,25,26,31,32,34,35,41,44,45,52,53,60,63,68,75,89,97-р сургуулиуд ажил хаяхаа мэдэгдлээ. Мөн Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Булган, Завхан, Ховд, Говьсүмбэр аймгийн сургуулиуд тэдэнтэй эв санааны

					нэгдэлтэй байгаагаа илэрхийллээ.
2.	Ардын эрх	1995.05.03 Лхагва 86/1045/	Ш. Алтангэрэл	Багш нар цуглаан хийв.	5-р сарын 1-ний өдөр эрх чөлөөний талбайд багш нарын цуглаан болж НЕБС-иудын багш нарын хөдөлгөөнийг зохицуулах төв хорооны дарга Ц. Магвандорж цуглааныг нээж үг хэлэхдээ: Багш нар маань зарлаагүй өлсгөлөнгөөр нууцхан өлсөж, засгийн газрын хоосон амлалтад молигдуулж байсан учраас ажил хаях болсон гэв. 10-аад хүн үг хэлж оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг нийгэмд бий болгох багш нарыг сонгон шалгаруулах боловсролын талаар явуулах төрийн бодлогыг шинэчлэх зэрэг асуудлыг хөндөв.
3.	Засгийн газрын мэдээ	1995.05.20 Бямба 57/299/		Найрамдлын цуглаан болов.	Эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө цогтой тэмцэгч Вьетнамын ард түмний гарамгай хүү Хо Ши Миний мэндэлсэний 105 жилийн ойд зориулсан найрамдлын цуглаан Пүрэв гаригт Нийслэлийн 14-р сургууль дээр боллоо. Хамт олноороо МВНН-ийн гишүүн энэ сургууль дээр болсон уулзалтанд БНСВУ-н элчин сайд Ву Ван Ваг, тус элчин сайдын яамны ажилтнууд, МВНН-н хүндэт ерөнхийлөгч Ж. Жамъян болон МВНН-ийн тэргүүлэгч гишүүд оролцлоо. Найрамдлын цуглаанд оролцогчид тус сургуулийн Хо Ши Миний танхимаар орж, сурагчдын урлагийн тоглолтыг үзэж сонирхлоо.
4.	Ардын эрх	1995.06.06 Мягмар 110/1069/	Р.Гоцбаяр	“Бид Есүсийнх” жагсаал	Өнгөрсөн бямба гаригт /6-р сарын 2-нд/ Есүст итгэгч монголчууд жагсаж Ертөнцийн эзнийг магтан дуулав. Энэ цуглаанд 4-70 насны 200-гаад хүн оролцжээ.
5.	Ардын эрх	1995.09.01 Баасан 172/1131/	Б. Чимгээ	Эмч ажилчид цуглаан хийлээ.	Нийслэлийн Баянгол дүүргийн эрүүл мэндийн VI төвийн орох хаалганы урд 17 машины гарааш барихаар газар ухсаныг эсэргүүцэж тус эмнэлийн эмч, ажилчид цуглаан хийлээ.
6.	Засгийн газрын мэдээ	1995.09.27 Лхагва	А. Лхагва	Гашуудлын цуглаан болов.	Улаанбаатар хотоос Мөрөнгийн чиглэлд ээлжит нислэг хийж явсан АН-24 онгоц осолд орж олон хүн амь насаа алдсан билээ. Тэдний шарилыг уржигдар нийслэлд авчирч, нисэх онгоцны “Буянт-Ухаа” буудлын нислэгийн талбайд амь үрэгдэгсэдийн шарилыг хүлээн авах, салах ёс гүйцэтгэх гашуудлын цуглаанд тэдний гэр бүл, найз нөхөд, төрөл төрөгсөд нийслэлийн хөдөлмөрчдийн төлөөлөгчид оролцон гүн эмгэнэл илэрхийллээ.
7.	Ардын эрх	1995.10.04 Лхагва 195/1154/	Б. Рагчаа	Хөтөлийн багш нар ажил хаяв	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл хорооны 10-н жилийн сургуулийн 75 багш ажилчид ажил хаяжээ. Учир нь тэд сүүлийн нэг сар цалин аваагүй байна.

8.	Ардын эрх	1995.12.27	Ж. Тэлмэн	Б. Гансүх өлсгөлөнгөө зогсоов.	Ерөнхийлөгчөөс эхлээд олон хүнийг хууран мэхэлж банкнаас 90 сая төгрөгийн зээл авсан Б.Гансүх: Банкнаас зээл авах бүх боломжийг олгосон хүмүүсийг хориогүй байж ганцхан намайг хорилоо гэж өлсгөлөн зарлав. Холбогдох хүмүүстэй уулзуулж, нүүрэлдүүлнэ гэсний дараа тэрээр өлсгөлөнгөө зогсоов.
1996 он					
1.	Засгийн газрын мэдээ	1996.06.21. Баасан 117/557 /	А. Лхагва	Ажил хаялтаа одоо ч зогсоход бэлэн байна	ЗГМ-сонины 115 дахь дугаарт “Их дэлгүүр хэзээ нээгдэх нь тодорхойгүй байна” гэсэн мэдээ нийтэлсний дараа УИД-ийн ажил хаясан хүмүүсээс 25 худалдагч эмэгтэй манай сонины редакцид хандаж Танай сонинд нийтлэгдсэн ажил хаялтын тухай мэдээлэлд Гадаа сууж байгаа нь 100 гаруй энд 60 орчим хүн байна гэж Г. Сүхээ худал мэдээлэл өгсөн байна гэж гомдол мэдүүлээд ажил хаялтанд нийт 340 хүн оролцож байгаа ажил хаяагүй 30 орчим хүн бий гэжээ. Өлсгөлөнд 7 хүн хамрагдаж энэ хувьчлалыг дахин хянаж үзэж “Түшиг” компанийн үйл ажиллагааг зогсоож УИД-г төрийн өмчид үлдээж өгөөч гэсэн шаардлагын дагуу ч ажил хаясан юм гэж Түр хорооны дарга С. Оюунцэцэг ярьлаа. “Түшиг” компанийн үйл ажиллагааг зогсоовол өлсгөлөнг одоо ч зогсоход бэлэн байна гэж өлсгөлөн зарлаж буй хүмүүс хэллээ.
2.	Монголын үндэсний мэдээ, Засгийн газрын мэдээ	1996.07.19 Баасан 136/576/	Ш. Батцогт	Е.Гэрэлчулуун, С. Билэгсайхан нарыг шүүхэд шилжүүл гэв.	Саяхан Төв Ази банкны 6000 гаруй хадгаламж эзэмшигчдийг төлөөлсөн эсэргүүцлийн жагсаал төрийн ордны дэргэд боллоо. Хадгаламж эзэмшигч Д. Лхагва хэлэхдээ: 1995 оны 11 сараас хойш хадгаламж эзэмшигчдийн хадгалуулсан мөнгө, хүүг өгөхгүй байна. Үүний гол буруутан нь Монгол Банк, Төв Ази банкинд зөвшөөрөл өгсөн явдал юм. 1996 оны 7-р сарын 6-нд Монгол Банк зөвшөөрлөө буцаан авч Төв Ази банкыг шүүхэд шилжүүлсэнээр бидний эрх ашгийг хохироов. Иймд Монгол Банк биднийг хохиролгүй болгох ёстой гэв. Тэд УИХ-ын гишүүн Ё.Гэрэлчулуун, С.Билэгсайхан нарыг гаргаж ир, шүүхэд шилжүүл гэж хашгирцгааж байв.
3.	Засгийн газрын мэдээ	1996.08.14 Лхагва 154/594/	Т. Эрдэнэцогт	Мөнгөө авъя	Төв Ази банкинд мөнгөө хадгалуулаад эргүүлж авч чадаагүй иргэд төрийн ордны гадна “Анхаар! Банкныхан луйварчид, Улсын дээд шүүх хүний эрхийг хамгаал” гэсэн лоозон барьж цугларав. Тэдний төлөөлөгчид УИХ-ын төсөв санхүү, мөнгө зээлийн бодлогын байнгын хорооны дарга А. Ганбаатар, Монгол Банкны дэд ерөнхийлөгч О. Чулуунбат нартай

					уулзсаны дараа ордныг тойрч хашгирч байлаа.
4.	Засгийн газрын мэдээ.	1996.08.15 Пүрэв. 155/595/	Д. Баярмаа	Өлсгөлөнд оролцогчид сувилалд явлаа.	УИД-хэн ажил хаяж, өлсгөлөн зарласан. УИД-ийг шударга бус хувьчилсан тул бид ажлаа хаяж өлсгөлөн зарласан. Дэлгүүрийг түр ч болов төрийн мэдэлд үлдээсэн нь чухал. Тэд 15 хоног өлсгөлөн зарласан бөгөөд тэдний 3 нь байгууллагын зардлаар сувилалд явуулах болсон.
5	Засгийн газрын мэдээ	1996.09.20 Баасан	Т. Оюунбилэг	Цагдаагийнхан хуулийн дагуу ажилласан.	Нийслэлийн БЗД-ийн 19 хорооны 3-р байранд оршин сууж байсан 29 айлыг шүүхийн шийдвэрээр байрнаас нь албадан гаргаснаас оршин суугчид байрны үүдэн суулт хийжээ. Тэднийг цагдаагийнхан албадан тараасан ч суулт үргэлжилсээр байгаа бөгөөд өлсгөлөн зарлаж ч магадгүй байна.
6.	Ардын эрх	1996.10.05 Бямба 199/1417/		МАХН-ын гишүүд, дэмжигчдийн цулаан болов.	МАХН-ын гишүүд, дэмжигч, залуучуудын зохион байгуулсан “Нийгмийн шударга ёсны төлөө” цуглаан эрх чөлөөний талбайд болов. Шинэ засгийн газрын сүүлийн саруудад явуулсан улс төр, эдийн засгийн бодлого, үйл ажиллагаа нь нийгмийн эмзэг давхарга, өрх толгойлсон эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд, өндөр настан, төсөвт байгууллагын ажилчид оюутан сурагчид, хүүхэд багачуудын амьдралд хүндээр тусч байгаа, Засгийн газар тэтгэвэр, тэтгэмж, цалинг нэмж нийгмийн хамгааллын тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийн сануулав. Цуглаанд 350 гаруй хүн оролцов.
7.	Засгийн газрын мэдээ	1996.10.10. Пүрэв 194/634/	Д.Цэрэннадмид	Дөрвөн өлсгөлөн зарлажээ. хүн	УДШ-ийн байрны үүдэнд суулт хийж байсан 16 дугаар хорооллын нэгэн сууцнаас хөөгдсөн хүмүүсийн 4 нь өлсгөлөн зарлаад 3 хоножээ. Тэд бидэнд орох орон байхгүй. Бид тэр байрыг “Шунхлай” компанийн гэрээтэй зөвшөөрлийн бичигтэйгээр орсон айлууд. Гэтэл шүүх тэр байрны 2-дахь эзэмшигч болж гарч ирсэн 4-р цахилгаан станцныханд уг байрыг эзэмшүүлэхээр буруу шийдвэр гаргаж, бидний амь нас хохирвол шүүх хариуцахгүй гэдэг. Бидний эрхийг дэндүү боогдуулж байна гэжээ.
8.	Ардын эрх	1996.11.19 Мягмар 230/1448/	Э. Мөнхдарь	ҮЭ-ийн цуглаан болов.	Нийслэлийн ҮЭ-ийн холбоо, Худалдаа үйлчилгээний ажилчдын биеэ даасан ҮЭ-ийн холбооноос ҮЭ-ийн гишүүд, хөдөлмөрчдийн цуглааныг зохион байгуулав. Цуглаан эрх чөлөөний талбайд болсон бөгөөд УИХ, ЗГ-т хандаж ажлын байрыг нэмэгдүүлэх, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх, ядуу айл өрхөд зориулсан орон сууц барьж эхлүүлэх зэрэг шаардлага тавьжээ.

1997 он

1.	Өнөөдөр	1997.01.09 Пүрэв 006/044/	Б. Элдэв	Үйлдвэрчний байгууллага жагсаал хийлээ.	УИХ-ын ээлжит чуулганаар нийгмийн хамгаалалтын багц хууль, нийгмийн даатгалын хуулиудад өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан МҮЭ-ийн 13 салбар зөвлөлөөс зохион байгуулсан 5000 гаруй хүний жагсаал болов. Уг жагсаал нь хөдөлмөрчдийн нийгмийн хамгаалын асуудлаарх арга хэмжээг цаг алдалгүй авахыг ЗГ-аас шаардаж байлаа.
2.	Ардын эрх	1997.01.09 Пүрэв 6/1484/	Ж.Чимэдцэрэн	Тайван жагсаал болов.	Хөдөлмөрчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн тайван жагсаал боллоо. Жагсагчид хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллагчдад хөнгөлттэй тэтгэвэр тогтоосон хуулийг хэвээр байлгах, цалин хөлс нэмэгдүүлэх шаардлагыг төр засгийн газарт тавьлаа.
3.	Засгийн газрын мэдээ	1997.01.09 Пүрэв. 6/698/	Ц. Бадрах	Хүнд хортой нөхцлийн заалтыг хэвээр үлдээхийг шаардав.	Нийгмийн эмзэг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхийг шаардсан олон мянган хүний цуглаан өчигдөр Д.Сүхбаатарын талбайд боллоо. Цуглаанд оролцогчид "Нийгмийн даатгал"-ын хуулинд хөдөлмөрийн хүнд, хортой нөхцлийн заалтыг хэвээр үлдээх, төсвийн байгууллагын ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг зогсоох, ҮҮ-лэлийг сэргээхийг ЗГ-аас шаардаж байлаа.
4.	Ардын эрх	1997.01.28 Мягмар 19/1497/	Б. Туяа	Эмч нар өлсгөлөн зарлав.	Дорнод аймгийн ЭМ-ийн төвийн даргаар томилогдсон Д. Манлайг хүлээж авахаас татгалзаж аймгийн нэгдсэн эмнэлгийн 14 их эмч ажлаас халагдах өргөдлөө өгч байсан. Түүнээс хойш сар гаруй болоход Д. Манлай тэдгээр эмчийг хүлээн авч уулзаж, хариу өгөөгүй учир тус эмнэлгийн их эмч нар өлсгөлөн зарлажээ.
5.	Өнөөдөр	1997.01.30 Пүрэв №021/059/	Ч.Лхагва	Эмч нар жагсаал зохион байгуулна.	Сүүлийн үед мөнгөний ханш хурдацтай унах болсон нь эмч нарын ахуй амьдралд хүндээр тусах болжээ. Мөн эмнэлгийн ажилчдын дунд явуулж буй аттестатчилал нь олон эмч нарыг ажилгүйдлийн эгнээнд оруулах үндэс болж байгаа аж. Баттай эх сурвалжаас авсан мэдээгээр Клиникийн I эмнэлэгт ажил хаях түр хороо байгуулагдсан бөгөөд Хүүхдийн II, ЭНЭМХ нэгдсэн төв, Сэтгэцийн эмгэгийн клинникийн эмнэлэгийн ажилчид цалин хөлс нэмэх, ажиллах нөхцлийг сайжруулах тухай бичсэн өргөх бичгийг ЗГ, УИХ-д хандан илгээгээд байна. ЗГ, УИХ дорвитой арга хэмжээ авахгүй бол жагсаал зохион байгуулахаар шийдээд байна.

6.	Өнөөдөр	1997.02.05 Лхагва 025/063/	З. Замилан	Суулт хийлээ.	Ялалтын талбайд эхэлсэн Монголоо мандуулах “Цогт” нэгдлийн удирдах зөвлөлийн тайван замаар эхэлсэн улс төрийн суулт 2 дахь хоногоо үргэлжилж 2000 гаруй хүний гарын үсэг цуглуулжээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүд, Халамжлагчгүй өндөр настан, багш, эмч, урлаг соёлын болоод төсвийн бага цалинтай, оюутан сурагчдын нийгмийн эрх ашгийг хамгаалахаар тэмцэж буй тэдний үйл ажиллагааг ЗГ хүлээн зөвшөөрч тодорхой арга хэмжээ авахгүй бол 1200 хүнийг оролцуулсан улс төрийн өлсгөлөн болон үргэжилнэ гэж зохион байгуулагчид тооцож байгаа ажээ.
7.	Өнөөдөр	1997.02.26 Лхагва 040/078/		Эсэргүүцлийн аян, цуглаан бол зөвхөн эхлэл.	Өчигдөр 15 цагаас эхлэн оюутнууд автобусаар үнэгүй зорчин эсэргүүцэл илэрхийлж, улмаар 16 цагт эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгуулах тухай МОҮЭ-ийн холбооны тэргүүлэгч Баасандоржтой уулзахад Өнгөрсөн онд оюутны НТ-ийн хөнгөлөлтөд олгогдоогүй саруудын мөнгийг нөхөн олгох тус хөнгөлөлт нь ямар ч хэлбэртэй байж болох, хөнгөлөлтийг нийт оюутнуудад ялгаваргүйгээр эдлүүлэх шаардлага тавьсан байна.
8.	Өнөөдөр	1997.03.01 Бямба 043/081/	Д. Балдан	Сануулах ажил хаялт эхэллээ.	Эх нялхсын төвийн эмч ажилчид сануулах ажил хаялт хийлээ. Тэд соёлын төвдөө цугларч олон эмч, ажилтан, ажилчид үг хэллээ. ЗГ-ыг нэн яаралтай арга хэмжээ авч эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх шаардлага тавьж, шаардлагыг хүлээн авахгүй бол улс төрийн тэмцлийн дараагийн шатанд шилжихээ сануулж, 304 хүн сануулах ажил хаялт эхэллээ.
9.	Өнөөдөр	1997.04.05 Бямба 068/106/	Д. Цэнд	Багш нар сануулах цуглаан хийлээ.	Өчигдөр ялалтын талбайд 4000 гаруй багш нар оролцсон сануулах цуглаан боллоо. Цуглааныг БСШУ-ны ҮЭ-ийн чөлөөт холбоо дангаараа зохион байгууллаа. Багш нарын авч байгаа цалин амьдралд хүрэлцэхгүй хүнд байгаа бөгөөд 5 сарын 1-ний дотор цалинг нэмэгдүүлэхгүй бол тэмцлийн дараагийн шатанд шилжихээ мэдэгдэв.
10.	Ардын эрх	1997.04.05 Бямба 73/1551/	Б. Ханддолгор	Цалингаа нэмэгдүүлэхийг шаардав.	МБСШУ-ны үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгуулав. Нийслэлийн цэцэрлэг, ЕБ, Их дээд сургуулиудын багш нар оролцсон цуглаанд оролцогчид бидний цалингийн дээд хэмжээ 26.600 төгрөг байгаа нь үнэ чөлөөлөгдөж, төгрөгийн ханш буурч байгаа үед амьдралд хүрэлцэхгүй байна гэж Ерөнхий сайд М.

					Энхсайханд шаардах бичиг илгээжээ.
11.	Засгийн газрын мэдээ	1997.04.12 Бямба 73/765	Манай сурвалжлагч	Сүхбаатрын талбай дахь өлсгөлөн.	Сүхбаатрын талбайд өлсгөлөн зарлагсадтай МУ-ын Ерөнхий Сайд М.Энхсайхан, ЭМНХ Сайд Л.Зориг, НЗД бөгөөд УБ хотын захирагч Ж.Наранцацралт нар уулзаж тэдний шаардлага болон ЗГ-аас баримталж буй бодлого үйл ажиллагааг тайлбарлан цаашид бололцоотой бүх арга хэмжээг авч ажиллахаа мэдэгдэв.
12.	Ардын эрх	1997.05.01 Пүрэв /1573/ 95	Б.Туяа	Суулт өлсгөлөнд шилжив.	Дорнод аймгийн "Дорнод импэкс" компанийхан хэсэг ажилчин төлөөлөн удирдах хурлын шийдвэрийг эсэргүүцэж суулт хийсэн. Тэд компанийн гүйцэтгэх захирлыг хуралдаанаар шууд томилсон гэж үзэж уг асуудлыг хуульд нийцүүлэн шийдэх хүртэл тэмцлээ үргэлжлүүлнэ гэдгээ мэдэгджээ.
13.	Ардын эрх	1997.05.01 Пүрэв /1573/ 95	Р.Сүрэн	Тээвэрчид цуглаан хийв.	УИХ-аас баталсан Татварын багц хуулийн "Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн ..." хуулийн зарим заалтыг эсэргүүцэн тээвэрчдийн цуглааныг нийслэлийн XII хороолол болон Гурвалжингийн гүүрний ойролцоо боллоо. Цуглаанд оролцогсод УИХ-д энэ талаар санал тавьсан боловч хүлээж аваагүй хэмээн Төрийн ордны ойролцоо очиж анхааруулах журмаар дохиогоо дуугарган, гэрлээ асааж, зогсохоор хөдөллөө.
14.	Ардын эрх	1997.05.09 Баасан 102/1580/	Ч. Хэрлэн	Багш нар 4 шаардлага тавьжээ.	Нийслэлийн ЕБС, цэцэрлэгийн багш нарын сануулах ажил хаялт болж 92 сургууль, 86 цэцэрлэгийн багш хамрагдсан байна. МБШУ-ны ҮЭ-ийн чөлөөт холбооны дарга М.Чимэддорж Төр засгаас хэрэгжүүлж буй бодлого багш нарын эрх ашигт нийцэхгүй байна, боловсролын салбарт хийх өөрчлөлтийг зарим багш эсэргүүцэж, зарим нь зөвшөөрсөн боловч орон тооны цомхтгол хийхгүй байх гэсэн болзол тавьсан, мөн цалин нэмэх, мөн 10 дугаар анги төгсөгчдөөс авах үндсэн 3 шалгалтыг тестээр авна, түүнийг яам дүгнэнэ гэж байгаа. Багш нар биднээс хүүхдийг хөндийрүүлээ. Тестийг яам авах нь буруу үзэж байна гэжээ.
15.	Ардын эрх	1997.09.19 Баасан 215/1693/	Л.Сугар	Оюутнууд эсэргүүцлээ илэрхийллээ.	Оюутны холбооны зохицуулах төвөөс зохион байгуулсан эсэргүүцлийн цуглаан боллоо. Цуглаанд оролцогчид сургалтын төлбөрийн хэмжээг үндэслэлтэй тогтоож 25-аас доошгүй хувь, дотуур байрны төлбөрийг 50 хувь бууруулахыг шаардаж байлаа. Цуглаанд 1000 гаруй оюутан оролцов.
16.	Ардын эрх	1997.10.27	Б. Үлэмж	Цуглаан болов	Соёл үйлчилгээний "Чандмань" төвийн барилгыг Дүрслэх

		Даваа 247/1725/			урлагийн музейд шилжүүлэх тухай ТӨХ-ны шийдвэрийг дэмжсэн “Мөнхийн урлаг-мөхлийн ирмэгт” цуглааныг эрх чөлөөний талбайд зохион байгууллаа. Цуглаанд нийт 300 гаруй уран бүтээлчид оролцов.
17.	Өнөөдөр	1997.10.02 Пүрэв 194/232/	Б.Оюун	Барилгачдын суулт хэд хоног үргэлжилж мэднэ.	Ялалтын талбайд суулт хийж байгаа “Тахь мон” компанийн барилгачид Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-т шаардлага тавиад 2 хонолоо. Тэд хотын гүйцэтгэх захиргаанд 9 байр олгох, бидний барьсан сууцанд орчихоод байгаа 20 айлын сантехникийн угсралтын асуудлыг шийдвэрлүүлэх гэсэн юм. Бидний хүсэлтийг хэзээ шийдвэрлэнэ тэр болтол суултаа үргэлжүүлнэ гэлээ.
18.	Өнөөдөр	1997.10.14 Мягмар 202/240/	З. Мэнд	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж үнэ нэмсэн гэлээ.	Эрх чөлөөний талбай дээр болсон өндөр настнуудын цуглаан болж цахилгаан, дулааны үнийг багасгахыг шаардаж цаашид дахин эсэргүүцлээ үргэлжлүүлнэ гэж мэдэгдэж байлаа.
19.	Өнөөдөр	1997.10.17 Баасан 205/243/	Д. Сүрэн	Эв нэгдлийн цуглаан	УБ хотын МАХН-ын хороо, МАСЗХ, МНХ зэрэг байгууллага хамтран уржигдар 16 цагт эрх чөлөөний талбайд эв нэгдлийн цуглаан зохион байгууллаа. Цуглааныг хотын МАХН-ын хорооны дарга М. Энхболд удирдан явуулав. Тэд ЗГ-т илтгэл алдарч буйгаа ярьж ЗГ-ыг огцруулах саналыг дэмжиж буйгаа илэрхийллээ.
20.	Өнөөдөр	1997.10.25 Бямба 210/248/	М. Сайхан	Луйврын эсрэг эцсээ хүртэл тэмцэнэ.	СХД-ийн 18-р хорооны 22-ын “Б” байрны 4-р орцны оршин суугчид төрийн ордны өмнө суулт хийж байна. Учир нь тэд улсын ордертой, орон сууцны контортой, гэрээ бүхий орон сууцаа Монголын газрын тосны хэрэг эрхлэх газарт алдсандаа энд зогч байгаа аж.
21.	Өнөөдөр	1997.10.29 Лхагв 212/250/	Ц.Мөнхцэцэг	Өлсгөлөн зарлагчдын биеийн байдлыг Г.Бошигт үзэж байна.	МНХ 10-р сарын 27-оос эхлэн ялалтын талбайд өлсгөлөн зарлалаа. Тэд УИХ-ыг тараах, ЗГ-ыг огцруулах зарчмын тухай хуультай болгох, эдийн засгийн талаархи төрийн согогтой бодлогуудыг таслан зогсоох, эгэл борчуудын эрх ашгийг хамгаалах “Бүх ардын онц шүүхтэй” болох гэх мэт 10 зүйлийн шаардлага тавьсны гол нь УИХ-ыг тараах тухай бөгөөд одоогоор 7 хүн өлсгөлөн зарлаад байна.
22.	Ардын эрх	1997.12.11 Пүрэв 285/1763/		Сэтгүүлч суулт зарлалаа.	УБ сонины ажилтан, сэтгүүлч О.Лхагвадорж шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж суулт зарлажээ. Түүний “Үнэний төлөө биш мөнгөний төлөө”, “Боол” нийтлэлдээ хүний хийсэн үйлдэлд дүгнэлт гаргасныг төлүүлэхээр 3 шатны шүүх шийдвэрлэжээ. Энэ шийдвэрийг тэрээд шударга бус гэж үзэж

					буй аж.
23.	Өнөөдөр	1997.12.17 Лхагва 246/284/	Д. Өнөдэлгэр	Эрх чөлөөний талбайд цуглаан хийж эсэргүүцлээ илэрхийлэв.	Эрх чөлөөний талбайд МУНН, Монголын тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ын холбооны төв хүрээ зэрэг 6 байгууллага, холбоо, хөдөлмөрчдийн цуглаан хийв. МУНН-ын дарга О.Дашбалбар үг хэлэхдээ: МУ-ын үндсэн хуулиар олгогдсон монгол хүн амьд явах эрхийг баталгаажуулахын тулд энэ цуглааныг хийж байна гэдгээ хэллээ.
1998 он					
1.	Ардын эрх	1998.07.01 Лхагва 153/1932/	Н.Лхагвасүрэн Д.Сэрээтэр	Бухимдсан эцэг эхчүүд Алтайд цуглаан зохион байгуулжээ.	Уралдаант шалгалт будилаантай боллоо гэж үзсэн эцэг, эхчүүд хэвлэл мэдээллийнхнийг оролцуулан Алтай хотод цуглаан зохион байгууллаа. Цуглаан дээр эцэг, эх, сурагчдын холбоо байгуулснаа мэдэгдэж үг хэлсэн хүмүүс энэ хаврын шалгалтын зөрчил, дутагдлыг хурцаар шүүмжлэв. Тест нь задарсан, зарим багш нар шефр дамжуулсан гэж үзсэн.
2.	Ардын эрх	1998.07.28 Мягмар 175/1954/	Б.Үлэмж	Өлсгөлөнгийн горимыг чангатгав.	Улс төрийн өлсгөлөн зарлаад байгаа Залуучуудын нэгдсэн холбоо, Хүний эрх, шударга ёсны хөдөлгөөнөөс цуглаан зохион байгуулав. ЗГ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах санал тавьж байсан тус хөдөлгөөнийхөн ард нийтийн санал асуулга явуулах, УИХ сайн дураараа тарах шаардлагыг хатуу тавьж байгааг цуглааны үеэр мэдэгдлээ.
3.	Ардын эрх	1998.08.27 Пүрэв 201/1980/	П.Энхжаргал	Чимээгүй жагсаал боллоо.	Зүүн Азийн эмэгтэйчүүдийн III чуулганы төлөөлөгчид Сүхбаатарын талбайд чимээгүй цуглаан зохион байгуулав. Тэд Монголын хүүхдийн ордноос явж Сүхбаатарын талбайд очин 10 гаруй минут дуугүй зогсож дэлхийн өнцөг булан бүрт хүчирхийлэлд өртөн амь насаа алдсан эмэгтэйчүүдийн дурсгалыг хүндэтгэжээ.
4.	Ардын эрх	1998.09.08 Мягмар 211/1990/	Б.Үлэмж	Хөдөлгөөнийг түр хаалаа.	Монголын тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалах төв зөвлөлийнхөн төв шуудангийн өмнөх замын хөдөлгөөнийг 30-аад минут орчим хаалаа. Хэлмэгдэгсдийн хөшөөний хажууд суулт зарлаад сар гаруй болж буй тус зөвлөлийнхөн УИХ-ын дарга Р.Гончигдорж болон ЭМНХ-ын сайд Ш.Батбаяртай уулзах хүсэлт тавьсан боловч хүсэлтийг биелүүлээгүй учир замын хөдөлгөөнийг хаасан гэж мэдэгджээ.
5.	Ардын эрх	1998.10.07 Лхагва 236/2015/		Өлгийд чимээгүй жагсаал боллоо.	С.Зоригийн дурсгалыг хүндэтгэсэн эмгэнэл, гашуудлын арга хэмжээ явагдсан байна. Үүнд Баян-Өлгийчүүд Өлгий сумын төв талбайд чимээгүй зулт жагсаал хийжээ.
6.	Ардын эрх	1998.11.05 Пүрэв	Р.Отгон	Олон нийтийн цуглаанд 1000	"Иргэд хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллыг дордуулахгүйн эсрэг" уриан дор МҮЭ-үүдээс олон нийтийн цуглаан зохион

		261/2040/		орчим хүн оролцлоо.	байгууллаа. МҮЭ-үүдээс хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллын нэмэлт арга хэмжээ авахуулах, амжиргааны болон цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох, орон нутгийн төсвийн байгууллагад ажиллагсдын цалин хөлс, иргэдийн тэтгэвэр тэтгэмжийг нэн даруй нөхөн олгох зэрэг шаардлагыг УИХ, ЗГ-т тавилаа. Цуглаанд оролцсон 1000 гаруй хүн Эрх чөлөөний талбайгаас Төрийн ордон хүртэл жагсаалаар явж дээрх шаардлагыг тавилаа.
7.	Өнөөдөр	1998.11.06 Баасан 216/510/		Орон нутагт цуглаан болов.	МҮЭ-үүдээс “Иргэд хөдөлмөрчдийн нийгмийн хамгааллыг дордуулахгүйн эсрэг” уриан дор Аймаг, сумдад болсон цуглаан дээр төсвийн байгууллагын ажилтнуудын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж хугацаандаа олгогдохгүй байгааг шүүмжилж, зарим нэмэгдэл арга хэмжээ авахыг шаардсан байна. Увс аймагт 1000 орчим хүний цуглаан болж, цалин тэтгэврийг архи, гурил зэрэг бараагаар тооцож өгдөгийг эцэс болгохыг аймгийн ЗД, ИТХ-ын даргаас шаардсан байна.
8.	Ардын эрх	1998.12.23 Пүрэв 303/2082/	Ч.Хэрлэн	“Ирээдүй”-хэн ажил хаяв.	Нийслэлийн СХД-ийн “Ирээдүй” цогцолборын 400-гаад багш 7 хоногийн хугацаатай сануулах ажил хаялт зарлалаа. 11, 12-р сарын цалин өгөөгүй, нийгмийн даатгалын төлбөр хийгдээгүй зэргээс шалтгаалан уг ажил хаялтыг зохион байгуулж байгаа юм. Энэ хугацаанд цалинг нөхөн олгохгүй тохиолдолд үргэлжлүүлэн ажил хаях ажээ.
9.	Ардын эрх	1998.04.07 Мягмар 080/1859/	Б.Цолмон	Нэгдсэн хөдөлгөөн цуглаан хийв.	УИХ-ын хаврын чуулган эхэлсэн өдөр МНХ-ний идэвхтэн гишүүд Д.Сүхбаатарын талбайд цугларч УИХ, ЗГ-ыг огцруулах шаардлагаа давтлаа. Цуглаанд оролцогчдын зарим нь “Шарын голын уурхай”, “Орхон аймаг” гэж пайз зүүж явсан нь хүмүүсийн гайхлыг төрүүлж байв.
10.	Ардын эрх	1998.04.16 Пүрэв 088/1867/	Б.Тэмүүлэн	Засгийн газар цалин, тэтгэмжийг нэмлээ.	Эрх чөлөөний талбайд МҮЭ-үүдийн холбооноос зохион байгуулсан хөдөлмөрчдийн жагсаал цуглаан боллоо. Тэд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг нэмэх, ажлын байрыг нэмэгдүүлэхийг шаардсан бөгөөд тэдний шаардлагыг хүлээн авч шийдвэрлэх болжээ.
11.	ЗГ мэдээ	1998.08.08 Бямба 159/1111/	Э.Эрдэнэ	Нэгдсэн хөдөлгөөнийхөн төрийн ордонд нэвтэрчээ.	Монголын нэгдсэн хөдөлгөөнийхөн Төрийн ордонд нэвтрэн орж УИХ-ын гишүүн М.Зэнээгийн өрөө хүрч парламент дахь олонхи, цөөнхийн бүлгийн төлөөлөгчидтэй уулзуулах шаардлага тавьлаа.
12.	ЗГ-ын мэдээ	1998.08.14 Баасан 163	Сурвалжлагч	Өлсгөлөн зогсож, өөр нэг	Орхон аймгийн Баян-Өндөр сумын ЗД “Өлсгөлөн зогсоох тухай” захирамж гаргав. Энэ хөдөлгөөний зорилго нь ТӨХ-

		/1115/		хөдөлгөөн байгуулагдав.	ний үйл ажиллагааг дэмжиж, уулын баяжуулах үйлдвэр дээр Төрийн өмч их хэмжээгээр янз бүрийн байдлаар хулгайд алдагддаг, улсын үйлдвэрийн өмч хөрөнгө гэнэт хувьд шилжиж байгаад иргэн бүр хөндлөнгийн хяналт тавьж байх зорилготой.
13.	Засгийн газрын мэдээ	1998.05.02 Бямба 89/1041/	О. Туяа	Цуглаан болов.	МНХ, Нийгмийн шударга ёсны төлөө бүх ард түмний хөдөлгөөнөөс СБ-ын талбайд цуглаан зохион байгууллаа. УИХ-ын дарга Р. Гончигдоржийг гарч ирж үгээ хэлэхийг шаардаж байлаа.
14.	Ардын эрх	1998.05.15 Баасан 114/1893/	Г.Эрдэнэбат	Жүжигчид цуглаан хийлээ.	ҮЖАТ-н үүдэн дээр хашаандаа барилга бариулахгүй гэж урлагийнхан цуглаан хийлээ.
15.	Ардын эрх	1998.05.20 Лхагва 118/1897/	Д. Халиун	Замын хөдөлгөөнийг саатууллаа.	Г.Бошигтын МНХ-хон төв шуудангийн өмнөх 4 замын хөдөлгөөнийг 18 цаг хүртэл хаалаа. Тэд үдээс өмнө СБ-ын талбайд цуглаан зохион байгуулж "УИХ тар" гэж чанга яригчаар хашгиралдав. УИХ тарахгүй бол маргааш дахиад замын хөдөлгөөн хаана гэж мэдэгдэв.
16.	Ардын эрх	1998.06.04 Пүрэв 131/1910/	О.Билэгт	МАХН цуглаан зохион байгуулав.	МАХН-ын удирдах зөвлөл, УИХ дахь МАХН-ын бүлгээс УБ хотын нийт оршин суугчид иргэдэд хандан Эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгуулав. Тэд ЗГ төрийн өмчийн СББ-ийг хувийн хэвшлийн "Голомт" банкинд нийлүүлж хууль ёсыг зөрчиж, ард түмний хөрөнгийг төр, засгийн эрх баригч хэсэг бүлэг хуваан завших хэлбэрт илтээр шилжүүлж байна гэж мэдээллээ.
17.	Ардын эрх	1998.06.19 Баасан 144/1923/	О. Билэгт	Сануулах суулт зохион байгуулав.	МҮЭХолбооноос төрийн ордны хойд цэцэрлэгийн талбайд сануулах уулзалт зохион байгууллаа. Хөдөлмөрчдийн эрх ашгийн тулгамдсан асуудлаар ЗГ-т удаа дараа шаардлага тавьсан. ЗГ албан ёсны хариу өгөөгүй учир тэд тавьсан шаардлагадаа хариу нэхэх пикет хэмээн энэхүү суултаа нэрлэжээ. Хариу өгөхгүй бол тэмцлийн дараагийн хэлбэрт шилжинэ гэв.
18.	Ардын эрх	1998.09.23 Лхагва 224/2003/	О.Билэгт	Автобусны жолооч нар ажил хаяв.	"Дарь эхийн овоо-вокзал"-ын чиглэлийн автобусны замд тусгай үйлчилгээний автокомпанийн Зил маркийн 54-58 дугаартай машин ачиж явсан ялгадасаа энэ замд 2 км орчим цувиулан асгаснаас автобус болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хүндрэл учирчээ. Дугуйн нь ялгадас наалдаж зорчигчдод хүртэл үнэр нь шингэж, дотор нь явахад бэрх болжээ. Иймд жолооч нар ажил хаяжээ.

19.	Засгийн газрын мэдээ	1998.09.26 Бямба 193/1145/	Н. Цасчихэр	Гурван эмэгтэйн нэг нь хүчирхийлэлд өртдөг	Өчигдөр эрх чөлөөний талбайд болсон цуглаан дээр “Гурван эмэгтэйн нэг нь хүчирхийлэлд өртдөг” гэсэн ХЭҮТ-ийн хэвлэлийн ажилтан Ш.Бадамханд ярилаа. УИХ-ын намрын чуулганд “Хүчирхийлийн эсрэг хуулийн төсөл”-ийг дэмжүүлэх зорилгоор ийн цуглаан зохион байгуулжээ. МОХ, нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газртай хамтран энэхүү цуглааныг хийжээ.
20.	Засгийн газрын мэдээ	1998.12.23 Лхагва 256/1208/	Г. Сансар		Нийслэлийн БГД-ийн “Ирээдүй цогцолбор”-ын 1-р байрны 43 багш хугацаагүй, сануулах ажил хаялт зарлажээ. Тэд багш нарын цалин хөлсийг хугацаанд нь олгох, нийгмийн даатгалын шимтгэлийг цаг хугацаанд нь шилжүүлэх шаардлага тавьжээ.
1999 он					
1.	Зууны мэдээ	1999.01.14 Пүрэв 8/008/	Г.Түмэнжаргал	Байрнаас хөөгдөөд суулт зарлав.	Багануур дүүргийн шүүх Багахангай дүүргийн 10 айлыг байрнаас нь албадан гаргах шийдвэр гаргажээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид 5 айлыг байрнаас нь албадан гаргасан аж. Үүнээс үүдээд тэдгээр иргэдийн нэг нь шүүхийн шийдвэрийг хүндэтгэж байгаа ч гагцхүү идэр есийн хүйтэнд нялх хүүхэдтэй хүмүүсийг гадаа гудамжинд хөөж гаргасныг эсэргүүцэж буй юм байна.
2.	Зууны мэдээ	1999.03.03 Лхагва 40/040/	Т.Билгээ	“Говь”-ийн ажилчдын ажил хаях дуулиан.	“Говь” компанийн хэсэг ажилчин ажил хаяхыг бусдадаа уриалжээ. Харин удирдлага нь тэднийг ажлаас халжээ гэсэн мэдээллийг тодруулбал. Утасны цехэд ажилладаг 4 эмэгтэй сонордуулга гэсэн бичиг (цалин нэмэх хэрэгтэй) гаргаж үйлдвэрийн хаалган дээр наасан байна.
3.	Өнөөдөр	1999.03.03 Лхагва 49/599/	С.Содбат	Жаргалант сумын багш нар ажил хаяжээ.	Төв аймгийн Жаргалант сумын багш нар 1998 оны сүүлийн 3 сарынхаа цалинг авч чадаагүй, 1999 он гарсаар 1 сарын цалингийнхаа 70 хувийг л авснаас өөр орлогогүй болсон тул ажил хаялт зарласан тухай мэдээлэв.
4.	Өнөөдөр	1999.03.11 Пүрэв 56/606/	Л.Батцэнгэл	Зургаан сумын багш нар ажил хаяжээ.	Завхан аймгийн Асгат, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын багш нар ажил хаялт зарлаад байгаагаас үзэхэд, дээрх сумын багш нарын цалинг өнгөрсөн оны 10-р сараас хойш өгөөгүй учир арга буюу ажил хаяхад хүргэсэн бололтой.
5.	Зууны мэдээ	1999.03.24 Лхагва 55/055/	П.Түмэн	Тэмцлийг идэвхжүүлэх хороо байгуулав.	Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 400 гаруй багш нар цугларч, хот хөдөөгийн бүх тэмцлийг нэгтгэн удирдах зорилгоор 25 хүний бүрэлдэхүүнтэй “Тэмцлийг идэвхжүүлэх” хороо байгууллаа.
6.	Зууны	1999.03.30	П.Түмэн	Багш нарын	СХД-ийн ЗДТГ-ын үүдэнд тус дүүргийн сургууль, цэцэрлэгийн

	мэдээ	Мягмар 59/059/		тэмцэл эхэллээ.	500 гаруй багш, ажилчид пикет (удирдлагаа ажлын байранд нь нэвтрүүлэхгүй байх) хийлээ. Тэд цалин хөлсийг хугацаанд нь тавих, эс өгвөл хуулийн дагуу алданги өгөх, ЭМД-ын мөнгийг цалингаас авсан атлаа зохих газарт нь шилжүүлээгүй зэрэг шаардлага тавьжээ.
7.	Зууны мэдээ	1999.04.01 Пүрэв 61//061/	П.Түмэн	Багш нар сайддаа мэдэгдэл өглөө.	Гэгээрлийн яамнаас нийслэлийн ЕБС-иудын ҮЭ-ийн байгууллагуудын мэдэгдэлд өгсөн хариу нь боловсролын үйл ажиллагаанд шүүмжлэл, дүгнэлттэй хандсан багш нарын санал, шаардлагыг илт үгүйсгэн дутагдлаа хамгаалсан утгатай болжээ. Иймд хот, хөдөөгийн олон мянган багш нар болон багш нарын тэмцлийг зохицуулах зөвлөлөөс өчигдөр гэгээрлийн сайд А.Баттөрд эсэргүүцлийн мэдэгдэл өгчээ. Үүнд: хичээлийн жилийн дундуур журнал, хувийн хэргийг сольж сурагчдын мэдлэгийг үнэлэх шинэ журмыг мөрдүүлэх гэж шахаж байгаа нь сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж байна. Иймээс шалгалт авах эрхийг сургууль, багшид үлдээх, багш нарын нэр хүндэд халдах явдлыг зогсоох, хувцас формыг хэрэглэх эсэхийг тухайн сургууль өөрсдөө шийддэг болохыг шаарджээ. Шаардлагын хариуг албан ёсоор 4-5 хоногийн дотор өгөхгүй бол улс төрийн шаардлага бүхий нийтийг хамарсан тэмцэлд шилжих болно гэдгийг мэдэгджээ.
8.	Зууны мэдээ	1999.04.05 Даваа 63/063/	Х.Аянга	МНХ-ний жийрхдэг хууч хөдлөв.	МНХ-г хуульд нийцээгүй үйл ажиллагаа явуулсны учир ХЗЯ, Төрийн бус байгууллагынхан нь зөвшөөрлийг цуцалсан билээ. Гэвч нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүх эргүүлэн сэргээх шийдвэр гаргасан учир эрхээ эдэлж, өнөөдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 9 цагаас цуглаан зохион байгуулах гэж байна. Ийм арга хэмжээ явуулахад тусгай журам байдгыг тус хөдөлгөөний удирдлагад УАБХГ, Нийслэлийн ЦГ-аас урьдчилан албан ёсоор сануулжээ. Ялалтын талбайд хаваржин зунжин өлсгөлөн зарлаж өвөлдөө ичсэн НХ-нийхний ээлжит “тэмцэл” ... эхэлсэн аж.
9.	Зууны мэдээ	1999.04.06 Мягмар №64 /064/	Т.Маргад	Нэгдсэн хөдөлгөөнийхөн чихмэл шатааж “бухимдлаа тайлав”.	Ялалтын талбайд өнгөрсөн жилийн турш өлсгөлөн зарлаж суулт хийсэн МНХ-хөн өчигдөр 9 цагт Сүхбаатарын талбайд цуглаан зохион байгууллаа. “Ноцтой гэмт хэргийн уурхай УИХ ямар ч болзолгүй тар”, “Ард түмний өмчийг буцааж өг” хэмээн лоозон барьсан 40-50-иад хүн оролцлоо. УИХ, ЗГ-т хандаж хэд хэдэн хүн үг хэлсний дараа 10 цаг 30 минутын орчим

					хүний дүрс бүхий даавуун чихмэлийн урд Гончигдорж гэж бичсэн байсан бөгөөд түүнийгээ шатаав. Үүнийгээ тэд УИХ-ын барцадыг арилгаж байна хэмээн ярьцгааж байв. Цуглаанд оролцогчид төр засгийн удирдлагуудын хэн нэгэнд шаардах хуудас өгөх гэсэн боловч хүн гарч ирээгүй учир төрийн ордныг тойрон алхаж бухимдлаа илэрхийлцэгээв.
10.	Өдрийн сонин	1999.05.01 Бямба 46/46/	Б.Батбилэг	УИХ-д 2 зүйлийн шаардлага тавьлаа.	МҮЭ-үүдийн холбоо, АҮ-ийн болон ХАА, Хүнсний ажилчдын ҮЭ-ийн холбоо хамтран өчигдөр Эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгууллаа. Тэд үндэсний үйлвэрлэлээ дэмжиж, ажилгүйдлийг арилгая гэсэн цуглаанд үйлдвэрийн ажилчид, оюутнууд ахмад настнууд оролцлоо.
11.	Зууны мэдээ	1999.05.03 Даваа №83 /083/	Т.Жаргал	Сэлэнгийн багш нар ажил хаяжээ.	Сэлэнгэ аймгийн Мандал сумын сургууль, цэцэрлэгийн багш нар энэ сарын 29-нөөс эхлэн сануулах ажил хаялт зарлалаа. Тэд сүүлийн 3 сарын цалингаа аваагүй бөгөөд өмнө нь аймгийнхаа удирдлагад хандаад үр дүнд хүрээгүйгээс ийм алхам хийхэд хүрчээ. Одоогоор сануулах ажил хаялтад 400 орчим багш хамрагдаад байна.
12.	Зууны мэдээ	1999.05.05 Лхагва 85/085/	Н.Энхээ	Мянган багш суулт хийжээ.	Сонгино хайрхан дүүргийн 50-иад сургууль, цэцэрлэгийн 400-гаад багш нар өнгөрсөн 3 сараас хойш цалингаа аваагүй зэрэг хэд хэдэн шалтгаанаар МҮЭ-үүдийн холбооны хурлын танхимд өнөөдөр 12 цагаас цуглаан зохион байгуулахаар болжээ. Цуглаанаас ЗГ-т хандаж шаардах хуудас гаргана. Асуудлыг шийдэхгүй бол шат дараалалтай арга хэмжээ авч, 1000 эмэгтэй багшийн суулт зарлаж тэмцлээ илэрхийлнэ гэж Ж.Батзориг ярив.
13.	Зууны мэдээ	1999.05.05 Баасан 87/087/	Т.Жаргал	Оюутнууд шийдвэрийг эсэргүүцэж байна.	Энэ сараас эхлэн Хотын тээвэр зохицуулалтын газрын дарга Н.Нямдаваагийн тушаалаар нийтийн тээврийн хэрэгслээр 7 хоногийн бямба, нямд болон бусад өдрийн оройн 21.00 цагаас хойш оюутны хөнгөлөлтийн билетээр үнэгүй зорчихгүй байх арга хэмжээ авч эхэлжээ. Үүнийг тус газрынхан алдагдлаа багасгахын тулд хийсэн алхам гэж тайлбарлаж буй аж. Өчигдөр МХХ-нд хэвлэлийн бага хурал хийлгэсэн ТИС-ийн оюутны холбооныхон эсэргүүцэж, энэ шийдвэрээ хүчингүй болгохыг шаардаж, үүнийг хүлээн авахгүй бол шат дараалан эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулж, улс төрийн тэмцлийн хэлбэрийг ашигласан ч болохгүй гэх газаргүй гэж мэдэгдэв.
14.	Өдрийн	1999.05.07	Б. Билиг	МҮЭ-үүдийн	УИХ-аар хэлэлцэж буй хөдөлмөрийн хуульд: ажил олгогч нь

	сонин	Баасан 51/051/		ХолбоонСос цуглаан зохион байгуулав.	хүн амын амжиргааны өртгийн өөрчлөлт болон хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй уялдуулах, цалин хөлсийг тогтоосон хэмжээнд хугацаанд олгоогүй бол ажил олгогч нь олгох ёстой, цалинг саатуулсан хоног тутам 0.3 хувиар бодож алданги төлдөг байх гэх мэт санал оруулсан боловч дэмжигдээгүй байна.
15.	Өдрийн сонин	1999.05.08 Бямба 52/52/	Р. Оюун, П.Тэндэнжав	Багш нар цалингаа шаардаж байна.	Нийслэлийн 42 дугаар сургуулийнхан цалингаа цаг тухайд нь өгөхийг шаардаж ажил хаялаа. Энэ хөдөлгөөнийг СХ дүүргийн Ирээдүй цогцолборын 7-р сургуулийн ҮЭ-ийн хороо дэмжиж, ажил хаялтын түр хороо байгуулжээ.
16.	Зууны мэдээ	1999.05.11 Мягмар №89 /089/	Т.Жаргал	Тайван жагсаал хийлээ.	Хотын тээвэр зохицуулалтын газрын даргын тушаалаар гарсан нийтийн тээврийн хэрэгслээр зорчих оюутны хөнгөлөлтийн билетийн талаархи 33-р тоот тушаал, УИХ-аас баталсан хуулийн дагуу оюутнууд ЭМД төлөх болсныг эсэргүүцэж оюутнууд өчигдөр жагсаал хийлээ. Тэд ТИС-ийн төв байрны талбайгаас хотын захирагчийн ажлын алба, ТЗГ хүртэл тайван жагсаал хийв. Дээрх шийдвэрийг цуцлахгүй бол дараагийн алхам хийж хотын тээврийн хөдөлгөөнийг зогсооно гэж тэд мэдэгджээ.
17.	Өнөөдөр	1999.05.12 Лхагва 109/659/	Ц. Энхмаа	Оюутнууд эсэргүүцлийн цуглаан зохион байгуулна.	УБ хотын ТЗГДаргын гаргасан нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй зорчих оюутны тасалбарын талаархи тушаалыг ТИС, АУИС, УБИС, ХААИС-ийн оюутнууд эсэргүүцэн УБ хотын менежер Э. Гомбожав, ХТЗГ-ын дарга Н. Нямдаваа нарт мэдэгдэл гаргасан байна. Хэрэв хариу өгөхгүй бол ТИС-ийн өмнөх талбайд эсэргүүцлийн цуглаан зарлах аж.
18.	Зууны мэдээ	1999.05.25 Мягмар №100 /100/	Т.Өнөр	Багш нар ажил хаялаа.	Эрдэнэтийн 10 жилийн 1, 3, 4-р дунд сургуулийн багш нар өчигдөр ажил хаяжээ. Орхон аймгийн ҮЭ-ийн холбооны дарга М.Танаагаас тодруулахад: Эдгээр багш нар 3 сарын цалингаа дутуу авч, 4, 5-р сарын цалин нь ерөөсөө олгогдоогүй байгаа. Иймд багш нар цалингаа бүрэн гүйцэд авах шаардлага тавьж ажил хаяжээ.
19.	Өнөөдөр	1999.10.06 Лхагва 232/782/	Ц.Энхмаа	Багш нар сануулга өгч ажил хаялаа.	Нийслэлийн СХД-ийн ЕБ-ын 14-р сургуулийн багш нар, 8,9 дүгээр сарын цалин, сургуульд ажиллагсадын хүүхдийн 1998 оны төлбөрийг гүйцэд олгох, олгогдоогүй цалин, ээлжийн амралтын мөнгийг Хөдөлмөрийн хуулийн дагуу алданги бодож хохиролгүй болгох, сургууль цэцэрлэгүүдийн цахилгаан, дулаан, усны хязгаарлалтыг зогсоох арга хэмжээ

					авахыг шаардлаа.
20.	Өдрийн сонин	1999.10.06 Лхагва 179/179/	Х. Оюунсүрэн	Багш нар 8-р сарын цалингаа өгөхийг шаардав.	СХД-ийн багш нар 8,9-р сарын цалингаа аваагүй байгаа бөгөөд дүүргийнхээ захиргааны үүдэнд цуглаан зохион байгууллаа. Энэ цуглаанд 14-р сургуулийн 800-аад багш оролцлоо.
21.	Монголын мэдээ	1999.10.20 Лхагва 190/192/	Ж. Амар	Их мөрөн гэвэл догшин нэгэн цутгалан байлаа.	СТӨ-ний өмнө Монголын үндэсний чөлөөт зохиолчдын холбоо, 281-ийн холбоо, Монголын радиогийн Баянмонгол Студи, "Хүмүүсээ амьддаа бие биеэ хайрла" сэдэвт цуглаан зохион байгуулав. Авьяаслаг найрагч, ард түмний хайртай хүү О. Дашбалбар хүнд өвчний улмаас таалал төгссөнд гүнээ эмгэнэн үг хэлэн дурсцаалаа.
22.	Монголын мэдээ	1999.10.22 Лхагва 192/194/	Г.Бурмаа	Багш нар сануулах ажил хаялт хийв.	СХ дүүргийн 74-р дунд сургуулийн багш нар энэ сарын 20-ны өдөр сануулах ажил хаялт хийлээ. Тэд амралтын мөнгөний дутууг нөхөн олгох, багш нарын хүүхдүүдийн сургалтын төлбөрийг төлөх, 9,10 дугаар сарын цалинг яаралтай олгох шаардлага тавьжээ.
23.	Монголын мэдээ	1999.11.18 Пүрэв 211/213/	Ч. Билгүүн	Ард түмний эсэргүүцлийн хороо байгуулжээ.	Цахилгаан станц болон НИК, Говь зэрэг объектуудыг хувьчлахыг эсэргүүцсэн цуглаан Эрх чөлөөний талбайд боллоо.
24.	Монголын мэдээ	1999.11.24 Лхагва 215/217/	Д. Дэнсмаа	Дархан-Уул аймгийн багш нар ажил хаялаа.	Тус аймгийн 7 сургуулийн 450 багш ажилчид хугацаагүй ажил хаялаа. Тэд сүүлийн 2 сарын цалингаа аваагүй бөгөөд яаралтай олгох, НД-ын шимтгэл төлөгдөөгүйгээс учирч буй хохирлоо арилгуулах, төрийн үйлчилгээний ажилтны 1 хүүхдийн оюутны төлбөрийг сүүлийн 2 жил олгоогүй байгааг шийдэхийг шаардлаа.
25.	Монголын мэдээ	1999.11.26 Баасан 217/219/	Д.Дэнсмаа	Сэлэнгэ аймгийн багш нар ажил хаялаа.	Тус аймгийн ЕБС-ийн багш нар ажил хаялаа. Тэд сүүлийн 2 сарын цалин өгөх, 4 хоногийн амралтын дутууг олгох, нэмэгдэл хөлсийг журмын дагуу олгохыг шаардлаа.
26.	Өдрийн сонин	1999.12.15 Лхагва 239/239/	Б.Оюунтуяа	Хөтөлийн эмч, ажилчид хугацаагүй ажил хаялаа.	Сэлэнгэ аймгийн Хөтөлийн нэгдсэн эмнэлгийн ажилчид 7-р сараас хойш цалингаа аваагүй учир ийнхүү хугацаагүй ажил хаялаа.
27.	Өдрийн сонин	1999.12.16 Пүрэв 240/240/	Д. Оюун	Багш нар өлсгөлөнгөө зогсоов.	Баянхонгор аймгийн Баацагаан сумын 8 жилийн дунд сургуулийн 5 багш энэ сарын 10-аас зарласан өлсгөлөнгөө зогсоов. Тэд сүүлийн сарын цалингаа нөхөн авах, Их, Дээд сургуульд сурч буй хүүхдийнхээ төлбөрийг шилжүүлэх зэрэг шаардлага тавьж байсан бөгөөд шаардлагыг нь биелүүлсэн

					учир өлсгөлөнгөө зогсоожээ.
28.	Монголын мэдээ	1999.12.14 Мягмар 228/230/	Г. Тамир	Өлсгөлөн зарлалаа.	Баянхонгор аймгийн Баацагаан сумын төсвийн байгууллагын хэсэг ажилчид 7 сараас хойш цалингаа аваагүй учир өлсгөлөн зарлажээ.
2000 он					
1.	Зууны мэдээ	2000.02.22 Мягмар №42/309/	М.Чимэг	“Ард” Батсүх хуурай өлсгөлөн зарлажээ.	Я.Батсүхийг ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газар албадан саатуулсанаас хойш бараг 4 сар боллоо. Энэ хугацаан мөрдөн шалгах хугацааг 2 ч удаа сунгаж. Түүнд хуурамч бичиг баримт үйлдэж, гаалийн татвар төлөх болон шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн үндэслэлээр мөрдөн байцааж дуусаад, С.Зоригийн хэрэгт холбогдуулан шалгахдаа хугацааг нь сунгажээ. 02-р сарын 15-наас ТХ-н ЦХ төвд Я.Батсүх өлсгөлөн зарлаж буйгаа албан ёсоор мэдэгджээ. Ус ч уухгүй хуурай өлсгөлөн аж.
2.	Өнөөдөр сонин	2000.03.16 Пүрэв №062 /915/		Ш.Эрдэнэмөнх “Аюулгүй хүнсний төлөө” хамтран ажиллахыг уриалав	Энэ өдөр ОУ-ын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдөр байлаа. Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг “Аюулгүй хүнсний төлөө” уриан дор Эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгууллаа. Мөн энэ үеэр хэрэглэгчдийн найдвартай түнш-компаниудын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа ажиллаа. МХЭАХН-ийнхэн нийт хэрэглэгчдэд хандаж гар дээрээс худалдаа хийхгүй байх, энгэртээ мэргэжсэн худалдагч, тогоочийн үнэмлэхгүй бол мөн баталгаагүй жин хэмжүүртэй газраар бүү үйлчлүүл гэсэн уриалгыг уг арга хэмжээний үеэр гаргалаа.
3.	Зууны мэдээ	2000.04.03 Пүрэв №105/372/	Б.Болд	Үйлдвэрчид ноолуур экспортлохыг эсэргүүцэж жагслаа.	Өчигдөр өглөө 10-11 цагийн хооронд толгойгоо шар даавуугаар боож уриа, лоозон барьсан хүмүүс Хан-Уул дүүргээс жагсаж Энхтайвны гүүрээр гарч Үндэсний жүжгийн Академик театрын өмнөх талбайд цугларлаа. “Говь”, “Буян”, “Мон-Италкашмир”, “Амикал”, “Монфорте”, “Туулкашмир”, “Ти энд Ай”, “Ээрмэл” зэрэг ноолуурын үйлдвэрийн ажилчид юм. Энэ жагсаал, цуглааны гол зорилго нь түүхий эд, ноолуурыг экспортлохыг хориглох, МУ ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ эргэн үзэж дахин зөвшилцөх, ингэхдээ ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчид, тэний ҮЭ-ийн байгууллагын санал, шаардлагыг танилцуулах, гадаадын наймаачдын хөл гар бологчидтой тэмцэх, таслан зогсоох, татварын хөнгөлөлтийг адил үзүүлэхийг дурджээ.
4.	Өнөөдөр	2000.05.04		Эрх чөлөөнийхөө	Чөлөөт хэвлэлийг эрх баригчид, дарга нар үл таалдаг. Тэдэнд

	сонин	Пүрэв №104 /957/		өдөр сэтгүүлчид чуулав.	“Шар хэвлэл” гэдэг нэр томъёо өгч, нэр хүндийг нь гутаах гэсэн. Гэвч бүтээгүй. Одоо сэтгүүлчдийн хооронд яс хаяхад улс төрийн хүчнүүд их үүрэг гүйцэтгэж байна. Эвслийн ЗГ, төрийн мэдлийн телевиз, радиогоор сонин хэвлэлд гарсан алдаатай материалын араас мөшгөж нэр хүндийг нь унагах боллоо гэж МСХ-ны ерөнхийлөгч Р.Хадбаатар цуглааны үеэр ярих. Өчигдөр дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр байсан. Энэ өдөрт зориулж МСХ, Монголын чөлөөт хэвлэн нийтлэгчдийн холбоо, Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлчдийн холбооноос “Хэвлэлийн эрх чөлөө=Хүний эрх чөлөө=Ус агаар” цуглааныг Эрх чөлөөний талбайд зохион байгууллаа. Цуглаан ардчиллаар олдсон хэвлэлийн эрх чөлөөг цаашид хадгалж, хөгжүүлэх, чөлөөт хэвлэл хөгжих бололцоог бүрдүүлэх, дэмжих, дэлхийн орнуудын хэвлэлийн эрх чөлөөг дэмжигчидтэй дуу хоолойгоо нэгтгэх зорилго агуулж байв.
5.	Зууны мэдээ	2000.05.11 Пүрэв 111/378/		Багш нарын ажил хаялт 7-1 хүртэл хойшиллоо.	СХД-ийн сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид дүүргийнхээ ЗДТГ-ын санхүүгийн ажилтнуудтай уржигдар уулзаж цалин, хүүхдийн төлбөрийн асуудлаар ярилцжээ. Цалин, оюутны төлбөрийг хугацаанд нь олгоогүйгээс ийм байдалд хүрч ЗД-д мэдэгдэл ирүүлсэн. Ярилцаж тохироод 5, 6 сарын цалин, амралтын мөнгийг хугацаанд нь олгоно гэсэн хариу өгөөд байна. 5 сарын 15-аас 7 сарын 1-ны дотор амлалтаа биелүүлнэ гэсэн.
6.	Өнөөдөр	2000.05.13 Бямба 112/965/	3. Бадмаараг	Оюутнууд НЗД-д эсэргүүцлийн бичиг илгээв.	МУИС-ийн ЭЗДС-ийн багш, оюутнууд уржигдар эсэргүүцлийн цуглаан хийж, сургуулийнхаа өмнө жагсав. Тэд хичээлийн VI байрны дэргэд сууц барихаар банзан хашаа босгож эхэлсэн Жанцав захиралтай “дайн” зарласнаа мэдэгдэж буй нь энэ аж. Хотын төвд босох 3 давхар эл байшин багш, оюутнуудын амгалан тайван байдлыг алдагдуулж, тус сургуулийнхныг машины зогсоолгүй болгосон тул оюутнууд эсэргүүцлийн бичиг илгээхээр шийджээ.
7.	Зууны мэдээ	2000.06.23 Баасан №149 /416/	Дамбий	Микро автобусны шугамны будлианы эзэн Ц.Дамиран	Микро автобусыг цэгцлэх зорилгоор холбогдох байгууллагуудаас зарласан тендерийг “Микро автобусны эздийн холбоо” шударга бус гэж үзээд түр хороо байгуулан ДБХЯ-ны гадаа 10 хоног зогсолт хийгээд нийслэлийн төв талбайд шилжин байрлалаа. 40 аж ахуйн нэгжийн 100 жолооч эсэргүүцлийн арга хэмжээнд оролцжээ. Тэд энэхүү

					хуйвалдааныг таслан зогсоож, тендерийн булхайг илчилхийг хүсч, энэний гол буруутан нь ДБХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Ц.Дамиран гэжээ.
8.	Зууны мэдээ	2000.08.16 Лхагва №190/457/		Ахмадууд Э.Бат-Үүлийг дэмжиж цугларлаа.	Нийслэлийн болон Дорнод, Хэнтий, Төв, Орхон аймгаас ирсэн МҮАН-ын гишүүн, дэмжигч ахмадууд өчигдөр МҮАН-ын төв байранд цугларлаа. Тэд “Ганц худагт” саатуулагдаж байгаа Э.Бат-Үүлийг даруй суллахыг төр, засгийн удирдлагаас шаардаж буйгаа илэрхийлж мэдэгдэл гаргав.
9.	Зууны мэдээ	2000.09.30 Бямба 229/496/	Б.Аюуш	Зултай жагсаал болов.	Монголын ардчилалын удирдагч Дэд бүтцийн хөгжлийн сайд асан С.Зориг 1998.10.2-нд бусдад хэрцгийгээр алагдсан. Энэ хэрэг гарсанаас хойш 2 жилийн нүүрийг үзэж байна. Ирэх 10 сарын 2-нд С.Зоригийн дурсгалыг хүндэтгэж хөшөөнд нь цэцэг өргөн, дэмжигчид зултай, чимээгүй жагсаал хийх юм байна.
10.	Зууны мэдээ	2000.10.04 Лхагва №232 /499/	Д.Даваа	Багш нар ажил хаялаа.	Хөгжим бүжгийн коллеж (ХБК)-ийн багш оюутнууд 10 сарын 3-аас хичээл хаяжээ. БСШУЯ-ны шийдвэрээр түдгэлзүүлэн улмаар ажлын хэсэг гаргаж СУИС-н харъяалалд үлдээхээр заажээ. Гэтэл ХБК-ийн багш оюутнууд үүнийг нь эсэргүүцжээ.
11.	Өнөөдөр	2000.10.04 Лхагва 231/1083/	Р.Дэлгэр	Багш нар ажил хаялаа.	ХБК-г СУИС-н харьяаллаас гаргаж, шаталсан сургалттай, бакалаврын боловсрол олгодог коллеж болгон өргөтгөж, улмаар ирээдүйн косерваторын үндсийг тавих саналыг дэвшүүж, БСШУЯ-ны удирдагад удаа дараа ханджээ. Гэвч энэ асуудлыг судалж буй нэрээр удааширсан учраас тус сургуулийн багш нар өчигдөрөөс ажил хаяжээ.
12.	Монголын мэдээ	2000.12.02 Бямба 234/476	Т.Төр	Оюутнууд ариун хайрын тангараг өргөлөө.	“Бидний сонголт ариун хайр”, “Зогс! Наана чинь ДОХ”, “ДОХ-оос хамгаалах найдвартай арга бол ариун хайр” гэсэн бичиг бүхий уриа, зурагт хуудас барьж цагаан хоолойгоор “Ариун хайрыг” сурталчлах цуваа шинэлэг зүйл байлаа. Энэ жагсаалд 17 их, дээд сургуулийн 1600 орчим оюутнууд оролцов
13.	Монголын мэдээ	2000.12.09 Бямба 239/481	Т.Төмөрмаа	Багш нар ажил хаялаа.	Завхан аймгийн Их-Уул сумын найман жилийн дунд сургуулийн багш, ажилчид ажил хаяжээ. 7, 8, 9 10, 11-р сарын цалинг алдангийнх нь хамт шаарджээ.
2001 он					
1.	Өдрийн сонин	2001.01.06 Бямба 005/568/	Ш.Оюун	“Хархорин” захынхан ажил хаялаа.	Тус захын жимс, ногоо худалдаалдаг лангуу түрээслэгчид ажил хаялаа. Тэд маш хүйтэн байшинд эрүүл ахуйн нэг ч шаардлага хангахгүй нөхцөлд өндөр татвар төлж ажилдагаас жимс, ногоо хөлдөж хайрагдан гүйлгээгүй болдог гэсэн

					шалтгаанаар ажил хаяжээ. Мөн олон хүнд лангуу түрээслүүлж байгаа нь борлуулалтад нөлөөлж байна гэжээ.
2.	Монголын мэдээ	2001.01.11 Пүрэв 007/502	Н.Баатар	Хугацаагүй ажил хаялт зарлажээ.	“Хархорин” зах дээр наймаа хийдэг хүмүүс ажил хаяжээ. Сар тутам авдаг татварын хэмжээ нэмэгдсэнээс наймаачид ийм арга хэмжээ авсан аж. Татварын хэмжээг багасгасан шийдвэр гаргасан үед ажил хаялтаа зогсоохоо мэдэгджээ.
3.	Зууны мэдээ	2001.08.04 Бямба 182/756/	Д.Дэлгэр	Ц.Болд өлсгөлөн зарлажээ.	Хилийн цэргийн хурандаа Ц.Болд камертаа өлсгөлөн зарлаад 2 хонож байна. Тэрээр эхнэрээ эмнэлэгт эмчлүүлж, өөрсдийгөө батлан даалтад гаргуулан гадуур байцаагдах зэрэг шаардлага тавьж ийнхүү өлсгөлөн зарласан байна.
4.	Зууны мэдээ	2001.09.24 Даваа 225/799/	С.Галсаа	Жагсаал хийж, бараагаа сурталчлав.	Монголын Худалдаа, аж үйлдвэрийн танхим дотооддоо үйлдвэрлэл эрхлэдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Бизнес-фестиваль” зохион байгуулав Бизнес-фестивальд оролцогсад Төв цэнгэлдэх хүрээлэнгээс Эрх чөлөөний талбай хүртэл хотын гол төв гудамжуудаар бараа бүтээгдэхүүнээ сурталчлах жагсаал зохион байгуулсан байна.
2002 он					
1.	Зууны мэдээ	2002.01.22 Пүрэв №45 /619/	У.Гэрэл	Б.Баярбатын эхнэр өлсгөлөн зарлахаар шийджээ.	Гэр бүлхийнхээ 5 хүний амь насыг зэрлэгээр хөнөөсөн Б.Баярбатын эхнэр Энхжаргалыг энэ хэрэгт холбогдуулан Ганц худагт саатуулаад 20 гаруй хонож байна. Харин тэрээр удахгүй өлсгөлөн зарлах тухайгаа хорихын удирдлагуудад дамжуулж өгөхийг хүссэн гэнэ.
2.	Монголын мэдээ	2002.01.24 №016 /766	Н Энхбаатар У.Болд	Хилсээр хоригдлоо хэмээн өлсгөлөн зарлажээ.	Хоёр он дамжин яригдаж байгаа Центропийн хэрэг хумигдах биш бүр аалзны тор шиг хүрээгээ тэлж нэр нөлөөтэй бизнесменүүдийг чихдсээр байна. ЦЕГ-ын харьяа Ганц худагийн хорих төвд “Цагаан шонхор холдинг”-ийн захирал Ч.Энхтайван, Х.Энхтайван, Д.Нямдорж, Б.Дашдондог, У.Болд нар хоригдож байгаа. У.Болд энэ сарын 11-ээс 15-ны 15 цаг хүртэл эсэргүүцэл илэрхийлэн өлсгөлөн зарлажээ. Прокурор болон мөрдөн байцаагчтай уулзуулахыг шаардаад хилс хэргээр хоригдож байна хэмээсэн аж. Мөн түүнчлэн хөл муутай учир эмчлүүлмээр байна гэжээ.
3.	Монголын мэдээ	2002.04.05 №068 /818	Н. Бадам	Эрх баригчдыг эсэргүүцсэн цуглаан өлгийд болжээ.	өнгөрсөн долоо хоногийн лхагва гаригт Баян-өлгий аймгийн төв өлгий хотод Төр засаг болон аймгийн удирдлагуудын буруу зйл ажиллагааг эсэргүүцсэн ажилгүйчүүд, нийгмийн эмзэг бүлгийнхэн голдуу 300 гаруй хүн цуглаан зохион байгуулж эрх баригчдаас

					сонгуулийн үеэр амлаж байсан амлалтуудаа хэрэгжүүлэхийг шаардаж, мэдэгдэл гаргажээ. Ер нь сүүлийн үед Баян-өлгий аймагт ажилгүйдэл, ядуурал нүүрлэж эрх баригчдын явуулж буй хатуу бодлогод бухимдах явдал газар авчээ. Нэлээд хэдэн сумдын засаг дарга нар ажлаасаа огцорчээ.
4.	Өдрийн сонин	2002.04.13 Бямба 091, 092/964, 965	Г.Төр	Шүгэлтэй жагсаал.	АН-аас Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын үүдэнд шүгэлтэй жагсаал зохион байгууллаа. РТХЭГ-ын дарга Д.Ганболдод 4 заалт бүхий шаардлага гардуулах болсноо уг цуглаан дээр мэдэгдэв. Тавьсан шаардлагыг хүлээж аваагүй тохиолдолд Д.Ганболдыг огцруулах хүртэл эрчимжүүлнэ гэжээ. Жагсагсад "Ард түмнийг МАХН 11,5 тэр бум долларын өрөнд ...", "Радио ТВ-ийн сэтгүүлчдийн амны хаалтыг ав", "Хэвлэл 4 дэх засаглал", "Үндэсний радио ТВ-ийг үндэсний болгоё!" зэрэг лоозон барьж, шүглээр "зэвсэглэсэн" байлаа.
5.	Өдрийн сонин	2002.04.16 Мягмар 095/968/	Г.Эрдэнэ	Ардчилсан хүчин ард түмнийг дахин сэрээлээ.	Ардчилсан хүчнээс Эрх чөлөөний талбайд, цуглаан зохион байгууллаа. Энэ цуглаанд АН байгуулагдсанаас хойш эрх баригчид засгийн эрх авснаас хойш сөрөг хүчний зүгээс хийж байгаа анхны цуглаан. Сонгуулийн амлалтууд огт биелэхгүй байна. Сонгуулийн үед түмэн зүйл амласан. Тэр бүхнийг байг гэхэд хүмүүсийн цалин тэтгэвэрийг 2 дахин нэмэх, татварын дарамтыг 30% бууруулах зэрэг амлалтууд юу болж байна.
6.	Монголын мэдээ	2002.04.16 №075 825	Э. Соёл-Эрдэнэ	Ялалтад цугларагсад суудалгүй болоод гомдсондоо биш, ажилгүй болоод агсарсандаа биш	АН, МоАХ, М ЭНХ-ноос зохион байгуулагдсан "төрөө хямралаас гаргая, тэмнээ ядуурлаас аварцгаая" сэдэвт олон нийтийн цуглаан очигдөр эрх чөлөөний талбайд болж 3 цаг орчим үргэлжилжээ. Цуглаанд УИХ-ын дарга асан Р. Гончигдорж болон намын гишүүд, олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөлөгчид байлцав.
7.	Өдрийн сонин	2002.04.18 Пүрэв 097/970/		Ши.Батбаярын хохирогчид өлсгөлөн зарлалаа.	НХХ-ийн сайд Ши.Батбаярын хохирогчид ерөнхий сайд Н.Энхбаярт өргөх бичиг илгээн, албан ёсоор өлсгөлөн зарлалаа. Өлсгөлөн зарлаж буй 2 эмэгтэй, 2 эрэгтэй хохирогч Нийгмийн хамгааллын яамны өмнө майхан барин байрлаад байгаа бөгөөд цаашид өлсгөлөн зарлагчдын тоо нэмэгдэж магадгүй бололтой.
8.		2002.04.18 Пүрэв №96 /982/		Сон Ян Жугийн хохирогчид зөвшөөрөл-	Солонгосын иргэн Сон Ян Жуд залилуулсан иргэд өчигдөрөөс НХХ Яамны байрны өмнө өлсгөлөн зарлалаа. ТЗХ-ийн газрын дарга Ганболдоос тодруулахад: Бид өмнө нь тэдний

				гүйгээр өлсгөлөн зарлажээ.	төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Өлсгөлөн зарлах нь тийм оновчтой арга биш гэдгийг хэлсэн. Тэд дүүргийн ЗД, цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл аваагүй өлсгөлөн зарласан.
9.	Зууны мэдээ	2002.05.06 Даваа №110 /996/	Ж.Төмөр	Тужийн нарсыг зорьсон анхны цуваа.	Зууны мэдээ сонин устаж буй Тужийн нарсыг нөхөн сэргээх хөдөлгөөнд олон нийтийг уриалжээ. Тужийн нарсанд мод тарих анхны цуваа Драмын театрын өмнөх талбайгаас энэ сарын 3-нд хөдөлжээ. Цуваа хөдөлхийн өмнө тус талбайд болсон цуваанд БОСайд Ч.Барсболд, МРТХЭГ-ын дарга Б.Ганболд, Зууны мэдээ сонины ерөнхий эрхлэгч Ц.Цэцэгчулуун нар оролцож үг хэллээ. Мөн ХХААСайд Насанжаргал, ЗГ-ын гишүүн Гадаад хэрийн сайд Л.Эрдэнэчулуун оролцов.
10.	Монголын мэдээ	2002.05.30 №857	Э. Соёмбо	᠗᠙рхангайд 300 хүн оролцсон цуглаан болжээ.	Тус аймгийн АН-ын салбар з᠔вл᠔л᠔с энэ сарын 27 нд олон нийтийн цуглааныг аймгийн т᠔в талбайд зохион байгуулжээ. 300-аад хүн оролцсон уг цуглаанд олныг хамарч байгаа 2 дахь арга хэмжээ юм. Цуглаанд оролцогсод аймгийн засаг дарга О. Батм᠔нх᠔д хандаж 6 шаардлага тавьж хариуг нь 7 сарын 1-ны дотор ᠔᠒хийг шаарджээ.
11.	᠗дрийн сонин	2002.06.29 №159 1032	Л. Батх᠔᠔	Сонины чнэ нэмэгдэж магадгүй	Ч᠔л᠔т хэвлэл сан буюу сонины хэвлэх чйлдвэрийн чйлдэнд сонины хэвлэлтийн чнэ нэмэгдэх гэж байгааг эсэрг᠔члэн ч᠔л᠔т сонины т᠔л᠔л᠔гчдийн цуглаан болов. Цуглаанд оролцсон “Сэр᠔члэг”, “Х᠔м᠔чс”, “Дээдсийн х᠔рээлэн” зэрэг ч᠔л᠔т сониныхны ярьж байгаагаар “Ч᠔л᠔т хэвлэл сан” гийн уайрдах з᠔вл᠔лийн 1999 оны 10-30 ны ᠗дрийн тогтоолоор сонин хэвлэлтийн чнийг 15%-р нэмэх шийдвэр гаргасан байна.
12.	᠗дрийн сонин	2002.10.24 №259 1132	Б.Цэнддоо	Дэмжлэг	11 сард Э. Бат- чл ГШХТХ᠔д᠔л᠔н᠔с тариаланчдыг трактортой нь оролцуулан жагсаал хийх гэж байгаа билээ. Эрх баригчид ччнийг таслан зогсоох ччднээс “Жагсаал цуглааныг дэмжих” тухай хуулийн т᠔с᠔л гардан батлуулах гэж байна. Ардчилалын эсрэг яваагаа дэлхий дахинд илтгэхчйлн тулд уг хууль дандаа з᠔вш᠔рс᠔н заалттай байх гэнэ.
13.	᠗дрийн сонин	2002.10.28 №262 1135	П.Баярт	᠗лгий хотод эсэрг᠔члийн цуглаан болж, эрх баригчид х᠔ч хэрэглэв.	Баян -᠗лгий аймгийн т᠔в ᠗лгий хотын иргэд ᠔н᠔рс᠔н баасан гаригт т᠔в талбай дээрээ эрх баригчдын алдаатай шийдвэрийг эсэрг᠔члэж цуглаан зохион байгуулжээ. Тус т᠔вийн хуучин захыг н᠔члгэн хотоос зайдуу н᠔члгэхийг чл х᠔ссэн наймаачдад х᠔ч хэрэглэсэнд иргэд ихэд бухимджээ. Захыг н᠔члгэсэн нь эсэрг᠔члийн гол шалтгаан байгаагүй гэнэ. Шинэ зах барихдаа т᠔св᠔с м᠔н᠔ гаргаж нууцаар тендер зарлаж ччрийн х᠔м᠔чсдээ ᠔гс᠔н байна. чнээс гадна шинэ захын байрлал шар шаварын орд газар агаад хятадууд уг газарт арьс шир боловсруулан химийн хорт бодисоор

					ихээхэн бохирдуулсан нь энгийн иргэдийг жагсахад хэргэжээ. Уг жагсаалд аймгийн АН-ынхан оролцжээ.
14.	адрийн сонин	2002.11.01 №266 (1139)	Б. Одмаа, Г. Эрдэнэчимэг Г. Дашцэрэн Х. Баттөгс	ХААИС-ын оюутнууаын жагсаалыг цагдаа нар тараав.	ХААИС-ын 500 гаруй оюутнууд жагсаал хийж шаардлага тавьлаа. Тэд 17 цагт сургуулиасаа Энхтайвны гэгээрээр алхан УБ хотын захирагчийн ажлын албаны гэгээнд эсэргээцлийн жагсаалаа хийжээ. Тэд ингэх болсон шалтгаанаа оюутны хөгжлөлтийн билет хэрэлцэхгүй болсон гэцгээв. ХААИС-ын 7000 оюутны дунд ердөө 130 билет олгожээ. Билет олголтыг цаашдаа цөөрүүлнэ гэсэн учир ийнхүү эсэргээцлээ илэрхийлэх болсон байна.
15.	Зууны мэдээ	2002.11.06 Лхагва №268 /1154/		Цуглааныг жагсаал болгохыг оролдов.	ЦЕГ-аас Эрх чөлөөний талбайд болох цуглааныг журамтай, хууль зүйн дагуу явуулах, жагсаал цуглаан зохион явуулах хуулийг хэрэгжүүлэх, иргэдийн эрх ашгийг хүндэтгэн хамгаалах талаар цуглааныг зохион байгуулах тал мэдэгдэл өгчээ. Гэтэл энэ цуглаан зохион байгуулалт муутай, хууль зөрчсөн үйлдэл гаргалаа. Цуглаан зохион байгуулагчид цуглааныг жагсаал болгон өөрчлөх гэж оролдлоо. Хориглосон газраар, авто машин трактор явуулахыг дэмжиж, хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж, зохион байгуулахад саад учруулав.
16.	Монголын мэдээ	2002.11.06 Лхагва 220/969	Б.Санаа	Трактораар Төрийн ордныг гороолж, Ерөнхий сайдад 5 зүйл бүхий шаардлагыг гардууллаа.	Эрх чөлөөний талбайд МоАХ-ноос зохион байгуулсан “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөний цуглаан болов. Ерөнхий сайдад өгсөн өргөх бичигт “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх” тухай хуулийг шударга ёсонд нийцүүлэн өөрчилж, 5 болзлыг хангах тухай заасан байлаа.
17.	Зууны мэдээ	2002.11.13	Ж.Заяа	Э.Бат-Үүл улс төрийн балмалд үйлдэлдээ тракторчдыг барьцаалжээ.	Э.Бат-Үүл эхлээд тракторчдын жолооны үнэмлэхийг хурааж авав. Жолооны үнэмлэх, шатахууны зардалгүй болсон тракторчдад нэг л гарц үлджээ. Тэр нь Э.Бат-Үүлийн амыг хэрж трактор бүү хэл, Ерөнхийлөгчийн машин хөндлөн гулд гарч чаддаггүй жанжины талбайд трактораа байрлуулах явдал байв. Тракторчид ч үүнээс өөр сонголтгүй болсноо өгүүлж байсан аж. Эрх чөлөөний талбайд эгнүүлэн жагсаасан 35 трактороос дөрөв нь өчигдөр буцжээ. Зорилгогүй ирснээ мэдсэн дээрх 4 тракторчин нутаг буцах шатхууны зардлаа Э.Бат-Үүлээс өөр гишүүнчлэлгүй Газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөнөөс биш, хотод байдаг ах дүү нараасаа авчээ.

18.	Өдрийн сонин	2002.11.14 278/1151/	Лу.Болд	Эрх баригчид хүч хэрэглэв.	Эрх чөлөөний талбайд байрлаад 7 хоносон тракторчид энэ сарын 12-нд Сүхбаатарын талбайд шилжиж байрласан билээ. Цагдаа нар Сүхбаатарын талбайг 3 дахин бүслэв. Сэтгүүлч Г.Уянга бичлэг хийснийхээ төлөө 3 цагдаад өргөгдөн автобус руу шидэгдэв. "Газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөн" –ийхөн болон АН-ын 43 хүн, 6 сэтгүүлчдийг "Паз" автобусанд хийн авч явав.
19.	Зууны мэдээ	2002.11.22 Баасан 282/1168/		Ерөнхийлөгч жагсаал, цуглааны тухай ...	Сүүлийн үед газар хувьчлалын асуудлыг тойрсон цуглаан, жагсаал хэд хэдэн удаа болсон. Ерөнхийлөгч үүнд байр сууриа ийн илэрхийлэв: Жагсаал, цуглаан зохион байгуулах, талаархи аль алинд нь Ерөнхийлөгч зөвшөөрөл өгч оролцдоггүй. Хуулиар олгосон тийм үүрэггүй. Жагсаал, цуглааныг холбогдох, хууль, журмын хүрээнд соёлтой хийх ёстой.
20.	Монголын мэдээ	2002.11.22 232/981	С.Туул	Баривчлагдсан сэтгүүлчид хуулийн байгууллагад хандахаар шийджээ.	Тус хөдөлгөөний үеэр цагдаагийнхан 4 сэтгүүлч, 2 операторыг баривчлан, зөвшөөрөлгүйгээр биед нь нэгжлэг хийн техник хэрэгслийг нь хурааж, хорьсон хууль эрх зүйн учир шалтгааныг өнөөдрийг хүртэл хэн нь ч тодорхой тайлбарлаагүй байгаа гээд энэ талаар сэтгүүлчид зохих хариултыг авахыг хүсч буйгаа илэрхийлсэн юм.
2003 он					
1.	Өнөөдөр сонин	2003.02.07		Хуулиас дээгүүр эрх гэж байдаггүй.	Хамгийн тодорхой жишээ бол трактортой жагсаал. Эрх чөлөөний талбайд үгээ хэлж болно, тэнд жагсаал хийж болно, харин Сүхбаатарын талбайд болохгүй, хуулийн заалт тийм байна гээд зүтгээд байсныг юу гэж ойлгох вэ? Хуулиас дээгүүр эрх эдлэх гэсэн хэрэг гэхээс өөрөөр тайлбарлах аргагүй.
2.	Өдрийн сонин	2003.02.22 №043 1232	Б. Эрдэнэбат	ОХУ-ын ЭСЯ-ны Өмн° лоозонтой жагсаал боллоо.	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 хороонд хуучин ЗХУ-ын мэргэжилтнүүд амьдарч байсан 5 давхар барилгын оршин суугчид Өмчлөгч нь биш эзэмшигч нь юм байна. Монгоёд орон сууц Өмчлөгчс Өмн° энэ байрыг оросын тал монголд шилжүүлнэ, эзэмшигчид нь Өмчилж авна гэсэн ойлголттой явсан хэмээсний найдвар талаар болж, Өмчлөгч хүртэл оросын тал орон сууцыг монголд шилжүүлсэнгүй. Иймд ОХУ-аас Монголд суугаа онц бөгөөд бэрэн эрхт элчин сайд О.М. Дерковский 1 пабүл 20-нд Орон сууцуудыг монголд шилжүүл, шилжүүлээгүй тохиолдолд газрыг чөлөөл гэсэн шаардлага тавьжээ. Гэтэл дурдсан хугацаанд хариу өгөгүй юм. Иймээс 3-р хорооллын оршин суугчид ОХУ-ын элчин сайдын яамны Өмн°

					эсэргүүцэл илэрхийлэн жагсаал хийжээ.
3.	Адрийн сонин	2003.04.08 №086 1275	Б. Эрдэнэбат	Төрийн ордноос 50 м зайд тариаланчид суулт хийжээ.	Газрыг шударгаар хувьчлахын төлөө хөдөлгөөн эрх чөлөөний талбайд очигдөр 12.30 минутанд цуглаан зохион байгуулсан билээ. Цуглаанд оролцогсод Ерөнхий сайд Н.Энхбаярт хандан хэсэлт гаргасан. Уг хэсэлтэд газрыг шударгаар хувьчилья сэдэвт цуглаан жагсаалын үйл ажиллагаанд оролцож буй иргэд уулзах хэсэлт тавьжээ. Хэсэлтэйн хариуг ерөнхий сайд ЗГ-ын ХЭГ-ын тэргүүн дэд дарга Л. Хангайгаар дамжуулан мэдэгджээ. Ерөнхий сайд нэгэр тулж уулзах шаардлагагүй гээд ЗГ-ын гишүүн ХХАА-ын сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулж тариаланчидтай уулзуулах ажлыг хэрэг эрхлэх газарт даалгажээ.
4.	Өдрийн сонин	2003.04.10 088/1277/	Г.Дашрэнцэн	Мөргөлдөөнд 5 хүн бэртжээ.	Монгол Улсын төрийн өндөрлөгүүдтэй уулзаж өөрсдийнхөө үгээ хэлье гэж хөдөө орон нутгаас зорьж ирсэн тариаланчдын төлөөлөгчдийн тэмцэл нийслэл хотод 3 дахь өдрөө үргэлжилж байна. Өчигдөр цагдаа, тэмцэгчдийн хооронд мөргөлдөөн гарлаа. Тэмцэгчид чанга яригчаа талбайд байрлуулах гэтэл цагдаа нар үл зөвшөөрсөн байна.
5.	Өдрийн сонин	2003.04.11 №089 1278		Суулт үргэлжилж байна.	Баян-Өлгий аймгийн драмын театрыг менежментийн хувьчлалаар хувьчлах шийдвэр гаргажээ. Гэтэл тус театрыг МАХН-ын удирдах албан тушаалтанд өгөхөөр аймгийн удирдлагууд шийджээ. Үүнийг нь театрын уран бүтээлчид, ажилчид эрс эсэргүүцэн аймгийн удирдлагуудад удаа дараа шаардлага мэдэгдэл явуулсан гэвч тэд хүлээн аваагүй. Тэдний тэмцэл цаашид үргэлжилж улс төрийн суулт хийгээд 7 хонолоо. Суултад урлагын гавьяат зүтгэлтэн Р. Самжид тэргүүтэй 9 хүн оролцож 1500 гаруй хүн гарын үсэг зурсан байна.
6.	Зууны мэдээ	2003.04.11 85/1283/	Ц.Цолмон	Жагсагчид хуулиа баримтлах ёстой.	Сүхбаатарын талбайд жагсаал цуглаан хийж байгаа хүмүүсийг албадан тараах гэж оролдсон нь хүний эрх зөрчсөн явдал уу. Энэ тал дээр ямар байр суурьтай байна вэ? –Энд хүний эрхийн тухай ярихдаа 1994 онд баталсан жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг баримтлах ёстой.
7.	Өдрийн сонин	2003.04.11 №089 /1278/		Баян-Өлгийгөөс мэдээллээ.	Баян-Өлгий аймгийн Хөгжимт <<Суулт үргэлжилж байна>> драмын театрыг менежментийн хувьчлалаар хувьчлах шийдвэр гарчээ. Гэтэл тус театрыг МАХН-ын удирдах албан тушаалтанд өгөхөөр аймгийн удирдлагууд шийджээ. Үүнийг нь театрын уран бүтээлчид, ажилчид эрс эсэргүүцэн аймгийн удирдлагуудад удаа дараа шаардлага мэдэгдэл явуулсан аж.

					Гэвч тэд хүлээн авахгүй байна. Тэдний тэмцэл цаашид үргэлжилж улс төрийн суулт хийгээд 7 хонолоо. Суултад урлагийн гавъяат зүтгэлтэн Р.Санжид тэргүүтэй 9 хүн оролцож 1500 хүн гарын үсэг зураад байна.
8.	Өнөөдөр	2003.07.26 Бямба 174/1912/	Р. Эмүжин	Хүчирхийллийг зогсоо.	Үзэл бодлоо ийн илэрхийлж буй хүмүүс АН-ын байрны гаднах талбайд АН-ын дэд дарга Л.Гүндалайг хил зөрчсөн гэдэг шатгаанаар баривчлан хорьсонтой холбогдуулан тус намаас зохион байгуулж буй цуглаан эхэлжээ.
9.	Монголын мэдээ	2003.09.10 180/1186/	Г.Тамир	Та нар ичихгүй бол бид ичихгүй.	Бид нийгэмлэгийнхээ эрх ашгийн төлөө Ерөнхий сайд, нийслэлийн Засаг дарга нарт хандсан. Гэтэл тэд хариу өгөөгүй. Тиймээс бид “Та нар ичихгүй бол бид ичихгүй, бидэнд алдах зүйл үгүй” гэж үзэж хүний нүднээс далд байгаа өлсгөлөнг ил гарган тэмцэхээ мэдэгдэж байгаа юм. Бидний мэдэгдэлд хариу өгч, доривтой арга хэмжээ авахгүй бол Сүхбаатарын талбай дээр өлсгөлөн зарлана. (хараагүйчүүдийн нийгэмлэг)
10.	Өдрийн сонин	2003.09.13 №218 /1407/	П.Энхбаяр	Нийслэлийн ЗД М.Энхболдод шаардах бичиг явууллаа.	ГШХТ хөдөлгөөн өчигдөр Эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгууллаа. Нийслэлд газар хувьчлал туйлын шударга бус байдлаар явагдаж байгааг эсэргүүцэн иргэд тус хөдөлгөөнийхөнд хандан өөрсдийн эрх ашгаа хамгаалан тэмцэх үйл ажиллагааг зохион байгуулахыг хүссэнийг нь дэмжин энэхүү жагсаал, цуглааныг зохион байгуулж байгаа юм байна. Цуглаанд нийслэлийн бүх дүүргээс 300-гаад хүн оролцлоо. ГШХТ хөдөлгөөнөөс нийслэлд газар хувьчлал шударга бус явагдаж байгаа талаар НЗД бөгөөд УБ хотын захирагч М.Энхболдод албан бичгээр удаа дараа явуулж энэ бусармаг үйл ажиллагааг таслан тогтоохыг шаардаж байсан аж. Гэвч өдий хүртэл ямар ч арга хэмжээ аваагүйгээс гадна жирийн иргэдийн эрх ашгийг хөсөрдүүлсэн нийслэл, дүүргийн ЗД нарын хууль бус захирамж гарсаар байгаа юм байна. Иймээс НЗД М.Энхболдтой ГШХТ хөдөлгөөний тэргүүн Бат-Үүл тэргүүтэй төлөөлөгчид биеэр уулзан тэрхүү хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгох талаар өмнө тавьсан шаардлагын хариуг авахаар боллоо.
11.	Өдрийн сонин	2003.09.13 №218 1407	П. Ихбаяр .	Нийслэлийн засаг дарга М. Энхболдод	ГШХТ хөдөлгөөн өчигдөр эрх чөлөөний талбайд цуглаан зохион байгуулж нийслэлийн газар хувьчлал туйлын шударга бус байдлаар явагдаж байгааг эсэргүүцэн иргэд тус хөдөлгөөнийхөнд хандан өөрсдийн эрх ашгаа хамгаалан тэмцэх үйл ажиллагааг зохион

				шаардах бичиг явууллаа.	байгуулах хэсэлтийг нь дэмжин энэхүү жагсаал цуглааныг зохион байгуулж байна. Цуглаанд нийслэлийн бүх дүүргээс 300 гаруй иргэд оролцлоо.
12.	Монголын мэдээ	2003.10.17 17/206	Г.Жамъян	Хараагүй хүмүүс өлсгөлөн зарлалаа.	Монголын 100 гаруй мянган тахир дутуу иргэд тэдний гэр бүлийнхний төлөөлөгчид тахир дутуу, хараагүй хүмүүсээ хүний хүрээнээс гаргаж байгаа төр, засагт бухимдлаа илэрхийлж байгаа нь тэр. Тэд тэмцлийнхээ дараагийн шатанд шилжин хэлмэгсдийн хөшөөний дэргэд майхнаа бариад өлсгөлөн зарлажээ.
13.	Зууны мэдээ	2003.10.17 250		Бид хүний жишгээр амьдарсаар байна.	“Бид хүн бол хүний нийгэмд хүний жишгээр амьдаръя”, “Ганди та хараагүйчүүдээр шоудахаа зогсоо” гэх маягийн лоозонг Эрх чөлөөний хөшөөний дэргэд өлгөж, өмнө нь ганц майхан барьж, гадна нь 5, 6 хүн хэвтсэн харагдана. Энэ бол хараагүйчүүдийн тэмцэл.
14.	Монголын мэдээ	2003.10.23 210	Д.Туяацэцэг Л.Цэрмаа	Өлсгөлөн зарласан эх заргаа авч, зэрэмдэг хүү нь ажилдаа эргэж орлоо.	Даргадаа зодуулсан эрэмдэг болсон гаальч залуугийн ээж Л.Цэрмаа Эрх чөлөөний талбайд энэ сарын 17-ны өдрөөс өлсгөлөн зарласан билээ. Хүүг нь ажлаас нь хууль бусаар халаад, зодож зэрэмдэг болгосон хүн түүнтэй хуйвалдагсдад шийтгэл ноогдуулах, хүүг нь хохиролгүй болгохыг шаардсан Л.Цэрмаа багагүй үр дүнд хүрчээ.
15.	Монголын мэдээ	2003.10.24 211	Д.Туяацэцэг	“Автобус-3”-хан ажил хаясан уу?	“Автобус-3” компанийн автобусууд уржигдар бүтэн өдөр үйлчилгээнд гарсангүй. Үүнээс болж зорчигчид нэлээд бухимдав. Жолооч, кондукторууд хувьчилж авсан эздийн хоорондын асуудлаас болоод ажил хаясан гэж ярьж байна.
16.	Монголын мэдээ	2003.11.09 223	Т.Болор	Тракторчид эрх чөлөөний талбайгаас СБ-ын талбай уруу шилжихээ мэдэгдлээ.	Эрх чөлөөний талбайд болсон цуглаанд оролцсон тракторчид УИХ, ЗГ-т тавьсан шаардлагынхаа хариуг хүлээн аваад туйлын ихээр харамсан гомдоход хүрсний улмаас сонордуулга гаргах болсон гэж тайлбарласан юм. Уг шаардлагын хариунд тариалангийн талбайг хэн ч очоод эзэмших, өмчлөх боломжтой гэж бичсэн байгаа ч үнэн хэрэгтээ худал ярьж буй аж. Ирэх мягмар гарагт Эрх чөлөөний талбайд одоо байгаа 35 трактороо Сүхбаатарын талбай уруу оруулах аж.
17.	Өдрийн сонин	2003.12.11 295/1984/	С.Сод	Ши сайд “баталгаа” гаргаагүй бол хохирохгүй л	Мөнгөө “хулхидуулсан” 120 гаруй иргэн хохиролоо гаргуулахаар өлсгөлөн зарласан. Тэдэнтэй хүний эрхийн өдрөөр хохирсон хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зорилготой гэх “Шинэ давалгаа”, “Хүний эрх шударга ёсны төлөө”

				байсан.	хөдөлгөөнийхөн нэгджээ. Тэд Эрх чөлөөний талбайд өлсгөлөнгөө зарлах гээд гэрээ барих гэж байхад нь цагдаа нар ирж өлсгөлөн зарлахыг хориглосон байна.
18.	Монголын мэдээ	2003.12.11 244/1250/	Б.Майцэцэг	Өлсгөлөн зарлах гэсэн хүмүүсийг цагдаа нар зодож тараажээ.	Үндэслэлгүй ажлаасаа халагдсан, эд хөрөнгө, орон байраа залилуулсан, хүн амины хэргийн хохирогч болсон, “Зөөлөн-Эх” холбоонд мөнгөө алдсан 200-гаад хүн өлсгөлөн зарлахаар шийдвэрлэсэн тухай бид мэдээлсэн. Гэтэл өлсгөлөн зарлах гэсэн хүмүүс Эрх чөлөөний талбай дээр цагдаа нарт зодуулж, барих гэж байсан гэр бараагаа буцаалгажээ.
19.	Монголын мэдээ	10.16 Пүрэв	Б.Гандолгор	Ялалтын талбайд хараагүйчүүд цуглаан, жагсаал хийлээ.	Дэлхийн цагаан таягтны өдөр тохиолоо. Нийслэлийн хараагүйчүүдийг төлөөлөн иргэд Ялалтын талбайд цуглав. Тэд хараагүйчүүдийн нийгэм хангамжийн асуудал хүндрэлтэй ажлын байр байдаггүй, мэдээллийн эрин зуунд амьдарч буй ч тэдэнд зориулсан ном, сурах бичиг байхгүйгээс мэдээлэл авч чадахгүй тухай гомдоллож байв.
20.				Сүхбаатарын талбай дахь суулт таржээ.	Орон нутгаас ирсэн тариаланчид Д.Сүхбаатарын талбайд хийж байсан суултаа завсарлалаа. “Газрыг шударгаар хувьчлахын төлөө” хөдөлгөөнөөс сэтгүүлчдэд мэдээлэл хийв. Хөдөлгөөний тэргүүн Э.Бат-Үүл хэлэхдээ “Азийн ханиад” хэмээх амьсгалын замын цочмог халтай хамшинж өвчин манайд ирсний дараа ЗГ-ын хуралдаанаар нийслэлд иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдал зарласан.

“МОНГОЛ УЛС ДАХЬ ТАЙВАН ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ”
СЭДЭВТ УУЛЗАЛТ ЯРИЛЦЛАГЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Уулзалт ярилцлага 2004 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Засгийн газрын 11 дүгээр байр, Үндсэн Хуулийн Цэцийн хуралдааны танхимд 09 цаг 50 минутанд эхлэв. Уулзалт ярилцлагад Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, ХЗДХЯ, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар, ЦЕГ-ын нийгмийн хэв журам хамгаалах газар, МАХН, Ардчилсан нам, МҮЭ, МХАҮТ болон МЗХ зэрэг байгууллагын төлөөлөгчид нийт 21 хүн оролцлоо. Уулзалт ярилцлагыг ХЭҮК-ын дарга С. Цэрэндорж удирдан явуулав. Арга хэмжээний үеэр МҮТВ, UBS-ТВ, ТВ-5, ТВ-9, 25 дугаар суваг телевиз, МОНЦАМЭ агенлаг, Монголын мэдээ зэрэг сонин, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээлэл, ярилцлага өгөв.

Уулзалт ярилцлагыг ХЭҮК-ын дарга С. Цэрэндорж нээж үг хэлэв.

Нээлтийн ажиллагааны дараа ХЭҮК-ын үндэсний зөвлөх, ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Д. Оросоо “Монгол Улс дахь тайван жагсаал цуглаан хийх эрх, түүний эрх зүйн орчин” судалгааны урьдчилсан тайланг танилцууллаа.

С. Цэрэндорж: Судалгааны урьдчилсан тайлан, материалыг хувилж та бүхэнд тараасан байгаа. 20 минут судалгааны илтгэлтэй холбоотой асуулт хариултын цаг байна.

Д. Ламжав: Жагсаал, цуглаантай холбоотой олон улсын конвенц байдаг болов уу? Энэ талаарх гэрээ конвенцыг судлаж үзэв үү? Элчин сайдын яамдын нутаг дэвсгэрт тайван жагсаал цуглаан хийхийг хориглоно гэсэн заалт байна уу?

Д. Оросоо: Элчин сайдын яамны нутаг дэвсгэрт жагсаал цуглаан хийхийг хориглосон зохицуулалт хуульд байхгүй. Хүний эрхтэй холбоотой 50 орчим олон улсын гэрээ, конвенц бий. Үүний 30 орчимд нь Монгол улс нэгдэн орсон гэсэн баримт байдаг.

Д. Ламжав: Тэгэхлээр цуглаан гэдэг нэр томъёо юунд хамрагдах вэ? АНУ-ын элчин сайдын яамны орчимд байгаа хүмүүс чухам ямар аргаар үзэл бодлоо илэрхийлсэн байж таарах вэ?

Д. Оросоо: Энэ асуудал бол жагсаал, цуглаанаас өөр асуудал, тиймээс энд “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль” үйлчлэхгүй. Үзэл бодлоо илэрхийлэх олон арга байдгийн зөвхөн нэг нь тайван жагсаал цуглаан зохион байгуулах арга юм. Тэдгээр иргэд өлсгөлөн, суулт хийх аргаар үзэл бодлоо илэрхийлж байгаа хэрэг юм.

Ван Хи Ли: Энэ асуудлаар өөрийн саналаа илэрхийлье. Хэдийгээр жагсаал цуглаан хийх эрхийн тухай зохицуулсан тусгай конвенц байхгүй боловч энэхүү эрх нь ИБУТЭОУП-д заагдсан байгаа. Энэ эрхийг эдлүүлэхэд тодорхой хязгаарлалт байдаг. Үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, ёс зүй, хүн амын эрүүл мэндийг хамгаалах шаардлагын үүднээс энэхүү эрхэд хязгаарлалт тогтоож болно. Мөн тухайн орны хуулиар жагсаал цуглаан хийхийг хориглосноос бусад газарт тайван жагсаал цуглаан явуулахыг хориглох нь буруу зүйл юм. Нөгөө талаар нэгэнт тайван замаар жагсаал цуглаан явуулна гэж зарласан бол үүнд ямар нэг хязгаарлалт хийх хэрэггүй юм. Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхийг хориглосон хориглолт нь нэлээд сонирхол татахуйц юм. Хэдийгээр улс орны аюулгүй байдал, нийтийн дэг журмын үүднээс ийм хязгаарлалт тогтоох нь зүйн хэрэг ч бид энэ ярилцлагын үр дүнд зарим нэг зүйл дээр хязгаарлалт тогтоох шаардлагагүй байгааг олж харна байх гэж итгэж байна.

Талбайн хувьд төрийн ордноос тодорхой зайд жагсаал, цуглаан хийхийг хориглоод, цагдаагийн байгууллагын ажилтнууд зөвхөн тэр хэсгийг л хамгаалдаг байх нь зохистой гэж үзэж байна.

С. Цэрэндорж: Олон улсын гэрээ конвенцэд зааснаар тухайн эрхэд нэгдүгээрт, нийтийн дэг журмын асуудал, хоёрдугаарт, ард түмний эрүүл мэнд, ёсзүйн үүднээс хязгаарлалт тогтоож болно. Бусад орны практикаас харахад тухайлбал, АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр, Европын холбооны шүүхийн шийдвэрүүдээс жагсаал цуглаан хийх эрхэд тавьсан захиргааны байгууллагын хориг хязгаарлалт нь тэр бүр зохистой байж чаддаггүй нь харагдаж байдаг.

Д. Ламжав: ИБУТЭОУП-ийн энэ заалт нь Үндсэн хуулийн түвшний заалт юм. Манай хууль тогтоомжид “жагсаал цуглаан” гэдэг үг хосоороо яваад байна. Энд заасан “жагсаал” гэдэг нь цаад утгаараа социализмийн үеийн майн баяраар ч юм уу жагсдаг тэр утга санааг илэрхийлээд байгаа юм. Тэгэхлээр манай хууль тайван цуглахаасаа жагсахыг илүүтэйгээр оруулчихаад байгаа юм. Төрийн ордонд жагсаал, цуглаан хийх тухай заалт байх нь илүүц юм. Ийм заалт байвал их л ядарсан заалт байх болно. Асуудал зөвхөн Сүхбаатарын талбайтай ч холбоотой биш, аймгийн засаг даргын тамгын газруудын үүдний талбай, сумдын индэртэй ч холбоотой. Зөвхөн тухайн байгууламжаас 50 метрийн зайтай л жагсаж, цуглахыг хориглоно гэвэл болно. Аюулгүй байдлын хувьд тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулж байгаа хүн хариуцах нь зүйтэй.

Ц. Энхцэнгэл: Зөвшөөрөл өгөх механизм нь хүний эрхийг хязгаарлах нэг хүчин зүйл болдог. Үүнээс гадна зөвшөөрөл авахад тодорхой хугацаа шаарддаг. 6 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ гэсэн журам байдаг. Энэ нь цаашдаа хэд хэдэн ч хоног сунгаж болох боломжтой болдог.

Д. Чилхаажав: Нийтэд тавих нэг асуулт байна. Зөвшөөрөл өгөх тухай асуудал нь эрх чөлөөг хязгаарлаж байна. Тайван жагсаал цуглаан хийх тухайгаа мэдэгдэх нь хангалттай. Энэ талаас нь асуудалд хандаасай гэж хүсч байна.

Д. Цэнд-Аюуш: Зөвшөөрлийг болиулах нь зүйтэй гэж үзэж байна. Би таны эсрэг юм хэлье, зөвшөөрөөч гэж гуйх нь утгагүй хэрэг юм.

Ц. Ижилмөрөн: Зөвшөөрөл өгдөг авдаг байх нь ямар нэг хэмжээгээр хэрэгтэй. Машин зам сааталтай байдаг. Аваар осол гарах нь элбэг. Жагсаал, цуглааны үед нийтийн эмх замбараагүй байдал үүсэх нь элбэг байдаг. Иймээс урьдчилан сэргийлэх ёстой.

А. Нэргүй: Асуудал дэвшүүлсэн 2 зүйл байна. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг эргэж харах цаг болсон. Үүн дээр санал нэг байгаа. Ялангуяа Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын хувьд нэг талаас хүний эрхийг зөрчөөд байгаа мэт боловч нөгөө талаас нийтийн дэг журмыг хангах гэсэн хоёрдмол асуудал байнга гарч ирээд байдаг. 1989 оноос хойш манай дүүрэгт болсон жагсаал цуглааны талаар Засаг даргаас явуулсан судалгаа байдаг. Нэг хэсэг хүний эрх нөгөө нэг хэсгийн эрхээр хязгаарлагддаг гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн асуудал боловч хэн, хэзээ, ямар эрхийнхээ асуудлыг хэрхэн тавьж байгаа нь чухал асуудал юм. Үзэл бодлоо илэрхийлж байна гэдэг нэр томъёоны дотор чухам юуг ойлгох юм бэ? Хэдэн хүний асуудлыг энд авч үзэх вэ? Эхлээд нэр томъёоны асуудлаа цэгцлээд дараа нь түүний хэлбэр, агуулгыг томъёолбол ямар вэ? Бидний энэ уулзалт ярилцлага үзэл бодлоо илэрхийлэх асуудал биш зөвхөн Сүхбаатарын талбайн асуудал уруу хэтэрхий ороод байна. Урьд нь бид ийм жагсаал, цуглааныг бороохойдож тараасан гэсэн асуудалд орж байсан хэдий ч энэ үйлдлээ тодорхой хуулийн хүрээнд ажилласан гэж үзэж байгаа. Захиргааны байгууллага зөвхөн хуулийн заалтаа л хэрэгжүүлж байсан. Гэхдээ Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийх эрхийг зөвшөөрөх нь зарим нэг сөрөг үр дагавартай гэж үзэж байна. Монголчууд төрөө дээдэлдэг ард түмэн. Өлсгөлөн, суулт хийж байгаа хүмүүс тэр газар орчиндоо ялгадасаа гаргах ч юмуу, өөр янз бүрийн зүйл хийж л байгаа. Гэхдээ төрт ёсны хүндэтгэлийн арга хэмжээ болдог талбайд ийм зүйл зөвшөөрөх нь зохисгүй.

Д. Оросоо: Сүхбаатарын талбайд тайван жагсаал, цуглаан хийх хүсэл зориг, хэрэгцээ, шаардлага олон нийт, түүний тодорхой хэсэгт байна. Үүнийг цаг хугацаа, өнгөрсөн хугацаанд болсон үйл явдлууд нотолдог. Иймд Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийх асуудал, түүний эрх зүйн зохицуулалт судлаачийн хувьд анхаарал татаж байсан нь үнэн. Иргэд нийслэлийн хэмжээнд жагсаал, цуглаан хийхийг сонирхдог хоёр том бөгөөд гол талбай бий. Нэг нь Сүхбаатарын талбай нөгөө нь Эрх чөлөөний талбай юм.

С. Цэрэндорж: Бидний ярилцлага үнэхээр ярьвал зохих сэдвийг хөндөж байна. Зөвшөөрлийн асуудал дээр анхаарал хандуулъяа. Энэ зөвшөөрлийг улс төрийн албан тушаалтан өгч байх уу, эсвэл засаг дарга өгч байх уу? Одоо засаг дарга өгч байгаа. Засаг дарга бол улс төрийн албан тушаал. Сумын засаг дарга одоо хүртэл хүн баривчлах эрхтэй хэвээрээ л байгаа. Тэгэхлээр зөвшөөрөл байх уу, байвал хэн өгөх вэ гэдэг нь их чухал. Иракийн дайнд ялсныхаа дараа Ж.Буш Англид айлчилсан. Гэтэл олон нийт эсэргүүцлийн жагсаалтай угтсан. Сурвалжлагчийн “Та яагаад зөвшөөрөл өгсөн юм бэ?” гэсэн асуултанд Лондонгийн цагдаагийн дарга “Америк хэдийгээр том гүрэн, Ж. Буш “том хүн” боловч манай ард түмний үзэл бодлоо илэрхийлэх эрх нь үүнээс чухал асуудал, Ж. Бушийн айлчлал нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэл болж чадахгүй юм.” гэж тайлбарласан байдаг. Тэнд зөвшөөрлийг цагдаагийн байгууллага өгдөг юм шиг байна л даа. Ингээд та бүхнийг цайны завсарлагад урья.

Цайны завсарлага 11.35 минутаас 11.50 минут хүртэл үргэлжлэв.

С. Цэрэндорж: Уулзалт ярилцлагаа үргэлжүүлье.

Г.Халтар: Нэр томъёогоо зөв тайлбарлаж чадвал зөв зохицуулалт хийх боломжтой. Би Шведэд байхдаа жагсаал цуглаан хийх асуудал ямар зохицуулалттай байдаг талаар сонирхож байсан. Манайх шиг ийм хатуу зохицуулалтгүй юм байна лээ. Төр, цагдаа зөвхөн хөндлөнгийн ажиглагчийн үүрэг гүйцэтгэдэг. Харин нийтийн дэг журам зөрчих тохиолдолд хүч хэрэглэдэг. Жагсаал, цуглаан хийх, нийгмийн хэв журам хангах гэсэн 2 асуудлыг ялгах шаардлагатай. Тэгээд жагсаал, цуглаан хийхэд авах зөвшөөрөл, цаг хугацаа гэх мэт асуудлуудыг тус тусад нь ялгаатай авч үзэх шаардлагатай байна. Олон улсын гэрээнүүдийг баримтлан хязгаарлалтуудыг багасгах нь зүйтэй. Мөн зөвшөөрлийг хэн олгох ёстой юм бэ гэдэгт анхаарал хандуулах хэрэгтэй. Манайд энэ асуудал зохицуулалтын зөв механизмаа олоогүй байна. Хуулийг өөрийн онцлогт тохируулан гаргах ёстой. Бүхнийг гаднаас хуулах нь зохисгүй хэрэг. Монголчуудын төрөө дээдлэх үзэл сэтгэлгээг хүндэтгэх хэрэгтэй. Манай хуулинд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа. Үүнийг бид дэмжиж байна. ХЭҮК-оос ийм арга хэмжээг зохион байгуулж байгаад талархаж байна гэдгийг хэлье.

Ц.Оюунтунгалаг: Энэ асуудлаар бид төрийн байгууллага хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг хангах үүднээс хуулиа гаргах уу, эсвэл хүний эрхийг дэмжих үүднээс зохицуулалт хийх үү гэдгийг анхаарах хэрэгтэй. Одоогийн мөрдөж байгаа зөвшөөрлийн тогтолцооны хувьд цаг хугацаа алддаг, үүнтэй холбоотой зөвшөөрөлгүй жагсаал цуглаан хийх үзэгдэл байдаг. Зөвшөөрөлгүй хийж байгаа жагсаал, цуглааныг тараах нь манай мөрдөж байгаа хуулиар бол зөв хэрэг. Гэхдээ, энэ нь эрүүл, эерэг шаардлагыг хүчээр дарж унтраах боломжийг бий болгож байдаг юм. Мэдэгдлийн зөвшөөрөл гэдгийг бид хүлээн авах хэрэгтэй гэж бодож байна. Гэхдээ энэ мэдэгдэл нь жагсаалын зорилготой холбоотой хэлэлцэгдэх хэрэгтэй. Хөдөлмөрийн тухай хуулинд “Ажил хаялт зохион байгуулж байгаа үед үйлдлээ дэмжих зорилгоор жагсаал, цуглаан зохион байгуулж болно.” гэсэн заалт байдаг. Харин жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд “Аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн ажилчдаас зохион байгуулж байгаа байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой жагсаал цуглаанд энэ хууль үйлчлэхгүй” гэсэн заалт байдаг. Энэ 2 зүйл заалтын холбоо хамаарлыг харах нь зүйтэй.

Г. Жамъян: Манай улсад зохион байгуулж байгаа жагсаал цуглаан хор аюулын хувьд хамгийн аюулгүй зүйл. Үүнийг эрх мэдэлтнүүд хамгийн аюултай зүйл болгож сүржигнээд байна. Асуудлыг эв зүйгээр зохицуулах хэрэгтэй. Хуулинд оруулах 2 санал байна. Нэгдүгээрт, жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл өгдөг байдлыг больё, зөвхөн

мэдэгддэг болъё. Хоёрдугаарт, жагсаал, цуглааныг зөвхөн Сүхбаатарын талбайд хийдэг болъё. Төрийн ордноос 20 метрийн зайтай л жагсаал, цуглаан явуулдаг болъё. Засгийн газар нэг хүний саналд дэндүү хойрго хандаж байна.

Д. Ламжав: Тайван цуглааны тухай ярья. Хэрвээ зөвшөөрөл байвал, нэгдүгээрт хугацааг нь богиносгох шаардлагатай. Хугацаандаа хариу өгөөгүй бол зөвшөөрсөн гэж үзэх хэрэгтэй. Татгалзсан хариу өгөх үндэслэлийг хуульд тодорхой заах хэрэгтэй. Ийм үндэслэл нь Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцэд нийцсэн байх ёстой. Хоёрдугаарт, ямар нэг газарт жагсаал, цуглаан хийж болохгүй гэсэн заалт байх ёсгүй. Манайд төрөө дээдлэх, бөхөө дээдлэх гэсэн 2 үгийн их буруу ашигладаг. Манайхан өнөө үед төрийг иргэдэд үйлчлэх байгууллага гэдгээр нь илүү их хүлээж авдаг болсон. Тэгэхлээр, ямар нэг талбайд Монгол улсын Үндсэн хууль үйлчлэхгүй болно гэдэг нь утгагүй.

н. Шаравсанжил: Зөвшөөрлийн системийн хувьд ХЭҮК бол хүний эрхийг хөхүүлэн дэмжих байгууллагын хувьд зөвшөөрлийг танай байгууллага өөр бусад байгууллагатай, жишээлбэл, засаг даргын тамгын газартай хамтарч зөвшөөрөл өгдөг байх нь зүйтэй гэж үзэж байна.

Д. Цэнд-Аюуш: Зөвшөөрлийн механизм буруу байна. Бидний татвар төлдөг цагдаагийн байгууллага бидний эрхийг зөрчиж байна. Цагдаагийн байгууллага өөрийн нэг номерийн зорилтоо биелүүлэхгүй байна.

Ц. Бүмнанжид: Хамаагүй зөвшөөрөл өгдөггүй гэж яриад байж болохгүй. Жагсаал, цуглаан зохион байгуулахтай хамт зохицуулах өөр бусад өнчөөн асуудал байдаг. Цагдаагийн байгууллага өнөөг хүртэл хуулийн хүрээнд л ажиллаж ирсэн, ямар нэг хуулийн заалтыг зөрчиж байгаагүй. Цагдаа төрийн албадлага, үйлчилгээний гэсэн 2 чиг үүргээр ажилладаг онцгой байгууллага.

Ван Хи Ли: Та бүхний ярианд үндэслээд би өөрийн саналаа дэвшүүлье. Жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийг хэнээс авах асуудлыг тодорхой, зохистой болгох нь чухал. Түүнээс гадна тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулагчид төрөөс зохион байгуулалт шаардаж байх ёстой. Үүнээс гадна болох гэж буй үйл явдалд цагдаагийн байгууллага мэдрэмжтэй хандах чадвартай байх хэрэгтэй. Та бүхэн Монгол улс бусадтай харьцуулахад харьцангуй тайван гэж их ярьлаа. Чухам хэнтэй харьцуулахад тайван байгаа вэ гэдгийг гаргаж ирэх хэрэгтэй байна. Хүний эрхийг хамгаалах байгууллагууд бас цагдаа, хүчний байгууллага яг хэрэгтэй үед, хэрэгтэй газар зохистой шаардлага тавьсан уу гэдэгт анхаарал хандуулж, хяналт тавьж байх хэрэгтэй. Жагсаал цуглаан зохион байгуулагчид ч бас төрөл бүрийн зүйлээс, жишээлбэл, олон хүмүүсийн бөөгнөрөл гэх мэт зүйлээс хамгаалагдсан байх ёстой.

Д. Оросоо: Олон улсын эрх зүйн хүрээнд хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах асуудал бий. Өөрөөр хэлбэл, Йохансбургийн зарчимд үзэл бодлоо илэрхийлэх чөлөөтэй эрхийг улс орны аюулгүй байдлын үүднээс хязгаарлах нь зүйтэй гэсэн санаа байдаг.

С. Цэрэндорж: Ярилцлагаа өндөрлөө. Энэ удаагийн уулзалт ярилцлагад Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэц, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, ХЗДХЯ, Засаг даргын тамгын газрууд, Нийслэлийн цагдаагийн газар, МАХН, Ардчилсан нам, МҮЭ болон МЗХ зэрэг байгууллагын төлөөлөгчид оролцож, нэлээд ач холбогдолтой боллоо. Та бүхэнд баярлалаа.

Уулзалт ярилцлага 2004 оны 02 дугаар сарын 09-ны 12.45 минутанд өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Г. Нарантуяа